



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.04.30 № 37-1/67
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244001729



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.25 № Хэт/834
танай _____-ны № _____-т

**Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 1/1 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



**МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024.04.11 № 01/727

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын
тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцэж
байгаа тул Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй
гэж үзэв.



Ч.ХҮРЭЛБААТАР

240334



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.04.18 № 01/2822

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН



9761000992



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mjha.gov.mn,

Цахим хуудас: www.mjha.gov.mn

2024.04.16 № 11/1869

танай 2024.04.11 -ны № 1/729 -т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

151881359 Дос. улам а 5.2024

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР


БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД


Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.


САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД


Б.ЭНХБАЯР

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газрын санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ...” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,...Засгийн газрын...үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;” гэж заасан шаардлагыг хангана.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 4 заалт, 3 хавсралттай байх бөгөөд нэгдүгээр заалтад Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг нэгдүгээр хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ,

үнэлгээний үзүүлэлтүүдийг гуравдугаар хавсралтаар батлах тухай, хоёрдугаар заалтын нэгт Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах, хоёрдугаар заалтын хоёрт Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах, хоёрдугаар заалтын гуравт Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр нэгтгэн гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах тухай, гуравдугаар заалтад энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгах тухай, дөрөвдүгээр заалтад тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан “Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”, “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого”, “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”, “Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Улаанбаатар хотын бүсчлэл- 20 минутын хотын бодлого”, “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” гэсэн бодлогын 8 тэргүүлэх чиглэлтэй бөгөөд эдгээрийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн үр дүн болон төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, үндсэн хариуцах байгууллагыг тусгана. Түүнчлэн жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгааг тусган боловсруулна.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газар төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад тулгуурласан эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, импортын хамаарлыг багасгах замаар эдийн засгийн зардлыг бууруулж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг ил тод, үр ашигтай болгож, засаглал, институцын чадавх, суурь дэд бүтцийг сайжруулан, эдийн засгийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хөгжлийн 2025 оны
төлөвлөгөөний төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ...” гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамнаас “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулав.

Төлөвлөгөөний төсөлд салбарын яамд болон аймаг, нийслэл 2025 онд хэрэгжүүлэхээр нийт 68 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 711 төсөл, арга хэмжээний санал ирүүлсэн.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөл нь “Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”, “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого”, “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”, “Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Улаанбаатар хотын бүсчлэл- 20 минутын хотын бодлого”, “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” гэсэн бодлогын 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойлж тусгасан.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийн нэгдүгээр бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”-ын хүрээнд гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт уул уурхайн шилжилтийг хийх, боомтын сэргэлт, бүс холбосон таван тойрог замын төслүүдийг хэрэгжүүлж тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, эрчим хүчний салбарт бодлогын суурь шинэчлэл хийж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай салбар болгон хөгжүүлэх, дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх бодлого баримтална.

Хоёрдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд үндэсний орон сууцжуулах бодлогыг баялгийн сантай уялдуулан дэмжих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг эрчимжүүлэх, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөхүйц чадвартай төгсөгчдийг бэлтгэх, нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хүн амын бүлэг бүрд зориулан оновчтой

хэрэгжүүлэх, соёл, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

Гуравдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”-ын хүрээнд төрийн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглаж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгох, шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбарын хөгжлийг эрчимжүүлэх, хүний эрхийн баталгааг хангах, хараат бус, ил тод шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааг хангах бодлого баримтална.

Дөрөвдүгээр бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого”-ын хүрээнд бизнесийн салбарт төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, төрийн оролцоог хязгаарлах, бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, банк, санхүү, даатгалын салбарын реформыг хэрэгжүүлж, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална.

Тавдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Ногоон хөгжлийн бодлого”-ын хүрээнд ногоон хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих, байгаль орчны тогтвортой байдлыг хангах бодлого баримтална.

Зургаадугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хүрээнд хөрөнгө оруулалт, хөгжлийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар төлөвлөх, бүсийн ялгаатай болон шаталсан татварын эрх зүйн орчныг бүрдүүлэх, бүсүүдэд эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татваргүй чөлөөт бүсүүдийг ашиглалтад оруулах бодлого баримтална.

Долоодугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Улаанбаатар хотын бүсчлэл-20 минутын хотын бодлого”-ын хүрээнд Улаанбаатар хотын засаглалыг сайжруулж, иргэд нийгмийн үйлчилгээг төвөгшөөлгүй, өөрийн гэрээс “20 МИНУТЫН ЗАЙ”-д авах бололцоог бий болгох, түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах төслүүдийг эрчимжүүлэх бодлого баримтална.

Наймдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ын хүрээнд “Нэг цонх-Нэгдмэл гадаад бодлого”-ыг үргэлжлүүлэх, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, орчны аюулгүй байдлыг хангаж, хүн, нийгмийн амар тайван орчныг бий болгох бодлого баримтална.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	6
1.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал	6
1.2. Салбаруудын өнөөгийн нөхцөл байдал	15
1.3. Макро эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	59
ХОЁР. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2025 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА, ТӨСӨӨЛӨЛ	61
2.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	61
2.2. Макро эдийн засгийн 2025 оны төсөөлөл	62
2.3. Болзошгүй эрсдэлийн тойм	63
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	65

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Бодит ДНБ-ий өсөлт	7
Зураг 2. Төсвийн орлого, зарлага, тэнцэл.....	9
Зураг 3. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)	10
Зураг 4. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь)	11
Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь).....	11
Зураг 6. Хөдөлмөрийн үзүүлэлт.....	12
Зураг 7. Гадаад худалдааны үзүүлэлт	15
Зураг 8. Хураан авсан ургац (мянган тонн).....	16
Зураг 9. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт (сая толгой мал).....	20
Зураг 10. Тээсэн ачаа (сая тонн)	22
Зураг 11. Нийт зорчигч (сая хүн).....	22
Зураг 12. Тээврийн салбарын орлого (тэрбум төгрөг).....	23
Зураг 13. Цахилгаан эрчим хүчний дамжуулалт түгээлтийн алдагдал	25
Зураг 14. Дулааны шугамаар алдагдах дулаан	26
Зураг 15. Барилга угсралт, их засварын ажил (тэрбум төгрөг).....	26
Зураг 16. Барилгын салбарын ажиллах хүч (мянган хүн, жил бүрийн 3 дугаар улирлаар)	27
Зураг 17. Барилгын салбарын ажилчдын сарын дундаж цалин (мянган төгрөг)	28
Зураг 18. Орон сууцны төрөл (нийт өрхөд эзлэх хувиар).....	28
Зураг 19. Жуулчдын тоо (салбарын орлого)	29
Зураг 20. Жуулчид (улсаар, хувиар).....	29
Зураг 21. Бие бялдрын түвшин тогтоох сорил	32
Зураг 22. Сургуулийн өмнөх боловсролын бүлэг дүүргэлт (хүүхдийн тоогоор).....	34
Зураг 23. 5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин (хувиар, аймгаар)	34
Зураг 24. Хамран сургалтын цэвэр жин (ангиар).....	36
Зураг 25. Их, дээд сургууль, коллежийн тоо	37
Зураг 26. Нийт суралцагчдын тоо, мэргэжлийн ерөнхий чиглэлээр.....	37
Зураг 27. Хүн амын өсөлт (сая хүн, хувь).....	41
Зураг 28. Хүн ам зүйн ачаалал, (100 хүнд ногдох хөдөлмөрийн бус насны хүн ам (15-аас доош насны болон 65-аас дээш насны хүн ам).....	41
Зураг 29. Хүн амын нас, хүйсийн суварга	41
Зураг 30. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг).....	43
Зураг 31. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн өсөлт	43
Зураг 32. Нийгмийн даатгалын хамрагдалт (мянган хүн).....	44
Зураг 33. Ажиллагчдын сарын дундаж, медиан цалин болон бодит цалингийн индекс (мянган төгрөг)	44
Зураг 34. Ядуурлын түвшин	45
Зураг 35. Жини коэффициент	45
Зураг 36. Хөдөлмөрийн дутуу ашиглалт (мянган хүн)	46
Зураг 37. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр.....	47
Зураг 38. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл.....	61

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсвийн зарим үзүүлэлт, (тэрбум төгрөг)	10
Хүснэгт 2. Хөнгөн үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний худалдаа (сая ам.доллар).....	18
Хүснэгт 3. Эрдэс бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ	20
Хүснэгт 4. Цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, эх үүсгүүрээр (МВт, эзлэх хувь)	25
Хүснэгт 5. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд	30
Хүснэгт 6. Цэцэрлэг, өмчийн хэлбэр, байршлаар.....	33
Хүснэгт 7. Зорилтот бүлгийн хүүхдийн хамрагдалт (тоогоор)	34
Хүснэгт 8. Ерөнхий боловсролын сургууль, суралцагчид	35
Хүснэгт 9. Их, дээд сургууль, коллежид суралцагчид	37
Хүснэгт 10. Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид	38
Хүснэгт 11. Эхний 10-т жагссан сургуулийн үндсэн мэдээлэл.....	38
Хүснэгт 12. Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөц	39
Хүснэгт 13. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, төрлөөр.....	42
Хүснэгт 14. Нийгмийн даатгалын орлого, зарлага, 2019-2023 он (мянган хүн, тэрбум төгрөг)	43
Хүснэгт 15. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд.....	45
Хүснэгт 16. Ойн нөхөн сэргээх ажил.....	50
Хүснэгт 17. Цөлжилтийн үйл явцын хандлага (хувь)	50
Хүснэгт 18. Улс орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	61

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Нэрлэсэн ДНБ 2023 онд урьдчилсан гүйцэтгэлээр 68.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 27.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.0 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлэв.

Үйлдвэрлэл талаас уул уурхай болон тээврийн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ. БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлого, хилийн хязгаарлалт, тээвэр, логистикийн саатлаас үүдэн 2022 онд 15.3 хувиар агшсан уул уурхайн салбар нүүрс, газрын тос олборлолт болон зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэний нөлөөгөөр 2023 онд 23.4 хувиар тэллээ. Тухайлбал, нүүрс олборлолт 2023 онд 81.2 сая тоннд хүрч, өмнөх оноос 2.2 дахин, цар тахлын өмнөх үе буюу 2019 оноос 1.6 дахин нэмэгдээд байна. Оюутолгойн гүний уурхайн үйлдвэрлэл 2023 оны 3 дугаар сард эхэлснээр зэсийн баяжмал үйлдвэрлэл 1,395 мянган тоннд хүрч, өмнөх оноос 17 хувиар өсжээ. Түүнчлэн, 2022 оны эхний хагаст хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас үүдэн зогсоод байсан газрын тос олборлолт сэргэж, 4.9 сая баррельд хүрч, өмнөх оноос 1.9 дахин нэмэгдсэн байна. Харин алт олборлолт 14.9 тоннд, төмрийн хүдрийн олборлолт 7.6 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс тус тус 23 болон 19 хувиар буурсан бөгөөд 2019 оны түвшинд хүрээгүй хэвээр байна. Тээврийн салбарын хувьд, экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт сайн байж, тээвэр зохион байгуулалт сайжирснаар 39.3 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлэв. Авто болон төмөр замаар тээсэн ачаа, мөн дамжин өнгөрөх ачаа тээвэр нэмэгдсэн нь тээврийн салбарын сэргэлтэд нөлөөллөө.

Өрхийн хэрэглээ сэргэж, аялал жуулчлал, дотоодын эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр худалдаа, үйлчилгээний салбарууд өслөө. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбар 2023 онд 5.7 хувиар тэлсэн байна. Үйлчилгээний бусад салбаруудын хувьд, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, зочид буудал, нийтийн хоол, шинжлэх ухааны үйл ажиллагаа, урлаг, үзвэрийн үйлчилгээний салбарууд өсөлттэй байлаа. Мэдээлэл, холбооны салбар дах хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр орон нутаг дах суурин интернэт хэрэглэгчийн тоо өсөж, харилцаа холбооны салбар өмнөх оноос 16.4 хувиар тэллээ.

Мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын өсөлтийг хадгаллаа. Засгийн газар 2023 оны 2 дугаар сард махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалснаар боловсруулсан махны биет хэмжээ болон экспорт өссөнөөр боловсруулах салбар өмнөх оноос 5.1 хувиар тэлж, нийт өсөлтийн 0.4 нэгж хувийг бүрдүүлэв.

Ковид-19 цар тахал, ОХУ-Украины дайны нөлөөгөөр тасалдсан барилгын материалын нийлүүлэлтийн сөрөг шокоос үүдэлтэй барилгын өртөг болон үнийн өсөлт үргэлжилсэн нь барилгын салбарын өсөлтийг удаашрууллаа. 2023 онд барилгын салбар өмнөх оноос 0.6 хувиар өсөхөд орон сууцны бус барилгын өсөлт гол нөлөө үзүүлсэн бол инженер, орон сууцны барилга өсөлтийг хязгаарлалаа. Орон сууцны бус барилгын өсөлтөд худалдаа, үйлчилгээ, эмнэлэг, сургууль, соёлын барилгын бүтээн байгуулалт голлон нөлөөлөв. Харин 2022 оны төмөр зам, автозамын томоохон бүтээн байгуулалтын суурийн нөлөөгөөр инженерийн барилга, байгууламж 2023 онд өмнөх оноос буурлаа. Мөн орон сууцны үнэ, барилгын материалын үнийн өртгийн өсөлтөөс шалтгаалан ашиглалтад орсон орон сууцны барилга өмнөх оноос 4 хувиар буурч барилгын салбарын өсөлтийг

саарууллаа. Орон сууцны үнийн өсөлтийг даган үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах шилжүүлэх үйл ажиллагааны идэвхжил суларлаа.

Өвөлжилт хүндэрч 2023 оны 12 сарын байдлаар нийт нутгийн 90 хувьд зудын эрсдэл өндөр байснаас хөдөө аж ахуйн салбарын 90 гаруй хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл буурч, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Оны эхнээс өвөлжилт, хаваржилт хүндэрснээс шалтгаалан 2023 онд төл бойжилт 28 хувиар буурч, малын хорогдол өмнөх оноос 6.4 дахин (2010 оноос хойших хамгийн өндөр хорогдол) нэмэгдсэнээр мал аж ахуйн салбар 10.3 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 1.4 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв. Харин газар тариалангийн салбарын үйлдвэрлэл өмнөх оноос 8 хувиар өсөж, өсөлтөд эергээр нөлөөлсөн байна.


Цахилгаан дулаан, усан хангамжийн салбаруудын үйлдвэрлэл хэвийн байж, цэвэр татварын орлого нэмэгдсэнээр өсөлтийг дэмжив.

Зураг 1. Бодит ДНБ-ий өсөлт

1. Эдийн засгийн өсөлтийн бүтэц (нэгж хувь)

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
ДНБ	5.6	-4.6	1.6	5.0	7.0
ХАА	0.7	0.8	-0.8	1.7	-1.3
Үйлдвэрлэл	0.9	-1.3	-0.6	-1.2	3.1
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-2.1	2.6
Боловсруулах	0.3	0.3	-0.1	0.5	0.4
Цахилгаан, ус	0.1	0.0	0.2	0.1	0.1
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2	0.0
Үйлчилгээ	2.9	-3.0	1.8	3.2	4.3
Худалдаа	1.2	-1.4	0.6	1.1	0.7
Тээвэр, агуулах	0.2	-1.0	-0.3	0.4	1.8
Үйлчилгээний бусад	1.5	-0.6	1.5	1.7	1.9
Цэвэр татвар	1.0	-1.1	1.3	1.4	0.9

2. Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо (нэгж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Тэмдэглэл: Салбаруудын өсөлтөд оруулах хувь нэмрийг харуулав

Эрэлт: Эрэлт талаас нүүрсний экспортын өсөлт гадаад тэнцвэрийг сайжруулсан бол инфляц, ханшийн тогтворжилт иргэдийн амьжиргаанд ирэх дарамтыг бууруулж, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг оны сүүлийн хагаст нэмэгдүүлснээр өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн идэвхжилийг дэмжлээ. Эрэлт тогтвортой байхын зэрэгцээ үйлдвэрлэгчийн зардал бууран, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн үйлдвэрлэлийн зөрүү аажмаар хумигдаж байна.

Гадаад эрэлт сайн байж, өсөлтийг тэтгэлээ. БНХАУ-ын хойд бүс нутгийн эдийн засаг харьцангуй өндрөөр өссөн нь манай улсын нүүрсний эрэлтийг дэмжиж, нүүрсний экспорт 2023 онд 70 сая тоннд хүрч төсөөллөөс даван бараа, үйлчилгээний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 42.9 хувиар өсөж, төсөвт төвлөрүүлсэн уул уурхайн салбарын орлого 1.5 дахин нэмэгдэн, бараа, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал бодит дүнгээр өнгөрсөн оноос 16.6 хувиар бууран гадаад эрэлтийн төлөв сайн байв. Нийт эдийн засгийн өсөлтөд цэвэр экспорт 5.2, өрхийн хэрэглээ 4.8, төрийн хэрэглээ 1.3, үндсэн хөрөнгийн хуримтлал 2.3 нэгж хувийн тус тус эерэг нөлөө үзүүлсэн байна.

Өрхийн бодит орлогын өсөлт дотоод эрэлтийг идэвхжүүлж, өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ. Төгрөгийн ханш 2022 оны эхний хагаст суларснаар иргэдийн

бодит орлого 2022 оны эцэст 0.7 хувиар, 2023 оны эхний улиралд 3.9 хувиар тус тус буураад байв. Төгрөгийн ханш 2023 оны сүүлийн хагаст тогтворжин аажмаар чангарч, мөн инфляцын өсөлт саарсны зэрэгцээ Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамжийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлснээр өрхийн хэрэглээнд ирэх дарамт буурч, өрхийн бодит орлого өнгөрсөн оны эцсээс 14.1 хувиар сайжирсан. Үр дүнд өрхийн хэрэглээ өмнөх оноос 7.4 хувиар тэлж, дотоод эрэлтийг нэмэгдүүллээ. Өрхийн бодит орлогын өсөлтөд нэрлэсэн дүнгээр цалин дунджаар 270.8 мянган төгрөгөөр буюу 27.8 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 61.2 мянган төгрөгөөр буюу 13.9 хувиар, мал аж ахуйгаас орох орлого 56.3 мянган төгрөгөөр буюу 49.8 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлээ.

Иргэдийн зээлийн өсөлт өрхүүд хэрэглээгээ нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Зээлийн үйлчилгээ сайжирч, хялбар болсны зэрэгцээ арилжааны банкнууд богино хугацаатай, эрсдэл багатай зээлийг түлхүү олгох хандлагатай байснаар иргэдэд шинээр олгосон зээл 22.1 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 6.3 их наяд төгрөгөөр буюу даруй 40.2 хувиар өссөн байна. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн дийлэнх буюу 13.2 их наяд төгрөг нь хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл байна.

Эдийн засаг дахь үндсэн хөрөнгийн хуримтлал нэмэгдэв. Уул уурхай дагасан бүтээн байгуулалтын өсөлт эерэг нөлөө үзүүлж, үндсэн хөрөнгийн хуримтлал 2023 онд 7.0 хувиар өслөө. Тухайлбал, орон сууцны бус барилга байгууламж 18.2 хувиар өссөн бол уул уурхайн хүнд машин, техник хэрэгслийн импорт нэлээдгүй нэмэгдсэнээр машин тоног төхөөрөмжийн хуримтлал 6.5 хувиар өссөн байна. Түүнчлэн 3,000 см³-ээс их моторын багтаамжтай суудлын автомашины импорт 73.5 сая ам.доллараар, нийтийн тээврийн хэрэгслийн импорт 39.4 сая ам.доллараар өссөн нь мөн нөлөөлсөн байна. Харин өвөлжилт хүнд байсны улмаас том малын зүй бус хорогдол 4.9 сая толгойд хүрч, өмнөх оноос даруй 7.4 дахин нэмэгдэн том малын тоо толгой буурсан байна. Эх үүсвэр талаас арилжааны банкнуудын шинээр олгосон зээлийн хэмжээ 2023 онд 41.8 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс 19.7 их наяд төгрөгийг аж ахуй нэгж байгууллагуудад олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 26 хувиар өссөн байна. Төсвийн хөрөнгө оруулалт 2023 онд 5.2 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 35.7 хувиар өссөн бол гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 1,570 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 37.3 хувиар буурсан байна.

Үйлдвэрлэлийн орцын үнэ буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, бизнесийн санхүүжилт сайжирсан нь үйлдвэрлэлийн гарцад эергээр нөлөөллөө. 2023 оны эцсийн байдлаар төгрөгийн ханш өмнөх оны эцсээс 34 төгрөгөөр чангарснаас гадна импортын түүхий эдийн үнэ болон үйлдвэрлэгчийн зардал буурч, ажиллагчдын тоо 2023 оны 2 дугаар улирлаас эхлэн алгуур нэмэгдэж, 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буюу 38.6 мянгаар өссөнөөр нийт үйлдвэрлэл өмнөх оноос 7 хувиар өсөв. Мөн 6 улирал дараалан сөрөг утгатай байсан бодит хүү 2023 оны сүүлийн улиралд эерэг болсон нь арилжааны банкны зээлийн нийлүүлэлтийг дэмжих эерэг хандлага ажиглагдаж эхэллээ.


Төсөө: Уул уурхайн салбарын сэргэлт болон түүнийг дагасан тээвэр, үйлчилгээний салбарын өсөлтийн нөлөөгөөр төсвийн орлого төлөвлөгөөнөөс 6 хувиар давж, төсвийн тэнцэл сүүлийн 5 жилийн хугацаанд анх удаа ашигтай гарлаа. Үндсэн тэнцэл ашигтай гарч, төсвийн бодлого нийт эрэлтийг бууруулах, инфляцыг хязгаарлах хүрээнд мөнгөний бодлоготой уялдаатай байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас хугацаа тулаад байсан бондын эргэн төлөлтийг хийж, өрийн

удирдлагыг амжилттай хэрэгжүүллээ. Дунд хугацаанд Засгийн газрын өрийн төлөв тогтвортой хадгалагдах хүлээлттэй байна.

Төсвийн тэнцэл сүүлийн 5 жилд анх удаа ашигтай гарлаа. Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдал зэрэг гадаад гэнэтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засагт томоохон эрсдэл учирч, улсын нэгдсэн төсөв 2020 онд 4.5 их наяд төгрөг, 2021 онд 2.9 их наяд төгрөг, 2022 онд 0.9 их наяд төгрөгийн тус тус алдагдалтай гарсан. Эдгээр хүнд сорилтын цаг үед Засгийн газраас эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэх, уул уурхайн далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2023 онд улсын төсвийн нийт орлого 24.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 31 хувиар өссөн. Улмаар төсвийн нийт тэнцэл 1.9 их наяд төгрөгийн, тэнцвэржүүлсэн тэнцэл 763 тэрбум төгрөгийн тус тус ашигтай гарлаа.

Уул уурхайн салбар төсвийн орлогын өсөлтийг дэмжлээ. Тайлант онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, Оюу толгойн далд уурхай ашиглалтад орж, зэсийн баяжмалын экспорт нэмэгдсэн. АМНАТ-ийг оновчтой бүрдүүлэх, олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим бүртгэл хийж, татварын тооцоолол, тайлагналыг хялбаршуулж автоматжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оноос 2.7 их наяд төгрөг буюу 51 хувиар, АМНАТ өмнөх оноос 1.2 их наяд төгрөг буюу 43 хувиар, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 1.6 их наяд төгрөг буюу 78 хувиар өссөн нь төсвийн орлого өсөхөд голлон нөлөөллөө. Түүнчлэн бүтээгдэхүүний цэвэр татварууд өмнөх оноос 971 тэрбум төгрөг буюу 16 хувиар өсжээ. Бүтцээр нь харвал, дотоодын эдийн засаг идэвхжиж, уул уурхайн бүтээгдэхүүний гарц өндөр байсны нөлөөгөөр НӨАТ-ын орлого 22 хувиар, гадаад үйл ажиллагааны орлого 13 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин импортын дизель түлшний онцгой албан татварыг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл чөлөөлсөн¹ шийдвэртэй холбоотойгоор онцгой албан татварын орлого 7 хувиар буурсан байна.

Зураг 2. Төсвийн орлого, зарлага, тэнцэл



Эх сурвалж: Сангийн яам

Иргэдийн орлогыг хамгаалах төсвийн бодлого хэрэгжсэн. Гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц 10 хувиас дээш түвшинд хүрч, иргэдийн бодит орлогод сөргөөр нөлөөлсөн. Улмаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр цалингийн суурь итгэлцүүрийг шинэчилж, тэтгэврийн зөрүүг арилгаж,

¹ Засгийн газрын "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах арга хэмжээний тухай" 2022 оны 161 дүгээр тогтоол

нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, төрийн албаны цалингийн тогтолцоог 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосон. Үүний үр дүнд цалин хөлсний зардал 2023 онд өмнөх оноос 665 тэрбум төгрөг буюу 40 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 971 тэрбум төгрөг буюу 16 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Төсвийн зарим үзүүлэлт, (тэрбум төгрөг)

Төсвийн үзүүлэлт	Гүйцэтгэл				Өөрчлөлт 2023/2022	
	2021	2022	2023 Төлөөлөгөө	Гүйц.	₮	%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	4,620	6,078	7,408	7,049	971	16%
НӨАТ	2,838	3,919	4,772	4,773	854	22%
Гадаад үйл ажиллагааны орлого	939	1,292	1,644	1,464	172	13%
Онцгой албан татвар	827	848	972	790	-58	-7%
Тусгай зориулалтын орлого	17	19	20	22	3	16%
Тэтгэвэр, тэтгэмжийн зардал	4,484	5,392	6,339	6,122	730	14%
Нийгмийн даатгал	2,627	3,382	4,106	3,990	608	18%
Нийгмийн халамж	520	522	699	612	90	17%
Хүүхдийн мөнгө	1,337	1,488	1,534	1,520	32	2%
Хөрөнгийн зардал	2,982	3,813	6,218	5,175	1,362	36%

Эх сурвалж: Сангийн яам


Засгийн газрын нийт өрийн хэмжээ буурлаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 30.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.7 хувиар буурсан байна. Тус бууралтад Засгийн газрын дотоод өр, өрийн баталгаа харгалзан 801 тэрбум, 1,065 тэрбум төгрөгөөр буурсан нь эерэг нөлөө үзүүлсэн бол Засгийн газрын гадаад өр 678 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь сөрөг нөлөө үзүүллээ. Засгийн газрын гадаад өрийн өсөлтийн задаргааг харвал, үнэт цаас буюу бондын хэмжээ харьцангуй тогтвортой байсан ч гадаад зээлийн өсөлт нийт гадаад өрийг нэмэгдүүлэх суурь шалтгаан болсон байна.

Инфляц: 2024 оны 2 дугаар сард 7.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.2 нэгж хувиар буурав. Нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт тогтворжиж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш жилийн өмнөх түвшнээс чангарч, гадаад үнэ болон тээврийн зардлын өсөлт саарч, макро эдийн засгийг тогтворжуулахад хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд инфляц буурсан хандлагатай байна.

Импортын барааны үнийн өсөлт 2022 оны 6 дугаар сараас хойш алгуур буурч, инфляцын дарамтыг бууруулж байна. Худалдааны түнш орнуудын инфляц саарч, худалдааны эргэлт сайжрахын зэрэгцээ тээврийн зардлын өсөлт саарч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байсан нь импортын барааны үнийн өсөлтийг сааруулахад голлон нөлөөлжээ. Үүний үр дүнд 2023 оны 2 дугаар сард 12 хувь байсан импортын инфляц 2024 оны 2 дугаар сард 4.8 хувь болж, 7.2 нэгж хувиар буурчээ.

Дотоодын голлох хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр хэвээр байгаа нь инфляцад сөргөөр нөлөөлж байна. Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үнэ нийлүүлэлтийн шалтгаанаас үүдэлтэйгээр эрчтэй өслөө.

Зураг 3. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тухайлбал, мах, гурил зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлт буурч, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөг нэмэгдсэнээр хүнсний бүлгийн үнэ 2024 оны 2 дугаар сард 10.3 хувиар өссөн байна. 2024 оны 2 дугаар сард мах, махан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар, гурил болон бусад төстэй бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар тус тус өссөн нь нийт инфляцын 27 хувийг бүрдүүллээ.

Төсөв, мөнгөний хатуу бодлого инфляцыг хязгаарлах чиглэлд уялдаатай байна. Төв банк 2022 онд мөнгөний бодлогын хүүг 5 удаа, нийт 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол 2023 онд бодлогын хүүг 13 хувьд хадгалсан. 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн мөнгөний бодлогын мэдэгдлээр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12 хувь болгох шийдвэр гаргасан байна. Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2023 онд 1.9 их наяд төгрөгийн ашигтай гарсан нь төсвийн бодлого инфляцыг хязгаарлах чиглэлтэй нийцтэй байгааг харуулж байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү 16.97 хувь болж, өмнөх жилээс 0.9 нэгж хувиар өссөн ч шинээр олгосон зээлийн хэмжээ өссөөр байна.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд актив талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого нэмэгдсэнээр арилжааны банкнуудын гадаад цэвэр актив нэмэгдсэн, дотоод зээл олголт өссөн нь нөлөөллөө. Эх үүсвэр талаас төгрөгийн өгөөж нэмэгдсэнээр төгрөгийн хадгаламж болон харилцах өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд нөлөөллөө. Арилжааны банкнуудын зээл олголт нэмэгдсэнтэй холбоотойгоор банкны салбарын зээлийн үлдэгдэл өсөж, 2023 оны эцсийн байдлаар 27.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 23.4 хувиар өслөө. Нийт зээлийн үлдэгдлийн өсөлтийн хамгийн өндөр буюу 4.8 нэгж хувийг хэрэглээний зээл, 3.1 нэгж хувийг худалдааны салбарын зээл, 2.3 нэгж хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 4. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь)



Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь)



Эх сурвалж: Монголбанкны статистик, Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоолол
Тэмдэглэл: Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг актив, пассив талын бүрэлдэхүүн доторх хувь нэмрээр харуулав.

Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өсөж, 55.4 хувьд, ажилчид 38.6 мянган хүнээр нэмэгдэж, 1,196 мянган хүнд тус тус хүрлээ. Гэсэн ч ажилчдын тооны өсөлтийн хурд цар тахлын өмнөх үеэс 4 дахин бага байна. Салбараар авч үзвэл, худалдаа, боловсруулах, тээвэр, үйлчилгээ, уул уурхай, эрчим хүчний салбарт ажилчдын тоо өссөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарт сүүлийн 2 жил дараалан

зудын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор тайлант улиралд ажиллагчдын тоо 30 мянган хүнээр буурч, 261 мянган хүнд хүрлээ.

Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурч, 3.9 хувьд хүрлээ. Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 16 мянгаар, цар тахлын өмнөх түвшнээс 2.2 дахин буюу 56 мянгаар тус тус буурч, 49 мянгад хүрлээ. Ажилгүй иргэдийн тоог бүтцээр нь задлан авч үзвэл, бүтцийн ажилгүйдэл 0.5 мянгаар нэмэгдсэн бол түр зуурын ажилгүйдэл 14 мянгаар, мөчлөгийн ажилгүйдэл 2.5 мянгаар тус тус буурсан байна. Эдийн засаг сэргэж, идэвхжиж байгаатай холбоотойгоор мөчлөгийн болон түр зуурын ажилгүйдэл буурчээ.


Ажиллах хүчний 8 хувийг, ажилчдын 7 хувийг, ажиллах хүчнээс гадуурх хүн амын 32 хувийг залуучууд буюу 15-24 насны иргэд бүрдүүлж байна. Ажиллагчдын тоог насны бүтцээр задлан харвал, тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 25-54 насны ажилчдын тоо 29 мянгаар, 55-аас дээш насны ажилчдын тоо 18 мянган хүнээр тус тус нэмэгдсэн бол 15-24 насны ажилчдын тоо 8 мянгаар буурсан байна. Мөн 15-24 насны иргэдийн ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1 хувиар нэмэгдэж, 10.4 хувд хүрсэн бөгөөд бусад насны бүлгүүдээс өндөр байна.

Тайлант улиралд өмнөх оны мөн үеэс ажиллах хүчнээс гадуурх хүн ам 28 мянгаар, цар тахлын өмнөх үеэс 66 мянгаар тус тус нэмэгдэж, 916 мянгад хүрлээ. Шалтгаанаар ялган харвал, түр зуурын буюу цалин бага учраас, ажиллах сонирхол бага байгаа, улирлын чанартай ажил хийдэг иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 9 мянгаар нэмэгдсэн бол тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг урт хугацаанд ажиллах хүчнээс гадуур байх иргэдийн тоо 19 мянгаар нэмэгдлээ.

Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 28 хувиар өсөж, 2,009 мянган төгрөгт хүрлээ. Салбараар задлан харвал хөдөө аж ахуй, уул уурхай, тээврийн салбарын дундаж цалин бусад салбараас илүү буюу өмнөх оны мөн үеэс 32 хувь, 27 хувь, 27 хувиар тус тус өссөн байна. Уул уурхай, тээврийн салбарын хувьд салбарын үйлдвэрлэл сэргэж, бүтээмжийн өсөлтийн нөлөөгөөр цалин өссөн бол хөдөө аж ахуйн салбарын хувьд хөдөлмөрийн нийлүүлэлт буурснаас дундаж цалин өссөн байх магадлалтай байна.

Зураг 6. Хөдөлмөрийн үзүүлэлт

1. Ажилчдын тоо, түүний өөрчлөлт



2. Ажилчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо
Тэмдэглэл: Өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулав.

Гадаад худалдаа: Монгол Улс 2023 онд дэлхийн 160 улстай худалдаа хийлээ. Өнгөрсөн 2023 онд экспортын барааны урсгал нэмэгдэж, импортын барааны үнийн

өсөлтийн дарамт бага байснаар гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оноос 23 хувиар өсөж, 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт өмнөх оноос 17 хувиар өсөж, 15.2 тэрбум ам.долларт хүрсэн бол импорт өмнөх оноос 6 хувиар өсөж, 9.3 тэрбум ам.долларт хүрэв.

Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд хүрлээ. Макро эдийн засгийн 2023 оны бодлогын тэргүүлэх чиглэлд экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэж нэмэгдүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд Засгийн газраас гадаад валютын улсын нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, компанийн үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн. Мөн хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтэрсэн зэрэг хүчин зүйлсийн үр дүнд экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд амжилттай хүрлээ.

БНХАУ-ын коксжих төрлийн нүүрсний импорт түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Цар тахлын дараа БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт нэмэгдэж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн коксжих төрлийн нүүрсний импортын татварыг тэглэх шийдвэр гаргаж, тус шийдвэрийг 2023 оныг дуустал сунгасан. Мөн коксжих нүүрсний ханган нийлүүлэгч орныг төрөлжүүлэх бодлого хэрэгжүүлсэн. Эдгээр шийдвэрүүд нь бусад өрсөлдөгч орнуудтай харьцуулахад үнийн хувьд өрсөлдөх чадвар өндөртэй манай улсын коксжих нүүрсний эрэлтийг нэмэгдүүлснээр Монгол Улс 2023 онд 70 сая тонн нүүрс экспортоллоо.

Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалж эхэлснээр нүүрсний үнэ 40 хүртэл хувиар өслөө. Түүхий эдийг нээлттэй, ил тод, зах зээлийн үнээр борлуулах хүрээнд 2023 оны 1 дүгээр сард цахим арилжааг эхлүүлж, нийт 3.1 сая тонн нүүрсийг дуудах үнээс дунджаар 5.6 хувиар өндөр үнээр борлуулсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжиж эхэлсэн. 2023 оны байдлаар 15 сая тонн нүүрсийг дуудах үнээс дунджаар 10 хувиар, 677 мянган тонн төмрийн хүдэр баяжмалыг дуудах үнээс дунджаар 7 хувиар нэмэгдүүлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржээр борлуулаад байна. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалснаар уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр худалддаг, тээврийг худалдан авагч тал хариуцдаг гэх мэт үр ашиг багатай асуудлууд засагдлаа.

Оюу толгойн далд уурхай ашиглалтад орлоо. Оюу толгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувь газрын гүнд оршдог. Ил уурхайтай харьцуулахад эрдсийн өндөр агуулгатай гүний уурхай ашиглалтад орсонтой холбоотойгоор 2023 онд зэсийн баяжмалын экспорт 1,525 мянган тоннд хүрч, 2016 оноос хойших дээд хэмжээнд хүрлээ. Цаашид далд уурхайн олборлолтын нөлөөгөөр зэсийн баяжмалын экспорт нэмэгдэж, манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн болохоор байна.

Хилийн боомтуудын үйл ажиллагаа тогтворжлоо. 2022 оны эхний хагас жилд цар тахлаас шалтгаалан Дорнод аймаг дахь хилийн боомтуудын үйл ажиллагаа хаагдаж, газрын тосны экспорт зогсоод байсан. 2023 он гарснаар хилийн боомтуудын үйл ажиллагаа тогтворжиж, газрын тосны экспорт 2023 онд 4.7 сая баррельд хүрч, өмнөх оноос 2 дахин өслөө. Мөн төмөр замын зохион байгуулалт сайжирч, төмрийн хүдрийн экспорт 5.6 сая тоннд хүрч нэмэгдлээ.

Малын махны экспорт түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Макро эдийн засгийн 2023 оны бодлогын тэргүүлэх чиглэлд махны экспортыг нэмэгдүүлэх, хувийн хэвшил бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр тусгасан. Энэ хүрээнд Засгийн газраас малын махны экспортод тавих хязгаарлалтыг цуцалж "Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-ийг нэвтрүүлснээр экспортлох үйл ажиллагаа хялбаршиж, 2023 онд махны экспорт түүхэн дээд хэмжээнд буюу 309 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 6.0 дахин нэмэгдээд байна.

Дэлхийн улс орнууд бодлогын хүүг нэмэгдүүлэх замаар үнийн өсөлтийг хязгаарлаж, төгрөгийн ханш тогтворжиж, оны сүүлийн хагаст чангарснаар импортын барааны үнийн дарамт бага байлаа. Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдлаас үүдэлтэйгээр худалдааны түнш орнуудын бүтээгдэхүүний үнийн өсөлт эрчимжиж, 2022 онд импортын барааны зардлыг нэмэгдүүлснээр импорт 1.9 тэрбум ам.доллараар өссөний 54 хувийг үнийн өсөлт бүрдүүлж байсан. Харин 2023 онд импорт 500 сая ам.доллараар өссөний 5 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлж байна. Худалдааны гол түнш болох БНХАУ-д үнийн бууралт явагдаж, ОХУ-Украины геополитикийн тогтворгүй байдлаас үүдэн үнийн өсөлт эрчимтэй явагдсан нефтийн бүтээгдэхүүн, бордоо, үр тарианы үнэ тогтворжиж, буурсан нь импортын үнийн дарамтыг бага байхад голлох нөлөөг үзүүллээ. Мөн манай улсын гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтворжиж чангарсан нь импортын зардлыг буурууллаа.


Тээвэрлэлтийн саатлаас үүдэлтэй хилийн орчимд үүсэн бараа бүтээгдэхүүний бөөгнөрөл арилж, импортын барааны урсгал хэвийн үргэлжилж байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд хилийн боомтуудын үйл ажиллагаа түр саатаж, БНХАУ-ын Тяньжин боомтод чингэлгийн бөөгнөрөл үүсэж, бараа татах төмөр замын хүчин чадал бага байснаас шалтгаалан барааны урсгал 3 сар хүртэлх хугацаагаар саатаж байсан бол 2023 онд хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн үргэлжиллээ.

Уул уурхай, тээвэр, боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлтийг дагаж тоног төхөөрөмж, машин механизм, дизелийн түлшний импорт өндөр байлаа. 2023 онд импорт өмнөх оноос 6 хувиар өссөний 5 орчим нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай бараа буюу тоног төхөөрөмж, машин механизм, барилгын материалын импорт бүрдүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлснөөр тус барааны импорт 2023 онд 255 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 55.8 хувь өслөө. Тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, цаашид дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр байна. Оны сүүлийн саруудад нүүрсний экспорт саарах хандлагатай байдаг ч 2023 онд гадаад эрэлт сайн байгаагаас шалтгаалж оны сүүлийн саруудад нүүрс тээвэрлэлт өндөр байснаар дизелийн түлшний эрэлт нэмэгдэж, дизелийн түлшний импорт 1,090 мянган тоннд хүрч 39.0 хувиар өслөө. Мөн эрчим хүчний тасралтгүй байдлыг хангах үүднээс цахилгаан, дулааны станцуудын өргөтгөлийн ажлыг эхлүүлж, 80МВт суурилагдсан хүчин чадалтай хуримтлуурын байгууламжийг суурилуулснаар цахилгаан тоног төхөөрөмжийн импорт 2023 онд 340 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 46.8 хувиар өслөө. Мөн 2023 онд нийтийн тээврийн парк шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлснээр 10-аас дээш хүн тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслийн импорт өслөө.

Хүнсний бүтээгдэхүүний импорт буурлаа. Эдийн засгийн идэвхжиж, өрхийн бодит орлого, зарлага оны сүүлийн хагаст өссөнөөр 2023 оны хүнсний бус хэрэглээний бүтээгдэхүүний импорт, тэр дундаа суудлын автомашины импорт өндөр байлаа. Харин согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан

согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж, согтууруулах ундааны онцгой албан татвар нэмэгдсэнээр импорт буурсан нь хүнсний бүтээгдэхүүний импорт буурахад голлох нөлөөлөө.

Зураг 7. Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар
Тэмдэглэл: Импортын бараа бүтээгдэхүүнийг хэрэглээний зориулалтаар ялган ангилсан.

Төлбөрийн тэнцэл: Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээнүүдийн үр дүнд 2023 онд нүүрсний экспортын нэмэгдсэнээр 2022 оны эцэст 0.7 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын улсын нөөц 2023 оны эцэст 4,921 сая ам.доллар болж, түүхэн дээд түвшинд хүрсэн ба гадаад валютын нөөц нэмэгдсэнээр 2022 оны эцэст 6 хувиар сулраад байсан төгрөгийн бодит ханш 2023 оны эцэст өмнөх оноос 15 хувиар чангарсан байна. Барааны экспортын өсөлт импортын өсөлтөөс өндөр байснаар төлбөрийн тэнцлийн урсгал данс 2007 оноос хойш анх удаа ашигтай гарсан бол шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурч, гадаад бондуудын эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотойгоор 2023 онд санхүүгийн дансны ашиг буурлаа. Өнгөрсөн 2023 онд Монгол Улсын Засгийн газар Сенчири-2 төслийн хүрээнд 8.65 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, 650 сая ам.долларын бонд болон Сенчири-3 төслийн хүрээнд 7.875 хувийн хүүтэй, 5.5 жилийн хугацаатай, 350 сая ам.долларын бондыг олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай арилжааллаа. Цар тахал, геополитикийн тогтворгүй байдалтай нүүр тулсан сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх өрийн дарамтыг бууруулж, өрийн дефолтын эрсдэлээс сэргийлж, зээлжих зэрэглэлийг тогтвортой хэвээр хадгалж чадлаа.

1.2. Салбаруудын өнөөгийн нөхцөл байдал

1.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр


Газар тариалан: Монгол Улс нийтдээ 1,050.0 мянган га тариалангийн эргэлтийн талбайтай бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 22.3 мянган иргэн, аж ахуйн нэгж үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалан эрхэлж байна.

2023 оны ургац хураалтын дүнгээр 326.3 мянган га талбайгаас 456.4 мянган тонн үр тариа, үүнээс 433.8 мянган тонн улаанбуудай, 17.8 мянган га-гаас 175.0 мянган тонн

төмс, 13.4 мянган га-гаас 183.0 мянган тонн хүнсний ногоо, 92.1 мянган га-гаас 253.0 мянган тонн тэжээлийн ургамал, 113.0 мянган га-гаас 50.5 мянган тонн тосны ургамал тус тус хураан авлаа. Мөн 2023 онд аж ахуйн нэгж, иргэд 330.0 мянган га-д чанар сайтай уринш бэлтгэсний 150.0 мянган га талбайг дэвшилтэт технологиор боловсруулан 2024 оны тариалалтын бэлтгэл ажлыг хангаад байна.

Ургацын дүнг өнгөрсөн онтой харьцуулахад хураасан төмс 16.2 хувиар буурч, улаанбуудайн үйлдвэрлэл 9.7 хувиар, хүнсний ногооны ургац 40 хувиар тус тус өссөн. 2023 оны ургацаас гурилын үйлдвэрүүд 193.0 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд хүнсний улаан буудай 21.9 мянган тонн нийтдээ 214.9 мянган тонн улаан буудай зах зээлд нийлүүлэгдлээ.

Зураг 8. Хураан авсан ургац (мянган тонн)



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, "Хүнсний хангамж, аюулгүй байдал Үндэсний хөдөлгөөн", Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг 2023 онд хэрэгжүүлж газар тариалангийн салбарын тогтвортой байдлыг дэмжлээ. Үүнд:

- Арилжааны 10 банкнаас газар тариалангийн үйлдвэрлэгч 645 иргэн, аж ахуйн нэгжид 89.7 тэрбум, жимс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 559 иргэн, аж ахуйн нэгжид 24.3 тэрбум, нийтдээ 114.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, хаврын тариалалт, уринш боловсруулалт, ургамал хамгаалал, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд явуулах боломжийг бүрдүүлэв.
- Хөрөнгө оруулалтын зээлийн эх үүсвэрээр 171 иргэн, аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэй 81.5 тэрбум төгрөгийн зээлийг зоорь, хүлэмжийн аж ахуй, услалтын систем, үтрэм байгуулах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулан олгосон байна.
- Үрийн шинэчлэл хийх хүрээнд 382 аж ахуйн нэгж, иргэнд импортын элит үр 5.6 мянган тонн, дотоодын үржүүлгийн үр 6.4 мянган тонн, нийтдээ 12.0 мянган тонн улаанбуудайн үрийг 20-30 хувийн урьдчилгаа төлбөртэйгөөр олгож тариалалтад дэмжлэг үзүүлээ.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Завхан, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймагт 3 мянган га талбайг услах хүчин чадал бүхий инженерийн хийцлэлтэй 10 услалтын системийн барилгын ажил 45-95 хувийн гүйцэтгэлтэй ба дараа жилийн тариалалтаас өмнө ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс, жимсгэнийн суулгац үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр суулгац үржүүлгийн төв, хүлэмжийн загвар аж ахуйг 6 аймагт тус тус байгуулж байна.
- Засгийн газрын шийдвэрийн дагуу аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан 4.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 13 нэр төрлийн ил талбайн болон хүлэмжийн ногооны үрийг үнийн 80 хувийн хөнгөлөлттэй нийлүүлж, иргэд, ногоочдод технологийн хугацаанд олгох ажлыг зохион байгуулсан.

Мал аж ахуй: Мал аж ахуй салбарын ДНБ үйлдвэрлэл 2023 онд 10.3 хувиар буурлаа. Энэхүү бууралтад малын тоо өмнөх оноос 9.1 хувиар буурсан нь голлон нөлөөллөө. 2023 оны эцэст, мал тооллогын урьдчилсан дүнгээр, улсын хэмжээнд нийт 64.7 сая толгой мал, үүнээс 4.8 сая адуу, 5.4 сая үхэр, 473.9 мянган тэмээ, 29.4 сая хонь, 24.6 сая ямаа тоологдов. Мал тооллогын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонь 3.3 саяар буюу 10.2 хувиар, ямаа 3 сая буюу 10.7 хувиар, үхэр 0.2 сая буюу 2.9 хувиар тус тус буурсан байна.

Манай улсын ажил эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд урьдчилсан дүнгээр 298.2 мянган малчин байна. Мал тооллогын 2023 оны дүнгээр малтай өрхийн тоо 247.8 мянга болж, өмнөх оноос 0.5 мянгаар буурсан бол малын тоогоор бүлэглэж үзэхэд, 1,000-аас дээш малтай өрх 3.3 мянгаар буурч, 50 хүртэлх малтай өрх 3.9 мянга, 51-200 малтай өрх 2.2 мянгаар өссөн байна.

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар эрчимжсэн аж ахуй эрхлэгч, тухайлбал, махны үхрийн 715, сүүний үхрийн 1,912, гахайны 728, тахианы мах, өндөгний 864, зөгийний 555, нийт 4785 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

2023 онд улсын төсвийн 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 78, гадаадын төсөл, хөтөлбөрийн 627.5 сая төгрөгөөр 22, орон нутгийн төсвийн 10.2 тэрбум төгрөгөөр 444, малчдын өөрсдийн санаачилгаар 118 гар худаг, нийт 663 худгийг ашиглалтад оруулснаар 907.0 мянган га бэлчээр, 2,866 малчин өрхийн 2 сая малыг усаар хангах боломжийг бүрдүүлсэн.

Хөнгөн үйлдвэр: Хөнгөн үйлдвэрийн салбарын ноос ноолуур, арьс шир, мод, модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, гоо сайхан, ахуйн химийн нийт 3,200 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэрт 44,000 орчим хүн ажиллаж байна.

Монгол Улсад ноос, ноолуур угаах 34 үйлдвэрт 54.3 мянган тонн ноос, ноолуур угаах, угаасан ноолуурын хялгасыг нь ялгах 50 үйлдвэрт 11.9 мянган тонн самнасан ноолуур гаргах, ээрмэлийн 14 үйлдвэрт 2.9 сая тонн ээрмэл гаргах хүчин чадал суурилагдсан боловч, суурилагдсан хүчин чадлынхаа 20-70 хувийг ашиглаж байна.

Өнөөгийн байдлаар Улаанбаатар, Дархан хотод арьс шир боловсруулах 34 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 гаруй жижиг, дунд үйлдвэр нийслэл, аймаг орон нутагт ажиллаж байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2023 онд нийтдээ 484.8 сая ам долларын экспорт, 1,077.5 сая ам долларын импорт хийсэн байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарын экспортын бүтцийг авч үзвэл, экспортын барааны нийт дүнд ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэл, түүхий эдийн экспорт дийлэнх хувийг эзэлж байгаа бол модон эдлэл, хэвлэл, цаас, картон бүтээгдэхүүний экспорт маш бага хувийг эзэлж, харин импортын дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Хөнгөн үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний худалдаа (сая ам.доллар)

Барааны нэр	Экспорт			Импорт		
	2021	2022	2023	2021	2022	2023
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	370.7	489.7	451.2	103.7	133.8	150.7
Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	6.4	5.2	4.7	6.4	9.3	9.5
Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2.2	2.1	3.2	24.6	35.1	36.2
Мод, модон эдлэл	0.1	0.3	0.3	67.3	81.7	79.5
Цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.0	0.3	0.1	64.3	98.1	78.4
Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	1.2	10.2	21.8	260.2	345.2	359.6
Нийт	380.6	507.8	484.8	526.5	703.2	1,077.50

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Угаасан ноолуурын экспорт 2023 онд өмнөх оноос 15 хувиар буурсан бол самнасан ноолуурын экспорт тоо хэмжээгээр 16.8 хувиар, үнийн дүнгээр 3.1 хувиар өссөн байна. Түүнчлэн түүхий ноолуурын импорт 2023 онд 150 тонн импортолж, өмнөх оноосоо 96 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Боловсруулаагүй арьс, шир 2023 онд 1,032.6 мянган ширхэг болж өмнөх оноос тоо хэмжээний хувьд 359.4 хувиар өссөн бол харин боловсруулсан арьс, шир 36.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газраас хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөх тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан. Мөн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, “Шинэ ховд үйлдвэрлэл, технологийн парк” төслүүдийг хэрэгжүүлж эхлэв.

Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарт 815 аж ахуйн нэгж, 8,150 хүн ажиллаж, нийт 607.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ.

Мод, модон бүтээгдэхүүн, тавилгын үйлдвэрлэлийн салбарт улсын хэмжээнд 450 гаруй аж ахуйн нэгж байгууллага, мод бэлтгэл, ойн цэвэрлэгээ, мод боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 3-4 хувийг үйлдвэрлэсэн. Мод бэлтгэл, зүсмэл материалын 180 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 6,000 гаруй хүнийг ажлын байраар хангасан.

Махны нөөц бүрдүүлэлт: Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан 2020-2021 онд 16 аж ахуйн нэгж нийт 10.3 мянган тонн, 2021-2022 онд 23 аж ахуйн нэгж 12.7 мянган тонн, 2022-2023 онд 7.9 мянган тонн махны нөөцийг бүрдүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанктай хамтран нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан нөөцийн мах бэлтгэлийн 53.3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 2 банкнаас санхүүжүүлж, мах бэлтгэн нийлүүлэгч 12 аж ахуйн нэгжид олгон, 7,900.0 тонн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж, нөөцөлсөн. Нөөцийн махыг хүчит шонхор захын бөөний болон жижиглэнгийн үнэтэй харьцуулахад 30-45 хувиар хямд худалдаалсан бөгөөд гүйцэтгэл 72.0 хувьтай байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн: Засгийн газраас дотоодын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд 2023 оны байдлаар хүнсний ногооны дотоодын хангамж 83

хувьд, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын хангамж 73.9 хувьд, өндөгний дотоодын хангамж 56 хувьд, мах, махан бүтээгдэхүүний дотоодын хангамж 97 хувьд хүрсэн.

Сүүний салбар: Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор баталсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” журмын дагуу 2022-2023 онд сүү боловсруулах 15 үйлдвэрт 12.0 сая литр түүхий сүү нийлүүлсэн 7,878 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 6.0 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон. Нийлүүлсэн түүхий сүүний хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өссөн байна.

Засгийн газрын 2023 оны 363 дугаар тогтоолоор сүүний урамшууллын хамруулах хугацаа, нийлүүлсэн бүтээгдэхүүний төрөл, урамшууллын хэмжээ зэргийг нэмэгдүүлээд байна. Мөн, тухайн Засгийн газрын тогтоолоор журмын хэрэгжилтийн хугацааг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

Жижиг, дунд үйлдвэр: Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2009-2023 онд 735.7 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, аж ахуйн нэгж, иргэдийн 8,673 төсөлд ойролцоогоор 1 их наяд төгрөгийн зээлийг олгосноор 53.4 мянган ажлын байрыг шинээр бий болгож, 38.8 мянган ажлын байрыг хадгалсан байна.

2023 онд эргэн төлөлтийн эх үүсвэрээс 28.9 тэрбум төгрөг, орон нутгийн эх үүсвэрээс 11.8 тэрбум төгрөг, олон улсын эх үүсвэрээс 3.4 тэрбум төгрөг, ХХААХҮЯ-наас 4.7 тэрбум төгрөг буюу нийт 88.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн.

Мал амьтны эрүүл мэнд: Монгол Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 21 аймгийн 337 сум, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 1,023 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйл ажиллагаа явуулж, нэгжүүдэд 876 малын их эмч, 447 малын бага эмч, 90 мал зүйч тус тус ажиллаж байна. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид дунджаар 56.4 мянга, нэг малын эмчид дунджаар 40.5 мянган мал ногдож байна.

Мал эмнэлгийн салбарын “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн дагуу халдварт, гоц халдварт, архаг халдварт өвчнөөс сэргийлэх, лабораторийн оношилгоо, тандалт шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлд хэрэгжүүлж байна.


Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2020 онд 25.8 тэрбум төгрөг, 2021 онд 26.4 тэрбум төгрөг, 2022 онд 26.6 тэрбум төгрөг, 2023 онд 54.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцууллаа. 2023 оны нийт санхүүжилтийн 76.2 хувийг гоц халдварт, 5.0 хувийг халдварт, 11.4 хувийг архаг халдварт, 2.6 хувийг лабораторийн оношилгоо, шинжилгээ, 1.8 хувийг халдваргүйжүүлэлт, 3.0 хувийг бусад мал, амьтан эрүүл мэндийг хамгаалах чиглэлд зарцуулсан.

Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх дараах дархлаажуулалтыг 2023 онд авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 9.3 сая толгой мал, амьтан хамруулж 92.4 хувийн гүйцэтгэлтэйгээр дархлаажуулалт хийгдсэн.
- Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын хүрээнд улсын хэмжээнд нийт 18.9 толгой хонь, ямааг хамруулахаас 73.5 мянган малчин өрхийн 17.6 сая толгой хонь, ямааг хамруулж, 92.8 хувийн гүйцэтгэлтэйгээр 49 (хамгийн бага хоног 30, хамгийн их хоног 76) хоногийн дундаж хугацаанд дархлаажуулалт хийгдсэн.

- Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлж, дархлаажуулах хүрээнд улсын хэмжээнд 16,792 малчин өрхийн 4.3 сая толгой хонь, хурга хамруулж, 94.2 хувийн гүйцэтгэлтэйгээр 58 (хамгийн бага хоног 33, хамгийн их хоног 70) хоногийн дундаж хугацаанд дархлаажуулалт хийгдсэн.

Зураг 9. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт (сая толгой мал)



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

1.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэр

Уул уурхайн салбар Монгол Улсын ДНБ-ий 27 хувь, аж үйлдвэрийн салбарын 73 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 83 хувь, экспортын 94 хувь, төсвийн орлогын 34 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Ашигт малтмалын тухай болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Үндэсний баялгийн сангийн тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулсан.

Салбарын хэмжээнд 2023 онд 11.7 тонн алт, 69.6 сая тонн нүүрс, 4.7 сая баррель газрын тос, 1,524.8 мянган тонн зэсийн баяжмал, 6.4 мянган тонн молибдений баяжмал, 5,712.9 мянган тонн төмрийн хүдэр, 1,087.8 мянган тонн жоншны хүдэр, баяжмал, 150.5 мянган тонн цайрын баяжмал, 12.5 мянган тонн катодын зэс үйлдвэрлэн экспортод гаргаад байна.

Хүснэгт 3. Эрдэс бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023*
Алт	тн	3.4	9.1	30.5	17.3	19.7	11.7
Зэсийн баяжмал	мян.тн	1,436.7	1,403.6	1,395.1	1,282.5	1,453.3	1,524.8
Молибдений баяжмал	мян.тн	6.0	5.7	6.4	7.3	6.5	6.4
Жоншны хүдэр, баяжмал	мян.тн	555.2	699.4	678.9	644.3	387.7	1,087.8
Гянтболд	тн	835.2	712.5	64.5	235.2	458.6	628.8
Төмрийн хүдэр	мян.тн	7,449.0	8,448.8	8,202.3	7,106.2	4,732.2	5,712.9
Цайрын баяжмал	мян.тн	123.9	134.8	134.1	112.6	141.2	150.5
Катодын зэс	тн	12,929.7	11,932.8	9,647.4	9,849.0	10,014.1	12,548.3
Нүүрс	мян.тн	36,264.7	36,604.1	28,676.9	16,117.6	31,821.6	69,608.5
Боловсруулаагүй нефть	мян.бар	6,189.8	6,545.2	4,070.5	4,348.9	2,605.7	4,730.4

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Ашигт малтмалын тухай хуулийн зохицуулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа бөгөөд 2018 оноос хойш 1.32 сая га талбайд 467 хайгуулын тусгай зөвшөөрлийг олгон, улсын төсөвт 50.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар 6.91 сая га талбайд ашигт малтмалын 2,726 тусгай зөвшөөрөл, үүнээс 1,726 ашиглалтын, 1,010 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 4.4 хувийг эзэлж байгаа ба геологийн судалгааны 10 чиглэлээр 70 гаруй төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжиж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2022 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан. Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 оны 466 дугаар тогтоолоор “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны түр журам”-ыг баталж, 2023 оны 59 дүгээр тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар гүйцэтгүүлэх асуудлыг шийдвэрлэж, 2023 оны 1 дүгээр сараас нүүрсний арилжааг нээлттэй, дуудлага худалдааны зарчмаар борлуулах ажлыг эхлүүлсэн. Биржээр арилжиж эхэлснээр нүүрсний экспортын хэмжээ нэмэгдэж, худалдаалах үнэ өсөж, далд эдийн засаг ил болж, худалдан авагч тал аливаа зуучлагчгүйгээр шууд худалдан авах тогтолцоо бүрдэж, төсвийн орлого нэмэгдлээ.

Түүнчлэн, биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг нэмэгдүүлэхээр “нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жонш”-ийг биржээр арилжаалах бүтээгдэхүүнд тооцон Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жоншны хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний үндэсний ангиллын стандартуудыг шинэчлэн батлуулаад байна.

Тус хуульд зааснаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд экспортын бүтээгдэхүүнээ заавал биржээр арилжаалах үүргийг хүлээж, нүүрс, төмрийн хүдэр, баяжмалыг биржээр арилжаалах ажлыг үе шаттайгаар эхлүүлснээс хойш 2023 оны жилийн эцсийн байдлаар 14.9 сая тонн нүүрс, 604.8 мянган тонн төмрийн баяжмалыг тус тус арилжиж, нийт 2,186.2 сая ам.долларын борлуулалтын орлого олсон бөгөөд үүний 155.3 сая ам.доллар нь биржийн үнийн өсөлтөөс шалтгаалсан нэмэлт орлого юм.

Монгол Улсад 14 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан газрын тосны хайгуулын 32 талбай ялгаснаас 9 талбайд хайгуулын, 4 талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Газрын тосны нөөц 43.34 сая тонн бөгөөд үүнээс 1996-2022 онд нийт 10.2 сая тонн газрын тос олборлож, үлдэгдэл баталгаат нөөц 33.1 сая тонн байна. Дорнод аймгийн Баянтүмэн-17, Хөх нуур-18, Дорноговь аймгийн Тариач-15, Өмнөговь аймгийн Галба-11 зэрэг хэтийн төлөв бүхий талбайнууд байна. Газрын тос боловсруулах үйлдвэр баригдсанаар дотоодын газрын тосоор үйлдвэрийг хангаж, шатахууны хэрэгцээний тодорхой хувийг хангах боломж бүрдэнэ.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд технологийн бус барилга байгууламжийн барилга угсралтын ажил, анхдагч технологийн барилга байгууламж, цахилгаан станцын ажлууд хийгдэж байна. Мөн үйлдвэрт дотоодын тос нийлүүлэх дамжуулах хоолой байгуулах төсөл хэрэгжиж, 18,834 ширхэг хоолой буюу 226 км хоолойг трассын дагуу байрлуулж, холбож гагнах ажлууд хийгдэж байна.


Хүнд үйлдвэрийн чиглэлээр 80 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, тэдгээрээс, төмөрлөг боловсруулах 26, металл хийцийн 5, машин, тоног төхөөрөмж эд анги үйлдвэрлэх 10, резин материал үйлдвэрлэлийн 7, кокс, хагас коксын 3, будаг, химийн 3, шохойн чулуу, цементийн 8, барилгын дулаалгын чулуун хөвөнгийн 1, чулууны 1, зэс утас үйлдвэрлэх чиглэлээр 2 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна.

Хүнд үйлдвэрийн салбар нь 286 мянган тонн хар төмөрлөг, 16 мянган тонн өнгөт төмөрлөг, 21 мянган тонн металл хийц, 120 ширхэг автобус, 35 ширхэг чиргүүл, 500 ширхэг бусад төхөөрөмж, 53 мянган тонн авто бензин, дизель түлш, 200 тонн бордоо, 450 тонн будаг, резин бүтээгдэхүүн, 30 мянган тонн битум үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай байна.

1.2.3. Зам, тээврийн салбар

Зам, тээврийн салбар нь 2023 онд бүх төрлийн тээврээр 107.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 46.6 (76.7%) сая тонноор нэмэгдсэн байна. Үүнд авто тээврээр тээсэн ачааны хэмжээ өмнөх оноос 2.1 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн, төмөр замаар тээсэн ачаа 2023 онд 36.1 сая тонн-д хүрч, өмнөх оноос 8.4 сая тонн буюу 30.5 хувиар нэмэгдсэн байна. Агаарын тээврээр 2023 онд 8.6 мянган тонн ачаа болон шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3 мянган тонноор буюу 33.5 хувиар буурсан байна.

Зураг 10. Тээсэн ачаа (сая тонн)



Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Бүх төрлийн тээврээр 2023 онд 146.5 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн байна. Үүнээс, 2023 онд автотээврээр давхардсан тоогоор 142.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос 0.3 хувиар, төмөр замын тээврээр 2.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 10 хувиар тус тус буурсан, харин агаарын тээврээр 1.7 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 81.7 хувиар, усан замын тээврээр 0.6 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 70.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг 11. Нийт зорчигч (сая хүн)




Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Бүх төрлийн тээврийн орлого 6.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 52.1 хувиар өссөн түүхэн өсөлттэй жил байлаа. Автотээврийн орлого 4.7 их наяд төгрөг болж өмнөх оноос 47.3 хувиар, төмөр замын тээврийн орлого 1.1 их наяд төгрөгт хүрч

өмнөх оноос 50.4 хувиар, агаарын тээврийн орлого 941.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 83.6 хувиар, усан замын тээврийн орлого 1.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.5 дахин өссөн байна.

Зураг 12. Тээврийн салбарын орлого (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Авто зам: Монгол Улс нийт 111,916.7 км авто замын сүлжээтэй. Үүнээс 14,921.3 км буюу 13 хувь нь олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд хамаардаг. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний 50.5 хувь буюу 7,535.6 км нь хатуу хучилттай авто зам байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан Монгол Улсын авто замын үндэсний сүлжээг бий болгох зорилтын хүрээнд 2020-2023 онд улсын хэмжээнд нийт 896.1 км хатуу хучилттай авто зам, 3,172.51 у/м гүүрийг барьж ашиглалтад оруулан 21 аймгийн төв, 104 сум, 5 хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдоод байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 онд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл 1.2 сая байна. Нийт тээврийн хэрэгслийн 66.1 хувь нь суудлын автомашин, 16.4 хувь нь ачааны автомашин, 2.0 хувь нь автобус, 6.8 хувь нь тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, 2.6 хувь мотоцикл, 6.1 хувь нь чиргүүл байна.

Автотээврээр 2023 онд 71.3 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс тээвэрлэсэн ачаа 38.2 сая тонн буюу 215.4 хувиар өссөн байна. Нийт ачаа тээвэрлэлтэд экспортын ачаа 68.2 сая тонн, импортын ачаа 3.0 сая тонныг эзэлж байна.

Экспортын тээвэрлэлтийг боомтуудаар авч үзвэл, Гашуунсухайт боомтоор 36.7 сая тонн, Шивээхүрэн боомтоор 19.1 сая тонн, Булган боомтоор 2.7 сая тонн бусад боомтоор 9.7 сая тонн ачаа тээвэрлэсэн байна. Экспортын тээвэрлэлтэд уул, уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт голлож байгаа бөгөөд нүүрсний экспорт 119.2 хувиар, газрын тосны экспорт 51.6 хувиар, зэсийн баяжмалын экспорт 25.2 хувиар тус тус өссөн байна.

Төмөр замын тээвэр: Монгол Улс нь нийт 3,349.4 км /дэлгэмэл урт/ төмөр замын сүлжээтэй бөгөөд нийт 12,235 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байгаагаас зүтгүүр 190, ачааны вагон 11,724, зорчигчийн вагон 321 байна.

Төмөр замын сүлжээг өргөтгөх ажлын хүрээнд 2023 онд Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг байнгын ашиглалтад оруулан,

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг дуусган туршилтын тээврийг эхлүүлээд байна.

Төмөр замаар 2023 онд 36.1 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оноос 8.4 сая тонноор буюу 23.2 хувиар өссөн байна. Нийт ачаа тээвэрлэлтэд экспортын ачаа 11.1 сая тонн, импортын ачаа 3.6 сая тонн, дотоодын ачаа 16.3 сая тонн, дамжин өнгөрөх ачаа 5.1 сая тонн эзэлж байна. Төмөр замаар тээвэрлэсэн дотоодын ачаа 4.3 сая тонн буюу 35.5 хувиар, экспортын ачаа 2.5 сая тонн буюу 28.8 хувиар, дамжин өнгөрсөн ачаа 2 сая тонн буюу 60.5 хувиар тус тус өссөн бөгөөд харин импортын ачаа 0.7 сая тонн буюу 7.1 хувиар буурсан байна.

Төмөр замын ачаа тээвэрлэлтэд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт голлож байгаа буюу 20.5 сая тонн уул уурхайн ачаа, үүнээс 12.7 сая тонн нүүрс тээвэрлэсэн байна.

Агаарын тээвэр: Монгол Улс нийт 16 агаарын хаалгатай бөгөөд ОХУ-тай 10 агаарын хаалгаар, БНХАУ-тай 6 агаарын хаалгаар хиллэдэг. Монгол Улсын агаарын зайг 6 секторт хуваан агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж байна.

Одоогийн байдлаар олон улсын 16, орон нутгийн 8 нийт 24 чиглэлд 16 агаарын тээвэрлэгч нислэг үйлдэж байна. Монгол Улсад нийт 60 агаарын хөлөг байгаагаас 4 агаарын хөлөг гадаад улсад бүртгэлтэй байна. Үүнээс 30 агаарын хөлөг нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.

Монгол Улсад нийт 25 нисэх онгоцны буудал байгаагаас олон улсын 5, орон нутгийн 20 нисэх онгоцны буудал байна. Үүнээс 4Е ангилал 1, 4D ангилал 1, 4С ангилал 1, 3С ангилал 18, 2С ангиллын 1, гэрчилгээгүй 3 нисэх онгоцны буудал байна.

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн орон бөгөөд олон улсад нислэг үйлдэж буй МИАТ ХК, “Хүннү эйр” ХХК, “Аэромонголиа” ХХК, “Изинис-Эйрвейз” ХХК, “Монголиан Эйрвэйз Карго” ХХК агаарын тээвэрлэгчид нь олон улсын агаарын тээврийн холбооны гишүүн юм. Монгол Улсын Засгийн газар 2023 оны байдлаар нийт 43 улсын Засгийн газартай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулаад байна.

Олон улсын чиглэлд 2023 онд дотоодын агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК-иуд 11 улсын 16 чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэж байна. Агаарын тээврээр 2023 онд нийт 1.7 сая зорчигч тээвэрлэсэн нь 2022 онтой харьцуулахад 81.7 хувиар өссөн байна.

Далай ашиглалт, усан замын тээвэр: 2023 оны байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлсэн нийт 375,823.9 тонны даац бүхий 25 орны 270 хөлөг онгоц Монгол Улсын төрийн далбааг мандуулан далайд аялж байна.

Улсын бүртгэлд 2023 оны байдлаар гэрчилгээ, улсын дугаартай нийт 206 усан замын тээврийн хэрэгсэл байна. Усан замаар 2023 онд 64.7 мянган зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2022 онтой харьцуулахад 71 хувиар өссөн байна.

1.2.4. Эрчим хүч

Өнөөдрийн байдлаар Монгол Улс баруун, төв, өмнөд болон дорнод бүс, Алтай–Улиастайн гэсэн 5 эрчим хүчний системд нийт 330 гаруй сум, суурин газруудыг төвлөрсөн эрчим хүчээр хангаж байна.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ: Монгол Улсын хэмжээнд 2023 оны гүйцэтгэлээр 10.9 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 9.9 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг түгээсний 75.5 хувийг дотоодын эх үүсвэрүүдээс, 24.5

хувийг импортын цахилгаан эрчим хүчээр тус тус хангасан байна. Нийт импортолсон цахилгаан эрчим хүчний 38.3 хувийг ОХУ-аас, 61.7 хувийг БНХАУ-аас тус тус импортолсон. Эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг эх үүсвэрийн бүтцээр нь авч үзвэл, 90.9 хувийг дулааны цахилгаан станцууд, 9.07 хувийг нар, салхи, усны эх үүсвэрүүд, 0.006 хувийг дизель эх үүсвэр тус тус үйлдвэрлэсэн.

Өвлийн их ачааллын үед буюу 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр эрчим хүчний ачаалал 1,636 МВт-д хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 224 МВт-аар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Хүснэгт 4. Цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, эх үүсгүүрээр (МВт, эзлэх хувь)


Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
ДЦС-ууд /МВт/	1,110.0	1,145.0	1,234.0	1,269.0	1,269.0
Эзлэх хувь	83.1%	82.1%	81.5%	81.9%	81.1%
СЭХ эх үүсгүүрүүд /МВт/	216.4	241.2	271.2	271.2	286.8
Эзлэх хувь	16.2%	17.3%	17.9%	17.5%	18.3%
Дизель үүсгүүр /МВт/	8.6	8.6	8.6	8.6	8.6
Эзлэх хувь	0.6%	0.6%	0.6%	0.6%	0.5%
Суурилагдсан хүчин чадал /МВт/	1,334.9	1,394.8	1,513.8	1,548.8	1,564.4

Эх сурвалж: Эрчим хүчний яам

Эрчим хүчний салбарын хэмжээнд эх үүсвэр болон цахилгаан дулааны дамжуулах, түгээх сүлжээний үндсэн тоног төхөөрөмжийн насжилт, хуучралт нь эрчим хүчний тасалдалд орох томоохон эрсдэлийг бий болгож байна.

Цахилгаан эрчим хүчний дамжуулалт түгээлтээр цахилгааны 13 хувь нь алдагдаж байна.

Зураг 13. Цахилгаан эрчим хүчний дамжуулалт түгээлтийн алдагдал




Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Дулаан хангамж: Улаанбаатар хотын эрчим хүчний эх үүсвэрүүдийн дулаан үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал 2,318 Гкал/ц бол дулаан хангамжийн системд холбогдсон хэрэглэгчдийн тооцоот ачаалал 2023 онд 3373.6 Гкал/ц ба суурилагдсан хүчин чадал 31.2 хувиар хэтэрсэн байна. Өөрөөр хэлбэл, эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан хотын гадна агаарын тооцоот температур -39° хэмийн утгад хүрч хүйтрэл удаан хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд эх үүсвэрийн дулаан хангамжийн суурилагдсан хүчин чадал хүрэлцэхгүй бөгөөд дулаан хангамжийн эх үүсвэрээс алслагдсан цэгүүдэд хүндрэл үүсэх нөхцөл байдалтай байна.

Улаанбаатар хотод жилд дунджаар 190 гаруй Гкал/ц-ийн хэрэглээ бүхий 280 гаруй барилга байгууламж төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр холбогдож байна. Нийслэлийн дулааны хэрэглээ жилд 7-8 хувиар өсөн нэмэгдэж, энэ хэмжээгээр хэрэглээний өсөлт тогтвортой байвал 2025 оны түвшинд холбогдсон хэрэглэгчдийн ачаалал 3,874 Гкал/ц болно.

Дулааны эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн алдагдал 18-20 хувь буюу өндөр байгаа нь дамжуулах түгээх шугамын насжилттай холбоотой байна. Нийт 370 км урттай 15 магистраль шугамын 74.6 км буюу 20.1 хувь нь 30-аас дээш насжилттай байна.

Зураг 14. Дулааны шугамаар алдагдах дулаан



Эх сурвалж: "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК

Нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжийн системд 2015 онд Амгалангийн дулааны станц, 2020 онд Сэлбэ дэд төвийг барьж ашиглалтад оруулснаар дулааны үйлдвэрлэлийн хүчин чадал бага хэмжээгээр нэмэгдсэн боловч, хэрэглээний өсөлтийг бүрэн хангаж чадахгүй байна.

Сэргээгдэх эрчим хүч: Улсын хэмжээнд арилжааны үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 155 МВт-ын салхин цахилгаан станц, 90 МВт-ын нарны эрчим хүчний эх үүсвэрүүд ажиллаж байна. Салхины станцуудын системийн түгээлтэд 7.5 хувь, төлбөр тооцоонд 17.3 хувь, нарны эх үүсвэрүүд системийн түгээлтэд 1.4 хувь, төлбөр тооцоонд 6.8 хувь ба нийт дүнгээр нар, салхины эх үүсвэрүүд үйлдвэрлэлийн 9.2 хувь, төлбөр тооцооны 24.2 хувийг эзэлж байна. Эрчим хүчний нэгдсэн сүлжээний горимын зохицуулалтад оролцох боломжтой усан цахилгаан станц БНХАУ-д суурилагдсан хүчин чадлын 19.2 хувь, ОХУ-д 20.2 хувийг эзэлж байгаа бол манай улсын хувьд ердөө 1.7 хувийг эзэлж байна.

Салбарын санхүү эдийн засаг: Сүүлийн жилүүдэд үнэ тарифт өөрчлөлт оруулалгүй тогтвортой мөрдөж ирсний улмаас эрчим хүчний салбар 2019 онд 59 тэрбум, 2020 онд 92 тэрбум, 2021 онд 78 тэрбум, 2022 онд 187 тэрбум, 2023 онд 47 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Харин 2022 оны 10 дугаар сараас Эрчим хүчний зохицуулах хорооноос инфляцад огцом нөлөө үзүүлэхгүй байлгах зорилгоор айл өрхийн цахилгаан, дулааны тарифт өөрчлөлт оруулалгүйгээр, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны үнэ тарифыг тодорхой хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн нь 2023 оны алдагдлыг бага хэмжээгээр бууруулах боломж олгожээ.

1.2.5. Барилга, хот байгуулалт

Барилга угсралт, их засварын ажил улсын хэмжээнд 2023 оны байдлаар 7,493.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1,092.10 тэрбум төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн байна. Барилгын салбарын бүтээн байгуулалтын ажлын 94.4 хувийг хувийн хэвшил гүйцэтгэж байна.

Зураг 15. Барилга угсралт, их засварын ажил (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Барилгын үйл ажиллагааны 7 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх олгох үйл ажиллагааг цахимаар бүрэн шийдвэрлэдэг болсон байна. Цахим системээр www.license.mcis.gov.mn дамжуулан нийт 5,379 хүсэлтийг хүлээн авч, 1,587 аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл материалыг баталгаажуулсан. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр өмнө 30-45 хоног зарцуулдаг байсан хугацааг 10-15 хоногт багтаан шийдвэрлэдэг болсон ба олон шат дамжлага, зардал, цаг хугацааг хэмнэх нөхцөл бүрдсэн байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар барилга угсралт, их засварын ажлын 40.2 хувийг орон сууцны барилга, 33.9 хувийг орон сууцны бус барилга, 22.1 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.8 хувийг их засварын ажил тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон сууцны барилга 20.86 хувиар, орон сууцны бус барилгынх 41.30 хувиар, их засварын ажил 45.17 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаа бол инженерийн барилга байгууламж 13.51 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Барилгын салбарын ажиллах хүчний судалгааны 2023 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд 89.4 мянган ажиллагчид ажиллаж байна. Үүнээс: Улаанбаатар хотод 63.4 мянга, баруун бүсэд 10.9 мянга, хангайн бүсэд 8.9 мянга, төвийн бүсэд 5.8 мянга, зүүн бүсэд 273 ажиллагчид тус тус ажиллаж байна.

Зураг 16. Барилгын салбарын ажиллах хүч (мянган хүн, жил бүрийн 3 дугаар улирлаар)



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

Барилгын салбарын нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2023 оны байдлаар 2019.8 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 424.5 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 17. Барилгын салбарын ажилчдын сарын дундаж цалин (мянган төгрөг)



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Барилгын материал: Барилгын материал, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, чанарт жилээс жилд ахиц дэвшил гарч, үйлдвэрлэлийн хүчин чадал цементийн хувьд 6, бетон хийц, эдлэлийн хувьд 4, хөнгөн бетоны хувьд 2 дахин нэмэгдсэнээр барилгын гол, нэр төрлийн түгээмэл хэрэглэгддэг бетон, төмөр бетон болон барилгын дүүргэлтийн материал, хаших бүтээц, дулаалгын материалын хэрэгцээг 100 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшинд хүрсэн байна.

Дэлхийн улс орнуудад коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлын дараах эдийн засгийн өсөлтөөс шалтгаалан бүтээн байгуулалтын ажлуудын идэвхжил, олон улсын тээвэр логистик, хилийн боомтын халдвар хамгаалалтаас үүссэн нөхцөл байдал, барилгын материалын үнэ ханшны өөрчлөлт болон бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсөвт өртөг нэмэгдсэн байна.

Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц: 2022 оны жилийн эцсийн байдлаар шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн ам 83 хувийг, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн ам 69.3 хувийг тус тус эзэлж байна.

Тус салбарт нийт 223 байгууллага, аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудад 12 мянган ажилтан ажиллаж, нийтийн орон сууцны зориулалттай 7 мянга гаруй барилгын ашиглалтын үйл ажиллагааг хариуцаж, жилдээ 115.7 сая м3 ус олборлон 3,783 км урттай шугамаар түгээж, хэрэглээнээс гарсан 102.9 сая м3 бохир усыг 1,885 км урттай шугамаар татан зайлуулж, цэвэршүүлэн ажиллаж байна. Орон сууцны ашиглалт, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөл эзэмшигчид 675.2 мянган хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байгаагаас 641.0 мянга нь айл өрх, 34.2 мянга нь аж ахуйн нэгж, байгууллага байна.

Орон сууц: 2022 оны байдлаар манай улсын нийт 941.4 мянган өрхийн 32.1 хувь буюу 302.2 мянган өрх нь инженерийн дэд бүтцийн шаардлага хангасан орон сууцанд амьдардаг бол 29.7 хувь буюу 279.6 мянган өрх нь инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжгүй байшин хороололд, 38.2 хувь буюу 359.7 мянга нь гэр сууцанд тус тус амьдарч байна.

Зураг 18. Орон сууцны төрөл (нийт өрхөд эзлэх хувиар)



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

2023 оны эхний 3 улирлын байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 11,346 айлын орон сууц ашиглалтад орсон бол үүний 83 хувь нь нийслэл хотод ашиглалтад орсон байна. Ипотекийн зээлээр хөтөлбөр эхэлснээс хойш 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар, Монголбанк, арилжааны банкнуудын эх үүсвэрээр нийт 114.8 мянган иргэнд хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийг олгоод байна.

1.2.6. Аялал, жуулчлал

Монгол Улсад 2023 оны байдлаар нийт 594¹ мянган жуулчин ирж, дунджаар эдийн засагт 1.2 тэрбум ам.доллар буюу 4.4² их наяд төгрөгийн орлого төвлөрүүлсэн түүхэн жил боллоо. Ийнхүү жуулчид ихээр ирэх болсон нь Монголд зочлох жилийн хүрээнд 35 улс /БНСУ-ын иргэдийн 2022 онд чөлөөлснийг оруулан тооцов/-ын иргэдийг 2025 оныг дуустал буюу 3 жилийн хугацаанд визийн шаардлагаас түр чөлөөлснөөр нийт 61 улсын иргэд Монголд визгүй зорчих боломжтой болсонтой холбоотой. Мөн, Аялал жуулчлалын тухай хууль болон жуулчдад НӨАТ-ын буцаан олгох журмыг баталсан нь том түлхэц боллоо.


Зураг 19. Жуулчдын тоо (салбарын орлого)



Эх сурвалж: УСХ, Байгаль, орчин аялал жуулчлалын яам

2023 онд Оросын Холбооны Улсаас 212.3 мянган, Бүгд Найрамдах Солонгос Улсаас 139.5 мянган, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 108.9 мянган жуулчид ирсэн нь нийт ирсэн жуулчдын 80 орчим хувийг бүрдүүлж байна.

Зураг 20. Жуулчид (улсаар, хувиар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аялал жуулчлалын салбарт улсын хэмжээнд 571 тур оператор компани, дотоод 3, гадаадын 9, нийт 12 агаарын тээвэрлэгч, 442 зочид буудал, 526 гаруй жуулчны бааз, амралтын газар, шууд бусаар 939 ресторан, зоогийн газар болон бусад аялал жуулчлалын салбарт хамаарах аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Олон улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс (WEF Travel & Tourism Development Index)-д 2019 оны судалгааны дүнгээр Монгол Улс 140 орноос 93 дугаарт эрэмбэлэгдэж байна. Тус индексийг бүрдүүлэгч шалгуур үзүүлэлтүүдийг харахад манай орны агаарын тээвэр, газрын дэд бүтэц, олон улсад нээлттэй байдал буюу визийн үзүүлэлтүүдэд хамгийн сул үнэлэгдсэн байна. Энэхүү асуудлуудыг шат дараалалтай шийдвэрлэхийн тулд аялал жуулчлалын бүс нутгийн дэд бүтцийн хүртээмж, чанарыг сайжруулах, Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрүүдийг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.2.7. Харилцаа холбоо, мэдээлэл технологи

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2023 онд 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 376.8 тэрбум төгрөгөөр буюу 21.8 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд утасгүй холбооны үйл ажиллагааны орлого 17 хувиар, компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагааны орлого 70.3 хувиар, өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааны орлого 23.4 хувиар, утсан холбооны орлого 26.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 5. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023
Орлого	тэрбум төгрөг	1,602.5	1,703.3	2,107.1
Суурин утасны цэг	мян.ширхэг	310.8	341.1	339.8
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид, давхардсан тоогоор	мян.хүн	4,607.6	4,834.2	4,850.6
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид	мян.хэрэглэгчид	9,55.5	991.4	1,072.3

Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Интернэт хэрэглэгчдийн тоо 2023 оны эцэст 4.4 сая болж, өмнөх оноос 180.5 мянган хэрэглэгчээр буюу 4.3 хувиар өссөн байна. Манай улсын харилцаа холбооны дэд бүтцийн хүртээмж дэлхийн дунджаас дээгүүр байна. Ялангуяа, 100 хүнд ногдох гар утас хэрэглэгчийн тоо /нийт хүн амын 98 хувь нь гар утас хэрэглэдэг/, хөдөлгөөнт өргөн зурвас хэрэглэгчийн тоо болон интернэт хэрэглэгчдийн нийт хүн амд эзлэх хувиараа 2022 онд хийсэн судалгаагаар өмнөх жилүүдтэй харьцуулбал хамгийн өндөр өсөлттэй байсан байна.

“ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем нь 2023 оны байдлаар 79 төрийн байгууллага, 168 аж ахуйн нэгж ашиглаж, нийт 495 нэр төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Монгол Улсад нийт “eMongolia”-д бүртгэлтэй 1.8 сая идэвхтэй хэрэглэгч байгаагаас давхардсан тоогоор нийт 41.7 сая үйлчилгээ авсан.

Монгол Улсын харилцаа холбооны салбарын хөгжил өнөөг хүртэлх хугацаанд мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэхээр техник, технологийн суурь дэд бүтцийг өргөтгөн 49,318 км урт шилэн кабелийн сүлжээ байгуулж, бүх аймаг, сумын төв, томоохон суурин газрууд хөдөлгөөнт холбооны үйлчилгээг орон нутгийн ард иргэдэд үзүүлж байна. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 2023 оны эцэст 4.9 (давхардсан тоо) сая болж өмнөх оноос 16.4 (0.3%) мянган хэрэглэгчээр өсөж, хөдөлгөөнт холбооны 4 дэх үеийн технологийг 2016 онд нэвтрүүлэн одоогийн байдлаар 3 сая 160 мянга гаруй хэрэглэгчтэй болсон байна.

Өнөөгийн байдлаар улсын төсөв, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1,448 багийн 178,000 өрх буюу нийт өрхийн 94.5 хувьд үүрэн холбооны үйлчилгээ хүргэж, цахим хэрэглээг бий болгосон. 2023 оны 4 улирлын байдлаар алслагдсан бүс нутгийн 191 багт оршин суугаа 10,412 өрхийн 42,000 иргэн үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй байна. Үүнээс 59 сум, суурин газар, багийг үүрэн холбооны сүлжээнд холбох улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлуулан, хэрэгжүүлж байна.

Цаашид хүн амын тоо болон аялал жуулчлалын тэргүүлэх бүс нутаг зэргийг харгалзан үзэж 53 багт харилцаа холбооны дэд бүтэц байгуулан үүрэн холбооны үйлчилгээ хүргэж, иргэдэд гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний зарлан мэдээллээс хоцрох, төрийн цахим үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авахгүй байх зэрэг эрсдэлийг бууруулахаар ажиллаж байна.

1.2.8. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн салбарт 2022 оны байдлаар 4,652 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас анхан шатны эрүүл мэндийн байгууллага 534, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага 90, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага 4,028 байна.

Салбарын хэмжээнд нийт 63.3 мянган ажилчин ажиллаж байгаа бөгөөд 10,000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтны тоо 189.6 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 21.3-аар өндөр үзүүлэлттэй байна.

Олон улсад эмч, сувилагчийн харьцаа 1:3 байдаг бол манай улсад эмч, сувилагчийн харьцаа 1:1, Улаанбаатар хотод 1:0.8, аймгийн түвшинд 1:1.3 байгаа нь сувилагчийн тоо дэлхийн түвшнээс 3 дахин цөөн, эмч сувилагчийн харьцаа улсын дүнгээр өмнөх онтой харьцуулахад 0.1-ээр буурсан үзүүлэлттэй юм.

Эрүүл мэндийн салбарт 2020 оноос гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлснээр анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт 3 дахин нэмэгдэж, өндөр төлбөртэй тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр хийлгэх

боломж бүрдсэн боловч, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа хармаанаасаа гаргаж байгаа зардал өрхийн орлогын 35 хувийг эзэлж байгаа² нь ДЭМБ-ын зөвлөмжөөс 25 хувиар өндөр байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалт: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын байгууллага 2021 онд байгуулагдсанаар эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн нэгдсэн худалдан авалт хийх замаар эмийн үнийг бууруулж, чанар, хүртээмжийг сайжруулах тогтолцоо бүрдсэн ч, эмийн үнэ өндөр, чанар, аюулгүй байдлыг хянах тогтолцоо бүрэн бэхжээгүй байна. Иймд эмийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог бэхжүүлж, төвлөрсөн худалдан авалтаар авч байгаа (15) эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх (30) замаар эмийн үнийг бууруулах, эмийн хяналтын лабораторийн чадавхыг бэхжүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган эмийн чанар, аюулгүй байдлыг хянах зайлшгүй шаардлагатай байна.

Эрт илрүүлэх тогтолцоо: Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд 1.3 сая иргэнийг хамруулсан нь хамрагдвал зохих хүн амын 38 хувийг эзэлж байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 74 хувьд (947.9 мянган хүн) өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдэн, эмчийн хяналтад орж, хүндрэл, нас баралтаас сэргийлсэн нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг үр дүнтэй байгааг харуулж байна.

Цахимжилт: Эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 4,652 байгууллагууд 37 төрлийн программ хангамж ашиглаж байгаа нь хоорондоо мэдээлэл солилцох, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад бэрхшээлтэй нөхцөл байдал үүсгэж байна. Хүний эрүүл мэндийн нууцлалыг хангах, эрүүл мэндийн статистик мэдээллийг нотолгоонд суурилан үнэн зөв боловсруулах, мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах чиглэлээр эрүүл мэндийн салбарт нэгдсэн систем бий болгох, технологийн хүний нөөцийг бэлтгэн, тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай байна.

1.2.9. Биеийн тамир, спорт


Монгол Улсад биеийн тамир, спортын 33 төрийн захиргааны байгууллагад 861 албан хаагч ажиллаж, 1 ажилтанд биеийн тамир, спортоор хичээллэдэг 3,988 иргэн ногдож байгаа нь 2018 оноос 8 хувиар нэмэгдсэн байна.

Бие бялдрын түвшин тогтоох сорилд 2022 онд 334.3 мянган иргэн хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн ба өнгөрсөн онуудад бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагсдын тоо бага байсан нь дэлхий нийтийг хамарсан цар тахал “Ковид-19” цар тахалтай холбоотой байна.

Бие бялдрын түвшин тогтоох сорилын үнэлгээг улсын хэмжээнд авч үзвэл “А” үнэлгээ 23.2 хувь, “В” үнэлгээ 31.6 хувь, “С” үнэлгээ 24.4 хувь, “D” үнэлгээ 14.2 хувь, “F3” үнэлгээ 6.6 хувь байгаа нь урьд онтой харьцуулахад “С” үнэлгээ-2.5, “D” үнэлгээ 5.1, “F” үнэлгээ 1.6 нэгжээр буурч, “А” үнэлгээ 5.7, “В” үнэлгээ 3.5 нэгжээр тур тус өссөн байна.

Зураг 21. Бие бялдрын түвшин тогтоох сорил

² Эрүүл мэндийн үндэсний тооцоо 2016-2021 он, ЭМХТ



Эх сурвалж. ОНБТСҮХ ны тайлан 2022

Бие бялдрын түвшин тогтоох сорилын дүнгээр нийт хамрагдагсдын 23.4 хувь нь илүүдэл жинтэй байгаагийн 53.2 хувь нь эмэгтэй, 46.8 хувь нь эрэгтэй хүн байна.

Монгол Улсад 2022 онд нийт 135 877 тамирчин бүртгэгдсэн нь өмнөх оноос 26.4 хувиар, нийт 3177 спортын арга хэмжээ зохион байгуулсан нь 2020 оноос 63.8 хувиар, биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэд 1.1 сая байгаа нь урьд оноос 79 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.2.10. Боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол:

Монгол Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 1,410 (төрийн 1,010, төрийн бус өмчийн 400) хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, сургуулийн өмнөх боловсролд 274.2 мянган хүүхэд хамрагдаж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн өмчийн цэцэрлэг 25-аар нэмэгдэж, төрийн бус өмчийн цэцэрлэг 28-аар буурсан байна. Үндсэн сургалтад хамрагдаж буй хүүхдийн тоо сүүлийн 3 хичээлийн жилд тогтмол өсөж, 2020-2021 оны хичээлийн жилтэй харьцуулахад 16.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Цэцэрлэг, өмчийн хэлбэр, байршлаар


Үзүүлэлт 6. Цэцэрлэг, өмчийн хэлбэр, байршилээр

Үзүүлэлт		Хичээлийн жил					
		2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024
Цэцэрлэгийн тоо		1,435	1,439	1,454	1,453	1,413	1,410
Өмчийн хэлбэр	Төрийн	889	910	948	972	985	1010
	Хувийн	546	529	506	481	428	400
Байршил	Хот	682	685	684	677	649	659
	Хөдөө	753	754	770	776	764	751
Бүлгийн тоо		7,903	8,122	8,499	7,877	8871	9034
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид		261,354	263,333	247,040	190,991	266,024	274,236

Эх сурвалж. 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэл

Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт 2023-2024 оны хичээлийн жилд дунджаар 30.4 байна. Төрийн өмчийн цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 31.5 байгаа нь хувийн цэцэрлэгээс 7.8 нэгжээр их байна.

Зураг 22. Сургуулийн өмнөх боловсролын бүлэг дүүргэлт (хүүхдийн тоогоор)



Эх сурвалж: 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэл

2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд цаашид улсын хэмжээнд хэрэгжүүлж, сургуулийн өмнөх насны хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд хамруулах зорилт тавин ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын 2-5 настай хүүхдийн хамран сургалт (цэвэр жин) 89.7 хувь байгаа нь 2022-2023 оны хичээлийн жилтэй харьцуулахад 3.2 нэгжээр, ковидын өмнөх жилтэй харьцуулахад 8.2 нэгжээр өссөн байна. Нийт хүүхдийн 88.2 хувь (242,109) нь төрийн өмчийн цэцэрлэгт, 11.7 хувь (32,127) нь төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.


Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй малчдын хүүхдийн тоо сүүлийн 3 жил, халамж эдэлдэг болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн 5 жил тогтмол өссөн байна. Улсын Их Хурлаар шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулахаар заасан ба 2023 онд 5 настай 77,115 хүүхэд байснаас 94.8 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нь өмнөх хичээлийн жилээс 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Зорилтот бүлгийн хүүхдийн хамрагдалт (тоогоор)

Зорилтот бүлэг	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024
Малчдын хүүхэд	31,891	31,860	30,102	33,657	34,888
Халамж эдэлдэг хүүхэд	2,902	3,096	3,301	3,460	3,794
Бүтэн өнчин хүүхэд	54	46	83	53	32
Хагас өнчин	1,947	1,711	2,643	1,833	1,234
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	1,076	1,156	1,385	1,498	1,977

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Зураг 23. 5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин (хувиар, аймгаар)



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд нийт 71.8 мянган хүүхдийг хамруулж гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 70.2 хувь гарсан нь өмнөх оноос 2.7 нэгжээр буурсан байна.

2023-2024 оны хичээлийн жилд нийт 33,999 албан хаагч ажиллаж байгаа нь өмнөх оноос 223-аар буурсан үзүүлэлт юм. Нийт ажиллагсдын 88.7 хувь төрийн өмчийн цэцэрлэгт, 11.3 хувь хувийн өмчийн цэцэрлэгт ажиллаж байна. Үүнээс 29 хувь нь үндсэн багш, 25.5 хувь нь туслах багш, 45.5 хувь нь бусад ажилчид байна. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж нэмэгдэж байгаатай холбоотойгоор төрийн өмчийн цэцэрлэгийн нийт ажиллагчдын тоо 2019-2020 оны хичээлийн жилтэй харьцуулахад 17.4 хувиар нэмэгдсэн хэдий ч багшийн ачаалал их, ажлын цаг урт, хөдөлмөрийн хөлс бага зэргээс шалтгаалан багш мэргэжлээр ажиллагчдын тоо цөөрч мэргэжлийн багшийн хангалт өмнөх оноос 1.3 нэгжээр буурч 92 хувьд хүрсэн байна.

Засгийн газрын 2023 оны “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай” 115 дугаар тогтоолын дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэлд сургуулийн өмнөх боловсролын багшийн хөтөлбөр орсон. Сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багшийн хангалтыг 2025 онд 95 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлээд байна.

Ерөнхий боловсрол: 2023-2024 оны хичээлийн жилд 871 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж өмнөх онтой харьцуулахад 12-оор өссөн байна. Нийт ЕБС-ийн 79.7 хувь нь төрийн өмчийн, 20.2 хувь нь хувийн сургууль байх бөгөөд тэдгээрт 776.8 мянган суралцагч, 36.9 мянган багш ажиллаж байна. Суралцагчийн тоо өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 3.3 хувиар нэмэгдсэн байна.

2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 25,471 бүлэг хичээллэж байгаа бөгөөд бүлгийн тоо өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 2.8 хувиар буюу 721-ээр нэмэгдсэн. Ерөнхий боловсролын сургуулийн нийт 25,471 бүлгийн 69.7 хувь нь нэг ээлжээр, 30.0 хувь нь хоёр ээлжээр, 0.3 хувь нь буюу 8 сургууль гурван ээлжээр хичээллэж байна.

Хүснэгт 8. Ерөнхий боловсролын сургууль, суралцагчид

Он	ЕБС-ийн тоо (байршил, төрийн өмчийн хэлбэрээр)					Суралцагчид (сургалтын хэлбэрээр)				
	Нийт	Хот	Хөдөө	Төрийн	Хувийн	Нийт	Өдөр	Орой	Эчнээ	Албан бус
2019-2020	820	258	562	662	158	646,839	640,449	88	123	6,179
2020-2021	839	277	562	672	167	686,321	680,837	51	93	5,340
2021-2022	848	285	563	682	166	717,451	712,353	33	102	4,963
2022-2023	859	297	562	688	171	751,513	746,405	33	94	4,981
2023-2024	871	498	373	695	176	776,817	771,772	-	-	5,095

Эх сурвалж: 2023-2024 оны хичээлийн статистик мэдээлэл

2022-2023 оны хичээлийн жилд ачаалал өндөртэй, гурван ээлжид шилжих эрсдэлтэй нийт 68 сургууль үйл ажиллагаа явуулж, 33.0 мянга орчим сурагч суралцаж байсныг бууруулах чиглэлээр Засгийн газраас шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд тус хичээлийн жилийн эхэнд нийт 60 сургуулийн ачааллыг бууруулж, гурван ээлжээр хичээллэх эрсдэлийг арилгаж, 2 ээлжээр шинэ хичээлийн жилд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлсэн.

Сургуульд элсэх насны нийт хүүхдийн 93.4 хувь нь 6 настайдаа сургуульд элссэн байна. Түүнчлэн, хамран сургалтын цэвэр жин бага боловсролын (1-5-р анги) хувьд 96.5 хувь, дунд боловсролын (6-9-р ангийн) хувьд 96.5 хувь байна.

Зураг 24. Хамран сургалтын цэвэр жин (ангиар)



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Нийт багш нарын 87.7 хувь нь (33,2 мянга) нь төрийн, 12.3 хувь (4.6 мянга) нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. Багшийн тоо өмнөх хичээлийн жилээс 2.9 хувь буюу 1,718-аар нэмэгдсэн. Нийт багш нарын 98.4 хувийг мэргэжлийн багш бүрдүүлж байна.

Суралцах хугацаандаа дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан (37.0 мянган) нийт хүүхдийн 97 хувь буюу 36.0 мянган хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн 528 дотуур байранд амьдарч байна.

Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны газрын хоол үйлдвэрлэлийн захиргааны статистикийн тайлан ирүүлсэн нийт 871 сургуулийн 649 (74.5%) нь хоолны газартай, 222 (25.5%) нь хоолны газаргүй байна. Нийт сургуулийн 323 (46.5%) нь стандартын гал тогоотой, 372 (53.5%) нь стандартын бус анги танхимыг өргөтгөн засварласан, технологи урсгал буруу, шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдаагүй, зай талбай бага/ гал тогоотой байгаа бол 120 (17.3%) сургууль нь түрээсийн хоолны газартай байна. 2023 оны статистикийн мэдээгээр баллонтой 3,674, шугамд холбогдсон 2,047 нийт 5,721 ус цэвэршүүлэгч төхөөрөмж ерөнхий боловсролын 507 сургуульд байна. Төрийн өмчийн 695 сургуулийн 72.9 хувь нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангагдаад байна

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага: Монгол Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 76 техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 48 буюу 63.1 хувь нь төрийн өмчийн, 28 буюу 36.8 хувь нь хувийн өмчийн байна. Нийт сургалтын байгууллагын 40 нь орон нутагт, 36 нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна.

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 16 салбарын 214 мэргэжлээр нийт 38,294 суралцагч (24,179 буюу 63.1 хувь нь эрэгтэй, 14,115 буюу 36.8 хувь нь эмэгтэй) мэргэжил, ур чадвар эзэмшин суралцаж байгаа ба үүнээс 18 хүртэлх насны суралцагчид 21,650 байгаа ба 18 хүртэлх насны суралцагчаас хагас өнчин 2,125 буюу нийт суралцагчийн 5.5 хувийг, бүтэн өнчин 182 буюу нийт суралцагчийн 0.5 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 638 суралцагч сурч байгаа нь нийт суралцагчийн 1.6 хувийг эзэлж байна. Нийт суралцагчдын 70.1 хувь нь төрийн өмчийн, 29.9 хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад суралцаж байна.

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын салбарт 4,168 ажиллагчид ажиллаж байгаагаас үндсэн багш 2,351 буюу нийт ажиллагчдын 56 хувийг эзэлж байна. Нийт үндсэн багшийн 1,914 буюу 81.4 хувь нь төрийн өмчийн, 437 буюу 18.6 хувь нь хувийн өмчийн техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үндсэн багш байна. 2023-2024 нийт үндсэн багшийн 775 буюу 33 хувь нь ерөнхий эрдмийн, 1,576 буюу 67 хувь нь мэргэжлийн багш байна.


Мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, дээд боловсролын шаталсан тогтолцоог бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын 20 сургуулийг өөрчлөн зохион байгууллаа.

Дээд боловсрол: 2021-2022 оны хичээлийн жилд 88 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байсан бол 2023-2024 оны хичээлийн жилээс дээд боловсролын сургалтын байгууллагын чанарт анхаарсан арга хэмжээний үр дүнд их, дээд сургуулиудын тоо цөөрч 65 болсон.

Үүнээс 33 нь их сургууль, 30 нь дээд сургууль, 1 нь коллеж байна. Өмчийн хувьд, нийт их, дээд сургууль, коллежийн 16 нь төрийн өмчийн, 45 нь хувийн өмчийн, 3 нь олон нийтийн/шашны өмчийн сургалтын байгууллага байна.

2023-2024 онд их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 145.3 мянга болж, өмнөх жилээс 78-р нэмэгдсэн байна.

Зураг 25. Их, дээд сургууль, коллежийн тоо




Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Хүснэгт 9. Их, дээд сургууль, коллежид суралцагчид

Үзүүлэлт	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024
Бүх суралцагчид	148,446	147,293	148,954	145,267	145,345
Үүнээс:Эмэгтэй	90,573	89,463	91,034	88,823	88,601
Бакалавр	119,301	119,232	120,192	115,250	113,322
Магистрантур	25,753	24,813	25,300	25,509	24,171
Докторантур	3,392	3,248	3,462	4,508	5,060

Эх сурвалж: Дээд боловсролын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик

Зураг 26. Нийт суралцагчдын тоо, мэргэжлийн ерөнхий чиглэлээр



Эх сурвалж: 2023-2024 оны хичээлийн статистик мэдээлэл

Их, дээд сургууль, коллежид нийтдээ 11,664 ажиллагчид ажиллаж байгаагаас үндсэн багш 5,112 буюу нийт ажиллагчдын 43.8 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2023-2024 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт ажиллагчдын 62.7 хувь нь төрийн өмчийн сургуульд, 34.4 хувь нь хувийн өмчийн сургуульд, үлдсэн нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.

Хүснэгт 10. Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид

Үзүүлэлт	Хичээлийн жил					
	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024
Ажиллагчдын тоо	12,634	11,306	11,970	12,175	11,923	11,664
Үүнээс: эмэгтэй	7,912	7,061	7,505	7,688	7,573	7,457
Үндсэн багшийн тоо	6,669	7,315	7,143	6,102	5,169	5,112
Үүнээс: эрэгтэй	4,028	4,482	4,314	3,740	3,169	4,207

Эх сурвалж: 2022-2023 оны хичээлийн статистик мэдээлэл

Монгол Улсад 2023-2024 оны хичээлийн жилд нийт 3,670 гадаад оюутан суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс 2.4 дахин нэмэгдсэн байна. БНХАУ-ын оюутнуудын гадаад оюутанд эзлэх хувь 10 хувиар нэмэгдэж 86.4 хувьд хүрсэн байна.

Төрийн болон хувийн өмчийн 88 их, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, тусгай шаардлагад тавигдах шаардлага хангахгүй байгаа 21 сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцалж, зарим сургуулийг нэгтгэн зохион байгуулав. Их, дээд сургууль, коллежийн хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийн чанарыг дээшлүүлэх хүрээнд хэрэгжиж байсан 2,564 хөтөлбөрт хяналт, шалгалт хийж, тусгай шаардлага хангахгүй байгаа өдөр, орой, эцнээ хэлбэрийн 1,086 хөтөлбөрийг хүчингүй болголоо.

Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын чанарын судалгааны хүрээлэн, олон улсын эрэмбэ тогтоодог "Times Higher Education" байгууллагаас аргачлалын зөвлөгөө авч хамтран ажиллаж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт 64 их, дээд сургуулиудын үндэсний эрэмбэ, чансааг урьдчилсан байдлаар тогтоосон.

Хүснэгт 11. Эхний 10-т жагссан сургуулийн үндсэн мэдээлэл

№	Сургуулийн нэр	Нийт оноо	Сургалт	Эрдэм шинжилгээ	Гадаад харилцаа	Орчны үнэлгээ
---	----------------	-----------	---------	-----------------	-----------------	---------------

1	Монгол улсын их сургууль	83.5%	94%	91%	41%	73%
2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	75.4%	86%	65%	50%	83%
3	Шинжлэх ухааны технологийн их сургууль	71.8%	82%	66%	30%	81%
4	Монгол улсын багшийн их сургууль	65.6%	82%	41%	37%	83%
5	Хөдөө аж ахуйн их сургууль	60.2%	72%	40%	30%	82%
6	Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал технологийн их сургууль	56.1%	59%	48%	40%	70%
7	Санхүү, эдийн засгийн их сургууль	52.3%	84%	10%	30%	64%
8	Отгонтэнгэр их сургууль	52.1%	66%	29%	37%	68%
9	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль	50.4%	54%	35%	24%	80%
10	Соёл урлагийн их сургууль	48.9%	58%	21%	44%	75%

Эх сурвалж: 2022-2023 оны хичээлийн статистик мэдээлэл

Засгийн газрын 2023 оны “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай” 115 дугаар тогтоолыг батлуулж, мэргэжил сонголт, зээл тэтгэлгийн үйл ажиллагаанд баримталж эхэлсэн.

2023 оноос их, дээд сургуулийн засаглалыг бие даасан байдлыг хангах төрөөс хараат бус байдлыг бэхжүүлэх бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэн, төрийн өмчийн их, дээд сургуулийн захирлыг удирдах зөвлөл томилох, чөлөөлөх эрхтэй болсон.

1.2.11. Шинжлэх ухаан, технологи

Шинжлэх ухааны салбарт яам, агентлагийн харьяа 12, Шинжлэх ухаан академийн харьяа 16, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын 21, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн дэргэдэх 2, нийт 63 эрдэм шинжилгээний байгууллага байна. Нийт 6,880 хүн ажиллаж байгаагийн 1,488 нь эрдэм шинжилгээний ажилтан байна.

Хүснэгт 12. Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөц

№	Үзүүлэлт	2021	2022
1	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагын тоо	71	63 /их, дээд сургуулийн тоо багассан/
	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагын тоо	35	35
2	Нийт ажиллагчид /эрдэм шинжилгээний байгууллага их дээд сургууль/	7,072	6,880
3	Нийт судлаачид /эрдэм шинжилгээний байгууллага их дээд сургууль/	5,085	5,224
4	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй ажилтан	1,970	1,815
5	Төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан	1,349	1,488
6	Эмэгтэй эрдэм шинжилгээний ажилтны тоо	719	662

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Шинжлэх ухааны салбарын 2023 оны санхүүжилт нь 91.4 тэрбум төгрөг батлагдсаны 72 хувь буюу 65.7 тэрбум төгрөг нь урсгал зардал, 13 хувь буюу 12.3 тэрбум төгрөг нь эрдэм шинжилгээний ажлын зардал бөгөөд энэ нь ДНБ-ний 0.12 хувийг эзэлж байна.

2023 онд жилийн эцсийн байдлаар үргэлжлэн хэрэгжиж байгаа 399 төсөл, арга хэмжээний судалгааны ажлын зардалд 8.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Үүнээс суурь судалгааны 164 төслийн 2,799.0 сая төгрөг, үндсэн чиглэлийн 27 төслийн 900 сая төгрөг, хавсарга судалгааны 1 төслийн 42.7 сая төгрөг, захиалгат төслийн 45 төсөлд 2,595.9 сая төгрөг, зорилтот төслийн 2 төсөлд 122.3 сая төгрөг, гадаадтай хамтарсан 72 төсөлд 1,411.0 сая төгрөг, технологи туршилт зүгшрүүлэлтийн 25 төсөлд 789.7 сая төгрөг, докторын дараах инновацын тэтгэлэгт 20 төслийн 100.0 сая төгрөг, ШУА-ийн грант 18 төслийн 100.0 сая төгрөг, инновацын грантын 2 төсөлд 120.0 сая төгрөг, "Мон Икс" арга хэмжээний хүрээнд грант 9 төсөлд 180 сая төгрөг, залуу судлаачдын грант 14 төсөлд 140 сая төгрөг олгосон.

1.2.12. Соёл, урлагийн салбар

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар урлагийн 35 байгууллага, 38 музей, 26 номын сан, киноны 14 байгууллага, 347 соёлын төв (ордон) нийт 460 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас соёлын салбарын соёлын бүтээлч үйлдвэрлэлийг ДНБ-ний 4 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд хууль, эрх зүйн хүрээнд "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027), "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)"-г тус тус батлан хэрэгжүүлж байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл арга хэмжээний хүрээнд Монголыг сурталчлах контентуудыг хийж, олон нийтийн цахим сүлжээгээр түгээн танилцуулж, нийгмийн сүлжээнүүдээр нийтдээ 40 контентыг нийтэлсэн бөгөөд 154.3 сая удаагийн үзэлт авсан байна.

Монгол Улсад 2022 онд 6 улсын 8 компани 9 кино зураг авалт хийж 618 сая төгрөг төвлөрүүлсэн бол 2023 онд 11 улсын 23 компани 36 кино зураг авалт хийж 11.9 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 19.3 дахин өссөн байна. Мөн Дэлхийн нэр хүндтэй Канн, Венец, Бусаны олон улсын кино наадамд оролцсон нь Монгол Улсын нэр хүндийг олон улсад эергээр сурталчилж, улмаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлсэн.

Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний хүрээнд соёлын боловсролын үндэсний сургагч багшаар 141 соёлын ажилтныг бэлтгэж, 124 соёл, урлагийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж, 90 гаруй мянган иргэн хамрагдсан байна. 4 аймгийн 6 суманд нүүдлийн соёлын боловсрол олгох хүүхдийн зуслан ажиллаж, нүүдлийн соёл, ахуйтай танилцах, эх хэл, үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах боломжийг бүрдүүлж, гадаадын 9 оронд амьдарч буй 200 гаруй монгол хүүхдүүдийг хамруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагуудын үзвэр, үйлчилгээ авах, үйлчлүүлэгчдийн тоо 2023 онд өмнөх оноос 16 хувиар өсөж нийт 9,380.6 мянган хүн болжээ.

Монгол Улсын Соёлын өвийн үзмэрийг сэргээн засварлах ажлын хүрээнд 2023 онд 165 сэргээн засварлах ажил хийгдсэн. Монголын Уран зургийн галерей Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Гадаад хэргийн яамны Соёлын өвийг хадгалан хамгаалах хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар олон улсын стандартад нийцсэн уран зураг сэргээн засварлах анхны иж бүрэн лабораторитой боллоо.

2023 оны байдлаар Монгол Улсын Засгийн газраас 778 дурсгалт зүйлийг Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалаар баталсан бөгөөд 197 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтад бүртгэсэн ба аймаг, нийслэлийн хамгаалалтад 597 түүх, соёлын дурсгал байна.

1.2.13. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Хүн амын өсөлт, бүтэц: Монгол Улсын нийт хүн ам сүүлийн 10 жилд 2.9-3.5 саяд хүрч, 600 орчим мянгаар нэмэгдсэн байна. Хүн амын өсөлтийн хувь 2 байхад хүн ам өсөж байгаад тооцогддог бөгөөд Монгол Улсын хүн амын өсөлт 2016 оноос тасралтгүй буурч, 2023 оны байдлаар 1.4 хувьд хүрлээ.

Зураг 27. Хүн амын өсөлт (сая хүн, хувь)




Зураг 28. Хүн ам зүйн ачаалал, (100 хүнд ногдох хөдөлмөрийн бус насны хүн ам (15-аас доош насны болон 65-аас дээш насны хүн ам))




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт хүн амд эзлэх ахмад настны хувь 12 ба түүнээс дээш бол насны бүтцийн хувьд хөгшрөх хандлагатай хүн ам гэж үздэг. Манай улсын хүн амын насны бүтцийг харвал, насжилтын хандлага ажиглагдаж эхэлж байна. 2023 оны байдлаар 65 ба түүнээс дээш насны буюу насжилт 4.9 хувь байгаа нь 2022 оныхоос 0.3 хувиар нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жилд насжилт 0.2-1.0 хувиар тогтмол өсөж байгаа бөгөөд цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 29. Хүн амын нас, хүйсийн суварга
2020 он



2030 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүн ам зүйн ачаалал буюу 100 хүнд ногдох хөдөлмөрийн бус насны хүн ам 2023 оны байдлаар 60 болж нэмэгдэж байгаа нь цаашид нийгмийн даатгалын санд ачаалал үүсгэхээр байна. Үүнд сүүлийн 5 жилд хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох ахмад настан 6.7-оос 8.2 болж өссөн, хүүхэд 50.4 байсан бол 51.7 болж өссөн нь голлон нөлөөлж байна.

Өрх, гэр бүл: Монгол Улсад 2023 оны байдлаар нийт 983.4 мянган өрх тоологдсоны 68.9 хувь нь хотод, 31.1 хувь нь хөдөөд амьдарч байна. 2018 онд хөдөө, орон нутагт

амьдардаг өрхийн тоо 4.3 хувиар буурч байсан бол 2023 онд 0.2 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл хөдөө амьдрах өрхийн тоо өсөж байна. Сүүлийн 5 жилд буюу 2018 онд 100 хүнд ногдох гэр бүл цуцлалт 2.0 байсан бол 2023 онд 2.2 болж өссөн байна. Харин 100 хүнд ногдох гэрлэлт 10.2 байсан бол 2023 онд 8.2 болж буурсан байна.

Нийгмийн халамж: Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 2.1 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг 2.6 сая иргэнд олгосон байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр авагч 62.6 мянган хүн байгаагийн 61.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, 26.4 хувийг тэжээгчээ алдсан хүүхдүүд, 11.5 хувийг ахмад настны тэтгэвэр авагчид, бусад төрлийн тэтгэвэр авагчид 0.3 хувийг эзэлж байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2023 онд 134.5 мянган иргэн хамрагдсаны 51.9 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.1 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо нэмэгдэж байна. Үүнд эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа иргэдийн тоо 2023 онд 67.4 мянга болж, өмнөх оноос 6.8 мянгаар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Үүнд нийгмийн халамжаас тэтгэвэр авагч ахмадын тоо 4.1 мянгаар нэмэгдсэн, байнгын асаргаа шаардлагатай 16 нас хүртэлх хүүхэд болон 16-аас дээш насны иргэдийн тоо 2-3.0 мянгаар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, төрлөөр

Д/д	Халамжийн үйлчилгээ	2019	2022	2023
	Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж авагчид	2,359,383	2,688,297	2,682,580
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр авагч	60,658	65,615	62,631
1.1.	Ахмад настны тэтгэвэр	3,360	5,765	7,235
1.2.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	41,396	43,392	38,722
1.3.	16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	117	137	119
1.4.	Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	15,766	16,307	16,536
1.5.	Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр	19	14	19
2	Нийгмийн халамжийн тэтгэмж авагч	120,132	125,809	134,556
2.1.	Асаргааны тэтгэмж	63,430	65,865	69,959
2.2.	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж авагч	56,702	59,944	64,597
2.2.1.	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд	11,164	12,882	14,128
2.2.2.	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	43,677	45,701	48,984
2.2.3.	Бусад	1861	1361	1485
3	Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж	224,130	246,686	252,678
4	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1,000,000	1,291,813	1,305,322
5	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	8,060	10,394	11,304
6	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	345	119	119
7	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	242,348	121,959	100,650
8	Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	197,320	319,737	314,751
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	57,924	54,360	55,483

10	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	312,556	283,220	267,764
11	Насны хишиг	135,542	168,201	176,929
12	Цаатан иргэний тэтгэмж	368	384	393

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын сангийн орлого 2023 онд 4.2 их наяд төгрөг болж, 2022 оноос 900 тэрбум төгрөгөөр өсөж, зарлага 4.0 их наяд төгрөг болж 630 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд 2023 онд 58.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага шимтгэл төлж нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 748.4 мянган иргэнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон байна.


Хүснэгт 14. Нийгмийн даатгалын орлого, зарлага, 2019-2023 он (мянган хүн, тэрбум төгрөг)

Он	Ажил олгогчийн тоо	Даатгалд хамрагдсан Даатгуулагчийн тоо			Орлого	Тэтгэвэр, тэтгэмж авагчийн тоо	Зарлага
		Албан журмаар	Сайн дураар	НИЙТ			
2019	48.2	969.5	187.7	1157.2	2485	655	2062.3
2020	49.3	953.4	193.1	1146.5	1878.2	657.2	2451.8
2021	52.4	1014.4	163.4	1177.8	2705.2	748.3	2562.9
2022	55.1	907.1	162.4	1069.5	3512.5	749.1	3415.7
2023	58.2	1021.4	158.5	1179.9	4261.6	748.3	4032.6

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, гүйцэтгэлийн мэдээ

Тэтгэврийн даатгалын сангаас 2023 онд 493.0 мянган хүнд 3,615.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан иргэдийн тоо 2.7 хувиар, зарлага 18.1 хувиар нэмэгдсэн байна.


Зураг 30. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, гүйцэтгэлийн мэдээ

Монгол Улсын Засгийн газар хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023 онд нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн бөгөөд 2023 онд тэтгэврийн дундаж хэмжээ 687.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 23.8 хувиар өссөн байна.

Зураг 31. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн өсөлт




Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, гүйцэтгэлийн мэдээ

Өнөөдрийн байдлаар 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 5 байгаа бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсөж, 2030 онд 7 тэтгэвэр авагч болохоор байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо 2023 онд 58.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага болж 5.5 мянгаар нэмэгдэж нийт даатгуулагч 1,315.9 мянган хүн болж 2022 оныхоос 3.2 хувиар өссөн байна. Үүнд албан журмаар даатгуулагчийн тоо 4.1 хувиар өссөн бол сайн дураар даатгуулагчийн тоо 2.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.


Зураг 32. Нийгмийн даатгалын хамрагдалт (мянган хүн)



Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөрийн үнэлэмж, дундаж цалин: 2023 оны жилийн эцсийн байдлаар дундаж цалин 2,009.3 мянган төгрөг, медиан цалин 1,556.4 мянган төгрөг байна. Хувийн секторын ажиллагчдын дундаж цалин 2,267.9 мянган төгрөг болж өмнөх оноос 18.2 хувиар өссөн бол төсөвт байгууллагын цалингийн дундаж 2023 онд 1,752.1 мянган төгрөг болж 14.2 хувиар өссөн байна.

Зураг 33. Ажиллагчдын сарын дундаж, медиан цалин болон бодит цалингийн индекс (мянган төгрөг)



Эх сурвалж: УСХ

Ядуурал: Үндэсний статистикийн хорооноос 2 жил тутамд ядуурлын түвшинг тооцдог. 2022 оны байдлаар ядуурлын түвшин 27.1 хувь байгаа бөгөөд энэ нь ядуурлын шугамыг шинэчлэн тооцсон дүн юм. Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 914.2 мянган хүн байгаа бөгөөд ядууралд өртөхөд ойрхон 346.4 мянган хүн ам байгаа нь ядуурал 10.3 хувиар нэмэгдэх эрсдэлтэй байгааг харуулж байна.

Нийт ядуу хүн амын 57 хувь нь хот суурин газарт, 43 хувь нь хөдөө, орон нутагт байна. Үүнээс 37 хувь нь Улаанбаатар хотод, сумын төвд 20 хувь, аймгийн төвд 19 хувь, хөдөө 23 хувь нь амьдарч байна.

Жини коэффициент буюу тэгш бус байдлын үзүүлэлт болох нэг хүнд сард ногдох зардлын ялгаа буурсан байна.

Зураг 34. Ядуурлын түвшин



Зураг 35. Жини коэффициент



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: Жини коэффициент хүн амын зардлын тэгш бус хуваарилалтыг илэрхийлсэн үзүүлэлт. 0> тусам ялгаа ихсэж, 0 руу ойртох тусам ялгаа бага байгааг илтгэнэ.

Ядуурлын шугамыг 2022 оноос шинэчлэн 418,090 төгрөгөөр тогтоосон.

Хөдөлмөр эрхлэлт: Монгол Улсад сүүлийн жилүүдэд ажиллагчдын тоо нэмэгдэж байгаа хэдий ч ажиллах хүчнээс гадуурх хүн ам өсөж, ажиллах хүчний оролцооны түвшин буурч байна. 2023 онд ажиллах хүч 1,245.6 мянга болж, өмнөх оноос 20 мянгаар буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 2023 онд 915.9 мянга хүрч өмнөх оноос 20 орчим мянгаар нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
15 түүнээс дээш насны хүн ам мян/хүн	2,258.80	2,287.40	2,316.00	2,344.60	2,373.20
Ажиллах хүч мян/хүн	1,273.9	1,250.6	1,225.3	1,265.2	1,245.6

Ажиллагчид мян/хүн	1,146.2	1,162.9	1,125.5	1,180.4	1,196.8
Ажилгүй иргэн мян/хүн	127.7	87.6	99.7	84.7	48.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам мян/хүн	832.1	877.4	926.7	894.3	915.9
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	60.5	58.8	56.9	58.6	57.6
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	54.4	54.6	52.3	54.7	55.4
Ажилгүйдлийн түвшин, хувь	10	7	8.1	6.7	3.9
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, хувь	15.1	12.4	13.7	10.6	8.5
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, хувь	11.2	7.4	8.6	7.4	4.5
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, хувь	14	12	13.2	9.9	8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 онд аж ахуйн нэгж байгууллагын 23.6 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн гэсэн нь өмнөх оноос 7.7 нэгжээр өссөн үзүүлэлт юм. Ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр авч үзвэл, ажиллах хүчний нийт эрэлтийн 23.5 хувийг мэргэжилтэн, 21.3 хувийг энгийн ажил мэргэжил, 17.2 хувийг үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 11.1 хувийг худалдаа, үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах ажил мэргэжлийн эрэлт эзэлж, нийт ажиллах хүчний эрэлтийн 73.1 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн барилгын засалч, шаварчин, жолооч, оёдолчин, мужаан, тогооч, зөөгч, гагнуурчин, цахилгаанчин, сантехникч зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэдэг ажил мэргэжлийн эрэлт их байгаа бол дээд боловсролын хувьд нягтлан бодогч, менежерүүд, инженер, малын эмч зэрэг ажил мэргэжлүүд эрэлттэй ажил мэргэжлийн хүрээнд нэрлэгдэж байна.

Зураг 36. Хөдөлмөрийн дутуу ашиглалт (мянган хүн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Салбараар нь авч үзвэл, бөөний болон жижиглэн худалдаа, барилга болон боловсруулах салбар нь нийт ажиллах хүчний хомсдолын дийлэнх хувийг эзэлж байна.

Монгол Улсын ажиллах хүчний оролцооны түвшин 2023 онд 57.6 хувь болж, өмнөх оноос 1.0 хувиар буурсан ба дэлхийн дундаж 60.4 байгаагаас доогуур үзүүлэлт юм. 2023 онд эрчүүдийн ажиллах хүчний оролцоо 66.3 хувь, эмэгтэйчүүдийнх 50.6 хувь болж буурч ажиллах хүчний оролцооны түвшин 15.7 хувийн зөрүүтэй байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо буурч буй шалтгааны 58 хувийг жирэмсэн,

хүүхэд болон өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өндөр настан асарч байгаа буюу асрахуйн шалтгаануудаар тайлбарлагдаж байна.

Зураг 37. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын нийт 15-24 насны залуучуудын 18.3 хувь нь (сүүлийн арван жилийн дунджаар) ямар нэгэн хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байна. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын судалгаагаар 2022 оны байдлаар олон улсад залуучуудын хөдөлмөр эрхлэлт 40 хувьтай байгаа бол Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлт 30 хувь буюу олон улсын дунджаас 10 хувиар доогуур байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 2023 онд ажил олгогчдоос нийт 84.9 мянган ажлын байрны захиалга ирүүлснээс 35.3 мянган иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан. Ажлын байрны ашиглалт 42 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилд зуучлан оруулсан хүний тоо 2991 хүнээр буюу 9.3 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хиймэл оюун ухаанд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан дундын зуучгүйгээр 19.9 мянган иргэн ажилд зуучлагдсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал: Сүүлийн 5 жилийн байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод нийт 1,623 хүн осолдож, үүнээс 1,593 нь үйлдвэрлэлийн осолд, 30 нь хурц хордлогод өртсөн байна. 2023 онд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 408 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 3.3 хувиар өссөн байна. Нийт осолдогчдын 57 буюу 13.4 хувь нь нас барсан байна.

1.2.14. Байгаль орчин, ногоон хөгжил

Уур амьсгалын өөрчлөлт: Монгол Улсын хүлэмжийн хийн ялгаруулалтын үнэмлэхүй хувь хэмжээ бага боловч, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий улс үндэстний нэг гэж тооцогддог.

Парисын хэлэлцээр 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба тус хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд Монгол Улс өмнө нь 2015 онд тодорхойлсон хүлэмжийн хийн ялгаралтыг 2030 он гэхэд 14 хувиар бууруулах зорилтоо ахиулан 22.7 хувь болгон тодорхойлж, Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт” -ыг батлуулан НҮБҮӨСК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт 2020 оны 10 дугаар сард хүргүүлсэн. Олон улсын төвшинд үүрэг, амлалт өгөхөөс гадна хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг үндэсний төвшинд бодитоор авч хэрэгжүүлэх

замаар Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах нь нэн чухал асуудал болж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын олон улсын байгууллагуудтай хамтран Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр 2023 оны байдлаар нийт 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Ногоон хөгжил: “Байгаль орчинд ээлтэй техник, технологи” үзэсгэлэнг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, 120 орчим аж ахуйн нэгж, байгууллага оролцож, шинэ технологи, үйл ажиллагаагаа сурталчилж хэвшээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний 2021 оноос өрнөж эхэлсэн бөгөөд доройтсон ойг нөхөн сэргээх, цөлжилт, хөрсний элэгдлийн эсрэг хамгаалалтын зурвас байгуулах, хот суурин газарт ногоон байгууламж нэмэгдүүлэх гэсэн үндсэн гурван зорилгын хүрээнд өрнүүлж байна. Эхний гурван жилд бэлтгэл ажил буюу суурь бэлдэж, тарьц, суулгац, хүний нөөц, дэд бүтэц бүрэлдэхүүнээр төлөвлөгдсөн. 2024 оноос мод тарилтын ажил эрчимжиж эхэлнэ. Одоогийн байдлаар 61.5 сая орчим ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлээ.

2023 онд Байгаль, орчин аялал жуулчлалын яам цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх, экологи-эдийн засгийн ач холбогдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор “Байгальд ээлтэй хэрэглээг гэр бүлийнхээ төлөө сонгоё” уриан дор Цахилгаан авто машины “Нээлттэй өдөрлөг”-ийг 2023 оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт цахилгаан автомашин импортлогч 15 аж ахуйн нэгж байгууллага, дэмжигч байгууллагаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Тээврийн цагдаагийн алба, Хаан, Хас, Төрийн банк оролцсон.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 21.0 хувь буюу 32.8 сая га талбайг 2022 онд улсын тусгай хамгаалалтад хамруулж, нэгдсэн сүлжээг бүрдүүлээд байна. Нийт нутаг дэвсгэрийн 15 орчим хувийг буюу 24.3 сая гаруй га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад хамруулсан. Улсын тусгай хамгаалалттай нутгийг хуулиар тогтоосон 4 ангиллаар авч үзвэл, 13.8 сая га талбай бүхий 22 дархан цаазат газар 13.8 сая га талбай, 13.5 сая га талбай бүхий 37 байгалийн цогцолборт газар, 5.3 сая га талбай бүхий 47 байгалийн нөөц газар, 106.6 га талбай бүхий 14 дурсгалт газрууд тус тус эзэлж байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрдэх эхийн 7.2 сая га талбай буюу 50 хувь, ойн сангийн 40 хувь нь хамрагдаж хамгаалагдсан.

Монгол Улсын хэмжээнд улсын тусгай менежментийн чиглэлээр 30 хамгаалалтын захиргаа, 30 дарга, 120 мэргэжилтэн, 332 байгаль хамгаалагч, 144 гэрээт байгаль хамгаалагч, 144 үйлчилгээний ажилтан үйл ажиллагаа явуулж байна.

Усны нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалт: Монгол Улсын гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбайн 49.91 хувь улсын тусгай хамгаалалтад хамрагдаж байна. Монгол орны хэмжээнд усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүхий усны 29 сав газарт хувааж, усны 21 сав газрын захиргаанд 234 хүн, 8 сав газрын зөвлөл ажиллаж байна.

Манай орон хязгаарлагдмал усны нөөцтэй орны тоонд ордог. Нийт 564,800 сая шоо метр нөөцтэйгөөс 10,500 сая шоо метрийг ашиглах боломжит нөөцтэй гэж тооцдог. Гэвч энэхүү усны нөөцийн дийлэнх буюу 80 орчим хувь нь нутаг дэвсгэрийн 30 хувьд буюу хангайн бүсэд, томоохон голуудын хөндийд бүрэлдэн бий болдог.

Манай улс 2023 онд нийт 645.1 сая м.куб ус олборлож ашигласан. Үүнээс 41.20 хувийг хөдөө аж ахуй, 32.31 уул уурхай, 13.61 хувийг хүн амын унд ахуй, 7.22 хувийг

эрчим хүч, 5.66 хувийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт тус тус ашиглажээ. Энэ нь ус ашиглалт өмнөх оноос 6.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүн амын өсөлт, хотжилт, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжлийн хурдац, төлөвлөлтийг харгалзан гол, ус хэрэглэгчдийн хэтийн төлөвийг тоймлон тооцож үзэхэд 2030 онд ус хэрэглээ 3-4 дахин нэмэгдэхээр төлөвтэй байна. Усны ойрын болон хэтийн хэрэглээг хангахад усны нөөцийн жигд бус тархалт, уур амьсгалын өөрчлөлт хүндрэл учруулахаар байна. 2023 оны усны тооллогын дүнгээр 264 гол горхи, 704 булаг шанд, 286 нуур тойром ширгэсэн байна. Цаашид усны температур нэмэгдэж, ууршилт ихсэж, урсац буурах хандлагатай байна. Ялангуяа говь, хээрийн бүс байгалийн аясаар хуурайшиж, усны нөөцийг ууршилтаар алдаж байгаа нь усны хомсдолыг бий болгож байна.

Улсын хэмжээнд хэвийн үйл ажиллагаа явуулж буй 108 цэвэрлэх байгууламж, шинээр баригдаж байгаа болон улсын комисс хүлээж аваагүй 53, цэвэрлэгээ хийгдэхгүй байгаа 32 цэвэрлэх байгууламж байна. Ахуйн бохир ус цэвэрлэх технологитой 164, үйлдвэрийн бохир ус цэвэрлэдэг 29 байгаагаас 21 аймгийн 62 сумын төвийн цэвэрлэх байгууламж механик болон биологийн цэвэрлэгээ хийж байна. Нийслэл Улаанбаатар хотын 5 дүүрэгт 9 цэвэрлэх байгууламж ажилладаг. Нийт цэвэрлэх байгууламжуудаас 26 нь цэвэршүүлэн гарч буй бохир усыг голд шууд хаяж, 25 нь төвлөрсөн сүлжээнд нийлүүлж, 142 нь хөрсөнд шингээн зайлуулдаг. Улсын хэмжээнд хоногт 400 мян.м³ бохир усыг цэвэрлэн байгальд нийлүүлж байгаа ч 136 мян.м³/хон бохир усыг механик болон биологийн цэвэрлэгээ хийхгүйгээр байгальд шууд нийлүүлж байна.

Нийслэлд арьс шир, ноос, ноолуур боловсруулах 44 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 үйлдвэр хаягдал усаа цэвэршүүлж эргүүлэн ашигладаг. Харин Эрдэнэт, Оюутолгой, Таван толгой зэрэг томоохон уул уурхайн үйлдвэрүүд ашигласан усныхаа 70-80 хувийг эргүүлэн ашигладаг технологи нэвтрүүлэн ажиллаж байна.

Ойн сан: Монгол Улсын ойн сангийн талбай 19,073.7 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 12.2 хувийг эзэлдэг бөгөөд үүний 12,452.0 мянган га нь ойгоор бүрхэгдсэн талбай 8.2 хувь (байгалийн болон таримал ой, гол мөрний дагуух бургас, сөөг), 5,634.4 мянган га нь ойгоор бүрхэгдээгүй (тармаг мод, байгалийн аясаар ойжиж байгаа болон зориудаар ойжуулж байгаа газар, түймэр, мод бэлтгэл, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ой), 521.6 мянган га нь ойн сан доторх ойн бус талбайд хамаарна. Ойн сангийн 15,471.5 мянган га буюу 83.1 хувь нь хамгаалалтын бүсийн, 3,136.5 мянган га буюу 16.9 хувь нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна.

Монгол орны ойн нийт нөөц 1,246,517,781 шоо метр бөгөөд үүний 79.29 хувийг шинэс, 8.92 хувийг хуш, 5.97 хувийг хус, 4.95 хувийг нарс, 0.23 хувийг гацуур, 0.01 хувийг жодоо, 0.17 хувийг улиас, 0.05 хувийг улиангар, 0.006 хувийг хайлаас, 0.25 хувийг бургас, 0.14 хувийг заг, 0.005 хувийг тоорой тус тус эзэлж байна. Шилмүүст мод зонхилсон ойн дундаж нас 131 жил, 1 га-ийн нөөц 142.9 м³, өсөлт 1.09 м³, навчит мод зонхилсон ойн дундаж нас 44 жил, 1 га-ийн нөөц 44.4 м³, өсөлт 0.98 м³, жилийн бүх дундаж өсөлт 10,212.5 сая м³ байна.

Монгол оронд 8 баг 62 овог, 316 төрөлд хамаарах 737 зүйлийн шавж нь мод, бут, сөөгийн навч шилмүүс, иш холтос, модлог, үр жимс, үндсээр хооллон ойд их, бага ямар нэг хэмжээгээр хөнөөл учруулдаг тул жил бүр урьдчилан сэргийлэх болон тэмцлийн ажлыг гүйцэтгэдэг. Улсын хэмжээнд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 265.8 мянган га талбайд улс, орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн санхүүжилттэй "Эрүүл ой" төслийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна. Энэ нь тэмцэл хийх шаардлагатай талбайн 36.4 хувийг хамарч байна.

Улсын хэмжээнд 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 80 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 802 га талбайд, ойн зурвас байгуулах ажлыг 75 га талбайд, говь, хээрийн бүсийг навчит модоор нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажлыг 16 га талбайд хийж, ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 973 га талбайд гүйцэтгэсэн. Үр түүх талбайн хэмжээ, үр болон тарьц, суулгацын нөөцийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад өссөн дүнтэй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/172, 116 дугаар тушаалаар "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын норматив"-ыг шинэчлэн баталж, мөрдөн ажилласнаар ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлын арчилгааны ажлын зардлыг шинээр тусгаснаар ойжуулалтын ажлын үр дүн, чанар сайжирсан.

Хүснэгт 16. Ойн нөхөн сэргээх ажил

Арга хэмжээ	2019	2020	2021	2022	2023
Үр бэлтгэх талбай, га	-	-	50.0	50.0	120.0
Үрийн нөөц, кг	714.0	710.0	340.0	12,186.0	480.0
Тарьц, сая.шир	-	-	7.9	45.8	61.9
Ойжуулалт, га	2,913.4	3,088.7	2,967.0	2,946.6	10,700.0
Ойн зурвас, га	1,741.3	183.1	668.4	668.4	80.0
Байгалийн сэргэн ургалтад туслах, га	4,683.5	582.0	310.0	168.0	800.0

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт, ой хамгааллын ажлыг эрчимжүүлж өмнөх онтой харьцуулахад үрийн нөөцийг 4.5 дахин, тарьц суулгацын нөөцийг 5 дахин нэмэгдүүлээд байна. 2023 оны байдлаар 41.5 сая мод тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж, 12.1 тонн үрийн нөөцийг бүрдүүлсэн. Ингэснээр 39 төрлийн 291.7 сая ширхэг тарьц, суулгац ургуулах боломжийг бүрдүүлсэн. Улсын хэмжээнд 452 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж, 124 зүйлийн 62.9 сая ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүллээ Энэ нь өмнөх жилийнхтэй харьцуулахад 20 гаруй хувиар өссөн үзүүлэлт юм.

Хөрс хамгаалал: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дулааны улирлын хур тунадасны хэмжээ ихээхэн буурч хуурайших, гандуу болох, цөлжих, газрын доройтол нэмэгдэх, хөрс үржил шимээ алдах явц илүү эрчимжих болсон. Сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд манай орны агаарын жилийн дундаж температур 2.46 градусаар дулаарч, хур тунадас ялимгүй нэмэгдэж байгаа боловч, хуурай үеийн үргэлжлэх хугацаа уртсаж байна.

2020 онд хийсэн цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай бүхий газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Үүний 23 хувь буюу 30 орчим сая га талбай цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна. Говь, хээрийн бүсийн хур тунадас багатай Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгийн нийт нутаг дэвсгэрийн 50-95 хүртэл хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн судалгааны дүн байна.

Хүснэгт 17. Цөлжилтийн үйл явцын хандлага (хувь)

Цөлжилтийн үнэлгээ хийсэн он	Сул илэрсэн нутаг	Дунд зэрэг илэрсэн нутаг	Хүчтэй илэрсэн нутаг	Нэн хүчтэй илэрсэн нутаг	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
2006	23.0	26.0	18.0	5.0	72.0

2010	35.3	25.9	6.7	9.9	77.8
2015	24.1	29.8	16.8	6.1	76.8
2020	31.5	22.1	18.6	4.7	76.9

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Сүүлийн 30 жилд мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрч байгаа нь цөлжилтийн үндсэн шалтгааны нэг болсон. Уул уурхай эрчимтэй хөгжиж үүнтэй холбоотой эвдэрсэн газрын тоо хэмжээ нэмэгдэж байна. 2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд улсын хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нийт 3,488.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 463.7 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Хог хаягдал: Монгол Улсын хэмжээнд цуглуулж, тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээ 2021 онд 2,402.5 мянган тонн байсан бол 2022 онд 2,496.5 мянган тонн болж, 3.9 хувиар нэмэгдсэн байна. Энгийн хатуу хог хаягдлын 63.3 хувийг өрхийн хог хаягдал, 36.7 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, зам талбай, бусад газраас цуглуулсан хог хаягдал эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 4 дүгээр албан даалгавраар "Эрүүл аюулгүй-цэвэр орчин" бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд 21 аймаг, 330 сумын төв, улсын тусгай хамгаалалттай газар, усны сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүс орчмоос нийт 1,200 тонн ил задгай хог хаягдлыг цэвэрлэж зайлуулсан. Уул овооны болон усны сав газар, авто замын дагуух газрыг 21 аймаг 330 сумын 5,274 иргэн, 75 албан байгууллага, аж ахуйн нэгжийг нийт 443.8 км зайд 5,326.1 тонн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж төвлөрсөн хогийн цэгт 23 авто машинаар зөөвөрлөх ажлыг зохион байгуулсан байна.

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 41-т "Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл" тусгагдан билээ. Үүний дагуу Засгийн газрын 2022 оны 377 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" Концессын төрлөөр худалдан авах ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгасан.

Цаг уур, орчны хяналт шинжилгээ: Манай оронд сүүлийн 10 жилийн хугацаанд нийт 45,135 аюулт үзэгдэл, осол тохиолдож, 4,035 хүний амь нас эрсдэж, 3,748.3 мянган толгой мал хорогдон 474.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. 2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 4,484 удаа аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 320 хүн амь насаа алдаж, 560.2 мянган толгой мал, амьтан хорогдож, 52.1 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.

Өнөөдрийн байдлаар ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээнд 318 цаг уурын өртөө, харуул ажиллаж байгаагаас зөвхөн 180 орчим нь цаг уурын автомат станц ашиглаж байгаа бөгөөд төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж үлдэж буй 150 орчим өртөө, харуулд цаг уурын автомат станц худалдан авч ашиглах боломжгүй байна. Энэ байдал нь цаг уурын үзүүлэлтүүдийн ажиглалт, хэмжлийг тасралтгүй хийх боломжгүй болж, урт хугацааны цаг уурын анхан шатны хэмжлийн мэдээний цуваа тасарч, уур амьсгалын өөрчлөлт, хэт халалт, хөрөлтийг хэмжихгүй өнгөрөх, уур амьсгалын дулаарлыг тооцоолох судалгаа, шинжилгээний ажлыг хийх боломжгүй болох нөхцөлийг бий болгож байгаа

төдийгүй цаг агаарын төрөл бүрийн урьдчилсан мэдээний таарцад сөргөөр нөлөөлж байна.

2023 оныг “Цаг уур, орчны шинжилгээний салбарын жил” болгон зарлаж салбарын техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт, албан хаагчдын нийгмийн баталгаа, цалин, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж, Дундговь, Өвөрхангай аймгууд, Улаанбаатар хотод нийт 20 ш автомат станц суурилуулсан. Мөн цаг уурын горимын мэдээний цахим системийг бий болгож, Цаг уур, орчны шинжилгээний газрын архив мэдээллийн сангийн 21 аймаг, 130 гаруй сумын, 1985 оноос хойш хугацааны бүрэн шалгагдсан ажиглалтын мэдээг цахим хуудсаар дамжуулан хурдан шуурхай, хялбар байдлаар авах боломжийг бүрдүүлж, 1,893 албан хаагчийн цалин, нэмэгдэл, хөлсийг 20-46 хувиар буюу сүүлийн 5 жилтэй харьцуулахад нийт цалингийн санг 2.5 дахин нэмэгдүүлээ.

1.2.15. Батлан хамгаалах

Батлан хамгаалахын багц хуулиудыг 2016 оноос эхлэн шинэчилж ирсэн бөгөөд 2023 онд “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг батлуулан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажил тасралтгүй хийгдэж байна. Мөн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын эрх зүйн шинэчлэлийг цаашид үргэлжлүүлэн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан хууль тогтоомжуудаас Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай (шинэчилсэн найруулга)” зэрэг хуулийн төслүүдийг батлуулахаар ажиллаж байна.

Түүнчлэн 2023 онд Монгол Улсын Засгийн газрын 2003 оны тогтоолоор “Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө”, “Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар”-ыг анх удаа батлуулснаас хойш 20 жилийн дараа шинэчлэн боловсруулж, Засгийн газраар батлуулсан.

2023 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн түвшинд 6 хууль дүрэм журам, Үндэсний аюулгүй байдлын түвшинд 6 дүрэм, журам, Улсын Их Хурлын 3 дүрэм, журам, Засгийн газрын түвшинд 15 орчим журмыг батлуулан хэрэгжүүлж байгаа бол Батлан хамгаалахын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Төрлийн цэргийн командлагч нарын тушаалаар Зэвсэгт хүчний хэмжээнд дагаж мөрдөх 31 дүрэм, журам, зааврыг батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх: Өнөөдөр дэлхий, бүс нутгийн хэмжээнд цэрэг, улс төрийн нөхцөл байдал тогтворгүй, хурцадмал байдалтай, цар тахлаас үүдэлтэй хямрал бүрэн арилаагүй, ОХУ-ын Украйнд явуулж байгаа цэргийн тусгай ажиллагаанаас улбаатай улс орнуудын эдийн засаг, нийгмийн орчинд олон бэрхшээлтэй асуудлуудыг бий болгож байгаагийн зэрэгцээ Монгол Улсын аюулгүй байдлын орчин, нийгэм, эдийн засагт ч шууд болон дам байдлаар нөлөөлж байна.

Өнөөгийн байдлаар зэвсэгт хүчний төрлийн цэргийг бие даалгах, хөгжүүлэх үүднээс 2019 онд Хуурай замын цэргийн командлалыг Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт шилжүүлэн байрлуулсан бол 2023 онд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалыг “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын байрлалд шилжүүлэн байрлуулаад байна

Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хүрээнд нийт 48 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх хүрээнд нийт 53 ажил, арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний Туршилт, судалгааны төвүүдийг түшиглэн, тэдгээрийг чадавхжуулж, батлан хамгаалахын аж үйлдвэрийн суурийг амжилттай тавьснаар батлан хамгаалах эрх ашигт нийцсэн цэргийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх суурь тавигдсан.

Монгол Улсын аюулгүй байдлыг цэрэг-улс төр, дипломатын аргаар хангах бодлогын хүрээнд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, өнөөдрийн байдлаар 39 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Үүнээс 5 улстай (ОХУ, БНХАУ, Украин, Беларусь, Бүгд Найрамдах Турк Улс) нь цэрэг-техникийн хамтын ажиллагаатай байна.

Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах зорилтын хүрээнд 2018-2023 онд нийт 236.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий зэвсэглэл, цэргийн болон тусгай зориулалттай техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг буцалтгүй тусламжийн шугамаар авсан байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь 22 жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах болон эвслийн цэргийн ажиллагаанд давхардсан тоогоор нийт 22,000 гаруй цэргийн алба хаагч оролцож, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн энх тайван, бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулав.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Түргэн байрлах хүчний рот”, “Инженерийн рот”, “Цэргийн хээрийн II шатны эмнэлэг”-ийн үндсэн болон өөрийгөө хангах техник, тоног төхөөрөмж, бэлэн байдал, сургалтын түвшнийг НҮБ-ын “Үнэлгээ зөвлөмжийн үзлэг”-т шалгуулж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чадавхын бэлэн байдлын системийн 2 дугаар түвшинд гаргаад байна.

Барилга-инженерийн цэргийн ангиуд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрөл, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар 2023 онд Улсын болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн барилга угсралт, засварын ажил, Өмнөговь аймгийн хилийн Гашуунсухайт боомтод хэрэгжиж буй “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах төсөл”, Говь-Алтай аймагт хийгдэж буй зам засварын ажлуудыг гүйцэтгэсэн.

Дээрхээс гадна улс орны хэмжээнд ургац хураалтын ажилд 2,300 гаруй цэргийн алба хаагчийг оролцуулж, “Тавантолгой түлш” ТӨҮГ-ын түүхий эдийг тээвэрлэх ажилд 190 орчим цэргийн алба хаагч, 58 нэгж өөрөө буулгагч автомашиныг үүрэг гүйцэтгүүлж, “Хөвсгөл нуур”-ын экосистемийг хамгаалах, тэнцвэржүүлэхэд гол үүрэгтэй оролцлоо.

Үүний зэрэгцээ цөлжилттэй тэмцэх, экологийн үйлсэд Зэвсэгт хүчний алба хаагчдыг оролцуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд батлан хамгаалах салбар нэгдэж, 2030 он гэхэд 27 сая гаруй модыг тарьж ургуулахаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

1.2.17. Хууль зүй, дотоод хэрэг

Хууль зүй, дотоод хэргийн салбар нь нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, шударга, хүртээмжтэй хүргэх, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгоход чиглэсэн багц хуулийн төслүүдийг боловсруулан 2023 онд Улсын Их Хурлаар батлуулсан. Тухайлбал:

- Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай,
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль зэрэг болно.

Цагдаа: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.

Төр захиргааны байгууллагуудын ажилтан, алба хаагч, их, дээд, ерөнхий боловсролын сургуулийн багш, ахлах ангийн сурагчдын эцэг, эх асран хамгаалагч нарт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ойлголт, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга” сэдвээр 790 удаагийн сургалт, мэдээллийн ажлыг танхимаар зохион байгуулж, 60.2 мянга орчим хүнийг хамруулсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, тэдний эцэг эх, багш нийгмийн ажилтнуудад сургалт, мэдээлэл өгөх чиглэлээр улсын хэмжээнд “Анзаар” арга хэмжээг зохион байгуулав.

Цахим орчин /вэбсайт, facebook, twitter/-д нийтлэгдсэн мэдээ, мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх “Кудос” системийг нэвтрүүлснээр цахим орчинд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэлд иргэдийн эерэг, сөрөг хандлагыг тодорхойлох боломжтой болсон.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэргийн статистик мэдээллийн тоо, нөхцөл байдалд орон зайн дүн шинжилгээ хийж, “Системийн динамик загвар”-аар нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэтийн төлөвийг 2045 он хүртэлх хугацаагаар тодорхойлж, дүн шинжилгээний ажилд ашиглаж байна.

Зайнаас тандан судлах арга буюу сансрын хиймэл дагуулын суурь зургийг ашиглан хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг илрүүлэх зорилгоор өндөр нарийвчлал бүхий АНУ-ын Махаг, BlackSky хиймэл дагуулын байр зүйн зургуудыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй 312 аж ахуйн нэгжийн ашиглалтын 43105 га талбайд хяналт, шинжилгээ хийж, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн хууль бусаар ашигт малтмал олборлосон 9 аж ахуйн нэгжийн 129 га талбайг илрүүлж, мөрдөн шалгах ажиллагааг явуулж шийдвэрлүүлсэн.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд төв архиваас иргэд, алба хаагчдад олгож байгаа 2 багц 7 төрлийн лавлагаа, үйлчилгээг төрийн үйлчилгээний “eMongolia” нэгдсэн системд холбох хөгжүүлэлтийг хийснээр цагдаагийн байгууллагаас нийт 27 төрлийн лавлагаа, үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.

Эрүүгийн хэргийг цахимжуулах, мөрдөн шалгах эрх бүхий алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, цаг хугацаа хэмнэх зорилгоор цагдаагийн байгууллагаас Төрийн үйлчилгээний нэгдсэн “eMongolia” системээс цагдаагийн эрх бүхий алба хаагч 90 төрлийн лавлагаа, мэдээллийг авч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашиглах боломжтой болж, цаг хугацаа хэмнэж, эрүүгийн хэргийг шуурхай, бүрэн гүйцэд явуулах нөхцөл бүрдсэн.

Хил хамгаалах: Монгол Улс нь 8,252.6 км урт хилийн шугамтайгаас 7,351.6 км хуурай газрын, 901.058 км усан хилтэй. ОХУ-тай 3,543 км, БНХАУ-тай 4,709.6 км хэсгээр хиллэдэг.

Хилийн 24 боомт ажиллаж, 184 орны 5.3 сая зорчигч, 89 орны 5.2 сая тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж, өмнөх оноос зорчигч 2.6, тээврийн хэрэгсэл 1.9 дахин тус тус өссөн. Чингис хаан, Замын-Үүд, Сүхбаатар, Боршоо боомтуудыг өргөтгөн шинэчилж, хилийн Алтанбулаг, Гашуунсухайт, Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Шалган нэвтрүүлэх албанд ашиглах “Гэрэгэ-24” системийг хөгжүүлж, “Чингис хаан” олон улсын агаарын боомтод E-Gate цахим гарцыг нэвтрүүлсэн. Хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Хүдэн”-гийн заставын хариуцсан хэсэг болон “Боршоо” боомтод 52 км шилэн кабелийг татан, “Боршоо” боомтод 12 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, дохиолол, хяналтын системийг ажиллагаанд оруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх: Монгол Улсын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд чиглэл хариуцсан алба 3, газар 3, хорих анги 21, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 16, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс 6, бусад салбар нэгж 14, нийт 63 нэгжид офицер 1,716, ахлагч 1,644, энгийн 71, нийт 3,431 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хаалттай тусгай нэгж 1, хаалттай дэглэмтэй хорих анги 5, нээлттэй, хаалттай дэглэмтэй хорих анги 8, нээлттэй дэглэмтэй хорих анги 7, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, төрөлжсөн эмнэлэг 1, нэгдсэн эмнэлэг 1, нийт 21 хорих ангид хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Улсын бүртгэл: Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний 67 ширхэг киоск машиныг бүртгэлийн анхан шатны нэгжүүдэд байршуулан, 26 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /eMongolia/ системийн 3.0 шинэ хувилбар нэвтрэхтэй холбоотой дараах сервисүүдийг бэлтгэн гаргалаа. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн дуусах хугацаа 30 хоногийн өмнө мэдэгдэх сервис,
- Гадаад паспортын хүчинтэй хугацаа 180 хоногийн өмнө мэдэгдэх сервис,
- Гадаад паспортын бичиг баримт харуулах хэсгийн сервис.

Иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн Датакард MX2100 хэвлэх төхөөрөмжид шинэ загварын NFC цахим иргэний үнэмлэхийн бэлдэц ашиглан хэрэглээнд нэвтрүүлэх тохиргоог хийж туршсан. Шинээр нийлүүлэгдсэн “Contactless” чиптэй иргэний үнэмлэхийн бэлдцэд бичилт хийх ажлыг бүрэн хангасан.

Шүүх шинжилгээ: Шүүх шинжилгээний чиглэлээр 6 газар, 4 хэлтэс, 21 алба, 8 хэсэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс мэргэжлийн Криминалистикийн шинжилгээний газар, Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, Тусгай шинжилгээний газар, Эдийн засгийн шинжилгээний хэлтэс, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон Захиргаа, удирдлагын газар, Санхүү төлөвлөлт, хангамжийн газар, Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс,

Дүн шинжилгээ, бүртгэлийн хэлтэс гэсэн нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн газраас нотлох баримтыг илрүүлэн бэхжүүлж авах, хэргийн газрын ул мөр, эд мөрийн баримтад үзлэг хийх, мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлтээр криминалистик, шүүх эмнэлэг, тусгай, эдийн засгийн шинжилгээ хийдэг бөгөөд жилдээ 65-69 мянга орчим шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж байна. Тухайлбал:

- Криминалистикийн шинжилгээний чиглэлээр: бичиг судлал, бичиг техник, галт зэвсэг, гарын мөр, мөр судлал, дүр зураг, дүрс бичлэг, дуу авиа, авто техник, тэсрэх төхөөрөмж, компьютер техник, экологийн гэх мэт 12 төрлийн шинжилгээг хийж байна.
- Шүүх эмнэлгийн чиглэлээр: хүний биед гэмтлийн зэрэг тогтоох, бэлгийн холбогдолтой гэмт хэргийн хохирогчид үзлэг хийх, цогцост задлан шинжилгээ хийх, эд эсийн шинжилгээ хийх, нас, хүйс тогтоох, хавтаст хэргийн материалаар болон Эксгумацийн /оршуулсан шарилд/ зэрэг 8 төрлийн шинжилгээг хийж байна.
- Тусгай шинжилгээний чиглэлээр: хими, биологи, физик, ДНХ, бактериологийн гэх мэт 5 төрлийн шинжилгээг хийж байна.
- Эдийн засгийн шинжилгээний чиглэлээр: аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд холбогдох өмчийн болон татварын хэрэг, маргааныг шийдвэрлэх зорилгоор эдийн засгийн шинжилгээ хийж байна.

Түүнчлэн бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийлэлд өртөж болзошгүй хохирогч, түүний бага насны хүүхдийг тус хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д түр буюу 24 цагийн хугацаанд байрлуулан тэдэнд эмнэлгийн туслалцаа үзүүлэхээс гадна хууль, эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч үйлчилдэг.

1.2.18. Гамшгийн эрсдэлийг бууруулж, чадавхыг нэмэгдүүлэх: Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас манай улсад тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын тоо жил бүр нэмэгдэж, нийгэм эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

Манай оронд сүүлийн 10 жилийн хугацаанд 45,135 аюулт үзэгдэл, осол тохиолдож, 4,035 хүний амь эрсдэж 3,748.3 мянган толгой мал хорогдож, 474.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан ба онцгой байдлын байгууллага нь 19,350 хүний амь нас 725.6 тэрбум төгрөгийн эд, хөрөнгийг авран хамгаалсан байна.

2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 4,484 удаа аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 320 хүн амь насаа алдаж, 209 хүн гэмтэж, бэртэн 560.2 мянган толгой мал, амьтан хорогдож, 52.1 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.

Монгол Улсын Онцгой байдлын байгууллага нь аймаг, нийслэлд гал унтраах аврах, 71 анги, Үндэсний аврах бригад, Уул, уурхайн аврах анги, Агаараас эрэн хайх, аврах анги, Ар талын анги, Шатахуун болон хүнсний нөөцийн анги, эрэн хайх, аврах банги, эрэн хайх, аврах 15 салбар, эрэн хайх, аврах 20 бүлэг, Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн 21 анги, салбар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Аврагч биеийн тамир, спортын хороо, Давтан сургалт, сэргээн заслын төв, Онцгой тусгай хувцас, хэрэглэлийн туршилт үйлдвэрлэлийн төв, Эрэлч нохойн сургалтын төв гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын хэмжээнд техник, тоног төхөөрөмжийн хангалт 57 хувь, аврах ажиллагааны багаж, хэрэгсэл 48 хувь, зориулалтын хувцас, хэрэглэл 40 хувь, холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмж 32 хувь, богино долгионы радио станц 36.6 хувь хэт богино радио долгионы станц 32 хувь, сансрын холбооны иридиум утас 48 хувь, гал, түймэр унтраах тусгай тоноглол бүхий автомашин 59.8 хувь, гал унтраах багаж зэвсэглэл 55.3 хувьтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийг баруун, зүүн, хойд, өмнөд, Улаанбаатар гэсэн 5 бүсэд хувааж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг бүсчлэн, бүс дэх төвүүдийг байгуулан, гамшгаас хамгаалах арга хэмжээг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед байгууллагуудын харилцан ажиллагааг жигдрүүлэх, штабын бэлтгэл, ажиллагааны удирдлагын чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “Онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдвээр стратегийн команд штабын сургуулийг нийслэл, 21 аймаг, яам, агентлаг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, олон улсын байгууллагын 2,500 гаруй төлөөлөл оролцуулан зохион байгуулсан.

Батлан хамгаалахын яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн хамтран боловсруулсан ажиллагааны бодлого-төлөвлөгөө, технологийн картын дагуу “Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах, живсэн тээврийн хэрэгслийг илрүүлэх, байршлыг тогтоох, татан гаргах” ажлын хүрээнд Хөвсгөл нуурт 7-55 жил болсон нийт 7 машин, тээврийн хэрэгслийг нуурын 33.4 метрээс 128 метр хүртэлх гүнээс татан гаргаж, нийт 47.7 тонн шатахуун тос, тосолгооны материалын бохирдлыг аюулгүй болгож, Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэж, үүсэж болох эрсдэлийг бууруулсан.

Стандартаар улсын хэмжээнд 169 гал, түймэр унтраах, аврах анги, 108 эрэн хайх, аврах нэгж, 9 нэр төрлийн 140 автомашин байх шаардлагатай юм. Иймд аливаа аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагатай уялдуулан тусгай зориулалтын техник тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэглэлийн хангалтыг сайжруулах, гал унтраах, аврах анги, салбарыг шинээр байгуулах, эрт зарлан, мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх, стратегийн нөөцийн барааг бүрдүүлэх, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

1.2.19. Улаанбаатар хотын авто замын түгжрэл, агаарын бохирдол

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлдэг нийслэл Улаанбаатар хотод 2023 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар нийт хүн амын 47.6 хувь нь оршин сууж, сүүлийн 10 жилийн хүн амын жилийн дундаж өсөлт 2.3 хувь байна. Хүн амын өсөлттэй зэрэгцэн Монгол улсын банкны нийт зээлийн 75.2 хувь, хадгаламжийн 80 хувь, ДНБ-ий 63 хувь нь Улаанбаатар хотод бий болж, Улаанбаатар хотын эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, санхүүгийн салбарын хөгжилд түлхэц өгч байгаа боловч хотын одоогийн дэд бүтэц хэрэгцээг хангах боломжгүй болоод байна.

Улаанбаатар хотод бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн тоо 712.9 мянга ба сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 47.0 мянган тээврийн хэрэгсэл нэмэгдэж, нийслэлийн нийт өрхийн 72.2 хувь нь автомашин эзэмшиж, улсын нийт авто тээврийн хэрэгслийн 56 хувь нь Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнд

оролцож байна. Иргэдийн авто машин эзэмшлийн өсөлттэй харьцуулахад авто замын сүлжээний хүчин чадал сүүлийн 10 жилд ердөө 19 хувиар нэмэгдсэн бол авто замын ачаалал 3 дахин нэмэгдсэн.

Улаанбаатар хотод өдөрт 2,882,317 замын хөдөлгөөний зорчилт хийгддэг ба хотын иргэдийн дийлэнх буюу 83 хувь нь ажил, сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээ авах, албан хэргээ гүйцэлдүүлэх зорилгоор замын хөдөлгөөнд оролцдог ба ингэхдээ 24 хувь нь нийтийн тээврийн хэрэгслээр, 64 хувь нь хувийн машинаар, 11 хувь нь явган болон унадаг дугуйгаар, 1 хувь нь бусад тээврийн хэрэгслээр зорчдог байна.

Автомашины хурдацтай өсөлт, авто замын сүлжээний байдал, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг хүчин зүйлсээс хамааралтай хотын нийт гудамж замын 78 хувь дээр түгжрэл үүсэж, автомашины дундаж хурд 35 км/цагаас 13 км/цаг хүрч буурсан ба замын хөдөлгөөний оргил ачааллын үед 8.9 км/цаг болж байгаа нь явган хүний зорчих хурдтай тэнцэж байна.

Тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцохдоо иргэд дунджаар өдөрт 3 цаг, жилд 33 өдрийг замын түгжрэлд өнгөрөөж, эрүүл мэнд, эдийн засгаараа хохирч байна.

Нийслэлийн хэмжээнд 431.0 мянган өрх амьдарч байгаагаас 53.3 хувь буюу 229.7 мянган өрх нь орон сууцанд, үлдсэн 46.7 хувь буюу 201.3 мянган өрх нь гэр хороололд амьдарч байна.

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, үйлдвэр, орон сууцны хороолол орчмын агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлдог.

Орон нутагт 2023 оны байдлаар агаарын чанарыг хянах 26 (аймгийн төвүүдэд 23, томоохон суурин газар 3) суурин харуул ажиллаж агаар дахь хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2)-ийг хөтөлбөрийн дагуу хоногт 2-3 удаа 20 минутын дунджаар сорьц авч, лабораторид химийн урвалж бодис ашиглан тодорхойлж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрийн хувьд 55.6 хувийг гэр хороолол, 28.9 хувийг автомашин, 15.5 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

2024 оны хүйтний улирал 01 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад PM_{10} тоосонцор 7 мкг/м³-ээр буюу 5 хувиар, хүхэрлэг хий (SO_2) нь 17 мкг/м³-ээр буюу 10 хувиар бага, харин $\text{PM}_{2.5}$ тоосонцор 4 мкг/м³-ээр буюу 4 хувиар, азотын давхар исэл (NO_2) нь 7 мкг/м³-ээр буюу 11 хувиар тус тус их байна.

Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, гэр хорооллын төлөвлөлтгүй тэлэлт, байгаль орчин доройтох, хүрээлэн буй орчны бохирдол нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, үйлчилгээний салбар доголдох зэргээр хот, суурин газарт тулгамддаг асуудал хуримтлагдаж нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байна.

Иймд, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нийгэм болон хууль зүйн баталгааг бүрдүүлэх, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд “Нийслэл

Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль"-ийг батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхээр урт, дунд, богино хугацаанд Улаанбаатар хотын авто замын сүлжээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн чанар хүртээмж, менежментийн тогтолцоог сайжруулах, автобусны чиглэлийг оновчтой болгох, Улаанбаатар Метро төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, дугуйн зам, явган хүний замын цогц төлөвлөлтийг хийх төсөл, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Мөн гэр хорооллоос үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулах хүрээнд Улаанбаатар хотыг олон төвт хот болгон хөгжүүлж, хүн амын нягтаршил суурьшлыг зөв төлөвлөж, гэр хороололд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг ойртуулах дэд төв, орон сууцжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.3. Макро эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Эдийн засгийн өсөлт 2024 онд тогтвортой үргэлжлэхээр байна. Оюутолгойн эрдсийн өндөр агуулгатай гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэж, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэхээр байгаа нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг дэмжихээр хүлээгдэж байна. Мөн уул уурхайн салбарын дам нөлөөгөөр тээврийн салбарын идэвхжил тогтвортой байх бол гадаадын жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүд 2024 оны сүүлийн хагас жилээс аялал жуулчлалын салбарт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Боловсруулах салбарт 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, махны экспортын зохицуулалт хялбаршсан зэрэг нөлөөгөөр уул уурхайн бус, боловсруулах салбаруудын гарц нэмэгдэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшиж болзошгүй байна. Цалин, тэтгэвэр тэтгэмж 2024 оны 2 дугаар улирлаас нэмэгдэж байгаатай холбоотойгоор өрхийн хэрэглээ өсөх хүлээлттэй байна. Дотоод эрэлт, өрхийн хэрэглээ эрчимжсэнээр худалдаа, үйлчилгээний салбарууд эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлэхээр байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ БНХАУ-ын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт гадаад эрэлтийг тэтгэснээр экспортын өсөлт хадгалагдаж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

Гадаад худалдаа: 2024 онд экспорт 17.4 тэрбум ам доллар, импорт 11.3 тэрбум ам долларт хүрч, гадаад худалдаа 6.1 тэрбум ам долларын ашигтай гарах төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ БНХАУ-ын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт гадаад эрэлтийг тэтгэснээр экспортын өсөлт хадгалагдахаар байна. Экспортын голлох бүтээгдэхүүнүүд болох зэсийн баяжмал, газрын тосны дэлхийн зах зээл дэх үнэ өсөхөөр хүлээгдэж байгаа бол коксжих нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурахаар хүлээгдэж байна. Гэсэн хэдий ч нийт нүүрсэнд агуулагдах чанар сайтай баяжуулсан нүүрсний хэмжээ нэмэгдэж байгаагаас гадна Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нүүрс, төмрийн хүдрийн арилжаалж эхэлсэн нь хилийн үнэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Төгрөгийн ханш чангарч, импортын барааны зардал буурах төлөвтэй байгаа ч өрхийн орлого, зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт өндөр хэвээр байх төлөвтэй байгаа нь импортын барааны эрэлтийг өсгөхөөр байна.

Төлбөрийн тэнцэл: Экспортын орлого нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл ашигтай гарахаар хүлээгдэж байна. Засгийн газраас өрийн зохицуулалтын хүрээнд 2024 онд

төлөгдөх хуваарьтай Хуралдай бондын өрийг бүрэн төлж барагдуулснаар дунд хугацааны төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа. Засгийн газрын зүгээс хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэх, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.


Инфляц: Улсын инфляц 2024 оны 2 дугаар сард 7 хувь гарсан бол 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшинд байх төлөвтэй байна. Улаан тэнгист үүсээд буй халдага үргэлжилснээр дэлхийн чингэлэг тээврийн зардал өсөж манай улсын импортын барааны үнийг өсгөх эрсдэлтэй байна. Мөн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор малын зүй бус хорогдол нэмэгдэж нийлүүлэлтийн шалтгаантайгаар махны үнэ нэмэгдэх, хүнсний инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж байна.

ХОЁР. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2025 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА, ТӨСӨӨЛӨЛ³

2.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Дэлхий эдийн засаг сүүлийн 4 жил цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, үнийн өсөлт, мөнгөний хатуу бодлогоос шалтгаалсан санхүүгийн хатуу нөхцөл зэрэг олон сорилтуудтай нүүр туллаа. Ирэх онуудад дэлхийн эдийн засгийн өсөлт тогтворжиж, 2024 онд 3.1 хувь, 2025 онд 3.2 хувь орчимд байна гэж Олон улсын валютын сан төсөөлж байна. Гэсэн хэдий ч геополитикийн тогтворгүй нөхцөл байдал даамжрах, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашрах, үнийн өсөлт төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах, мөнгөний бодлогын төлөв болон өрийн хуримтлалаас шалтгаалан санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

Зураг 38. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, 2024 оны 1-3 дугаар сар

Хүснэгт 18. Улс орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2023	2024	2025
Дэлхий	3.1	3.1	3.2
Хөгжингүй орнууд	1.6	1.5	1.8
АНУ	2.5	2.1	1.7
Евро бүс	0.5	0.9	1.7
Хөгжиж буй орнууд	4.1	4.1	4.2
БНХАУ	5.2	4.6	4.1
ОХУ	3.0	2.6	1.1

Эх сурвалж: "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайлан, ОУВС, 2024 оны 1 дүгээр сар

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2 хувиар өсөж, өсөлтийн түвшин тус улсын Засгийн газрын зорилтот 5 хувиас давлаа. 2023 онд худалдааны эргэлт буурч, залуучуудын ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, инфляц буурсан бол аж үйлдвэрлэлийн салбар өсөж, хэрэглээ нэмэгдсэн нь нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Тус улс эдийн засгийн өсөлтийг дэмжих хүрээнд төсөв, мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлэхийг зэрэгцээ орон сууцны урьдчилгаа, ипотекийн зээлийн хүүг бууруулах, үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч компаниудын зээл, санхүүжилтийг дэмжих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Тус улсын Засгийн газраас 2024 онд эдийн засгийн өсөлт 5 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий 3 хувь, хэрэглээний үнийн өсөлт 3 хувь орчим, ажилгүйдлийн түвшин 5.5 орчим хувьд байх зорилтуудыг зарлаад байна. Харин Олон улсын валютын сан БНХАУ-ын эдийн засгийг 2024 онд 4.6 хувиар, 2025 онд 4.1 хувиар тус тус өснө гэж төсөөлж байна. Ирэх жилүүдэд технологи, уур амьсгалын өөрчлөлт, геополитикийн асуудлуудыг тойрсон дэлхий дахины болон БНХАУ доторх өрнөлүүд тус улсын улс төр, эдийн засгийн төлөвт нөлөөлөхөөр байна.

ОХУ: ОХУ-Украин хоорондын геополитикийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн улс орнууд ОХУ-ын эсрэг үе шаттайгаар эдийн засгийн хориг

³ Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх хэсэгт заасны дагуу макро эдийн засгийн 2025 оны чиг хандлагыг энэ хэсэгт тодорхойлж, төсөөлөл, тооцоог тайлбарлав.

арга хэмжээ авч хэрэгжүүлсэн хэдий ч тус улсын эдийн засаг 2023 онд 3.6 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд цэрэг армийн зардалтай холбоотой төсвийн зардлын тэлэлт, түүхий эдийн өндөр үнэ гол нөлөө үзүүллээ. 2023 онд Европын Холбооны орнуудад хийсэн тус улсын экспортын хэмжээ өмнөх оноос 45 хувиар буурсан байна. Украины дайралттай холбоотой газрын тос шилжүүлэн ачих, тээвэрлэх үйл ажиллагаа түр зогссон, Хар тэнгис дэх далайн шуурганы улмаас ОХУ-ын боомтуудын тээврийн хөдөлгөөн хязгаарлагдмал байгаа нь экспортод сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Олон улсын валютын сан тус улсын эдийн засгийг 2024 онд 2.6 хувиар, 2025 онд 1.1 хувиар өснө гэж төсөөлж байна.

АНУ: Өрхийн хэрэглээ эрчимжиж, экспорт нэмэгдсэн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2023 онд 2.5 хувиар өслөө. Тус улсын инфляц 2023 оны эцэст 3.4 хувь болж буурсан ба АНУ-ын төв банк 2023 оны 7 дугаар сараас хойш бодлогын хүүг 5.25-5.5 хувьд хадгалж байна. Цаашид инфляцын бууралтын эрчим, хөдөлмөрийн зах зээлийн төлөв бодлогын хүүг бууруулах хугацааг тодорхойлохоор байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөө, эрэлтийн бууралтын нөлөөгөөр тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.1 хувь, 2025 онд 1.7 хувь болж саарна гэж Олон улсын валютын сан үзэж байна.

Евро бүс: Эрчим хүчний үнийн шокоос үүдэлтэй инфляц 2023 онд аажмаар саарч оны эцэст 2.9 хувьд болж буурсан ч хэрэглээ хангалттай түвшинд хүрч сэргээгүй, инфляцыг хязгаарлахаар төв банкнуудаас барьж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр бүс нутаг дах хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа суларсан нөлөөгөөр Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтээс доогуур буюу 0.4 хувь байлаа. Бүс нутгийн томоохон эдийн засгуудын нэг ХБНГУ-ын эдийн засаг 2023 онд 0.3 хувиар агшсан байна. Эрчим хүчний үнийн шокийн нөлөө аажмаар саарч, инфляцын бууралт өрхийн хэрэглээг дэмжсэнээр тус бүсийн эдийн засаг 2024 онд 0.9 хувь, 2025 онд 1.7 хувиар өсөн алгуур сэргэнэ гэж Олон улсын валютын сан төсөөлж байна.

2.2. Макро эдийн засгийн 2025 оны төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Засгийн газраас дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтвортой түвшинд хадгалахаар зорьж байна. Оюутолгойн гүний уурхайгаас олборлох зэсийн баяжмалын үйлдвэрлэл болон баяжмал дахь зэс, алтны агууламж нэмэгдэнэ. Мөн нүүрсний олборлолт тогтвортой нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт 2025 онд нэмэгдэхээр байна. 2024 онд хөдөө аж ахуйн салбарт өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг сайн хангаж, цаг агаарын нөхцөл хэвийн байна гэж үзсэнээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2025 онд аажмаар нэмэгдэнэ. Түүнчлэн, дотоодын худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж, цэвэр татварын орлого өссөнөөр эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх төлөвтэй.

Эрчим хүчний салбарт либералчлалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эрчим хүчний салбарын потенциал үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлнэ. Гадаадын жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлж, худалдаа, үйлчилгээний салбар болон бусад салбаруудын идэвхжилд эергээр нөлөөлнө. Үйлдвэрлэлийн зардлыг бууруулах үйлдвэрлэлийн орц, тоног төхөөрөмжийн татвар, тарифын хэмжээг хөнгөлснөөр хөдөө аж ахуй, боловсруулах, уул уурхай гэх мэт салбаруудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эерэг нөлөө үзүүлнэ. Мөн хөрш орнуудтай чөлөөт худалдааны худалдааны хэлэлцээр хийх ажлыг эрчимжүүлж, аж үйлдвэр, боловсруулах салбарын гарцыг нэмэгдүүлнэ.

Гадаад худалдаа: 2025 онд экспорт 19.6 тэрбум ам доллар, импорт 12.5 тэрбум ам долларт хүрч, гадаад худалдаа 7.1 тэрбум ам долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

Монгол Улсын Засгийн газраас гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог өргөжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Импортоор бараа, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой бүх төрлийн гэрээний бүртгэлийг автоматжуулж, бараа нэвтрэх боомтыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр байна. Мөн эдийн засгийн идэвхжил өндөр байж завсрын хэрэглээний бүтээгдэхүүний импорт нэмэгдэж, импортын өсөлтөд голлох нөлөөг үзүүлэхээр байна.

Инфляц: Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд мөчлөг сөрсөн мөнгө, төсвийн бодлого хэрэгжүүлж байна. Экспортын орлогыг нэмэгдүүлэх, валютын бодит орох урсгалыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэж, валютын ханшийн зах зээл тогтворжиж байна. Инфляцын түвшинд дунд хугацаанд буюу 2025-2027 онд Монголбанкны зорилтот түвшин 6 ± 2 интервалд байх төлөвтэй байна.

2.3. Болзошгүй эрсдэлийн тойм

2.3.1. Геополитикийн зөрчлийн хамрах хүрээ тэлж, гүнзгийрэх. Дэлхийн нефть, газрын тосны экспортын 35 орчим хувийг бүрдүүлдэг Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, дэлхийн худалдааны 11 орчим хувь дамжин өнгөрдөг Улаан тэнгист халдлага үргэлжлэх, ОХУ-Украины мөргөлдөөн даамжрах зэрэг нь хүчин зүйлс чингэлэг тээврийн зардлыг нэмэгдүүлж авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй байна. Мөн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт хүнсний ургацад сөргөөр нөлөөлж, дэлхийн хүнсний үнийн өсөлт манай улсын инфляцыг өсгөх эрсдэлтэй байна. Түүнчлэн, 2024 оны 2 дугаар улирлаас цалин, тэтгэвэр нэмэгдэх, “Эрдэнэс Тавантолгой” ХК ногдол ашиг тараахтай холбоотойгоор эрэлтээс өдөөгдсөн инфляц нэмэгдэхээр байна. Мөн зудаас шалтгаалан малын зүй бус хорогдол өндөр байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантайгаар махны үнэ нэмэгдэх, хүнсний инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж байна.

2.3.2. Түүхий эдийн эрэлт, үнэ:

БНХАУ-ын ган, төмөр үйлдвэрлэлийн орц түүхий эдийн хэрэглээ нь Монгол Улсын экспортын эрэлтийг тодорхойлж байна. Түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж байгаа бөгөөд олон улсын байгууллагууд тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд өмнөх оноос саарна гэж төсөөлж байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

2.3.3. Зуд, ган, мал, амьтны өвчин:

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь цаг агаарын таагүй байдал, ган, зудын нөхцөл байдлаас өндөр хамааралтай. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч 2023 онд том малын зүй бүс хорогдол 2010 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрч нэмэгдсэн бөгөөд 2024 оны эхнээс ихэнх нутгаар цас их хэмжээгээр орж, жил дараалсан зуд тохиолдож 3 дугаар сарын 14-ний байдлаар 4.7 сая толгой мал хорогдоод байна. Цаашид зудын эрсдэл нэмэгдэж, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх, ган тохиолдох, малын халдварт өвчин тархах эрсдэлтэй

байна. Улмаар өрхүүдийн орлого буурах, инфляц өсөх, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, хөдөөгөөс хот руу шилжиж ирэх хөдөлгөөн нэмэгдэх, төвлөрөл нэмэгдэх, хөдөө аж ахуйн салбар төсөөллөөс илүү агших эрсдэлтэй байна.

2.3.4. Эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдал:

Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээний 20 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. 2023 оны 12 дугаар сард ОХУ-ын 2 станцад гэмтэл гарснаар Монгол Улс руу нийлүүлэх эрчим хүчийг хязгаарлах тухай мэдэгдэж байсан ба энэ нь манай улсад эрчим хүчний тасалдал үүсэх эрсдэл өндөр байгаа харуулж байна. Мөн манай улсын эрчим хүчний хангамж нь төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна.

2.3.5. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг:

Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөл нь “Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”, “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого”, “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”, “Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Улаанбаатар хотын бүсчлэл- 20 минутын хотын бодлого”, “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” гэсэн бодлогын 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойлж тусгасан.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийн нэгдүгээр бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”-ын хүрээнд гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт уул уурхайн шилжилтийг хийх, боомтын сэргэлт, бүс холбосон таван тойрог замын төслүүдийг хэрэгжүүлж тээвэр, логиستيкийн нэгдсэн сүлжээг бий болгох, эрчим хүчний салбарт бодлогын суурь шинэчлэл хийж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай салбар болгон хөгжүүлэх, дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх бодлого баримтална.

Хоёрдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд үндэсний орон сууцжуулах бодлогыг баялгийн сантай уялдуулан дэмжих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг эрчимжүүлэх, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөхүйц чадвартай төгсөгчдийг бэлтгэх, нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хүн амын бүлэг бүрд зориулан оновчтой хэрэгжүүлэх, соёл, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

Гуравдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”-ын хүрээнд төрийн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглаж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгох, шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбарын хөгжлийг эрчимжүүлэх, хүний эрхийн баталгааг хангах, хараат бус, ил тод шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааг хангах бодлого баримтална.

Дөрөвдүгээр бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого”-ын хүрээнд бизнесийн салбарт төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, төрийн оролцоог хязгаарлах, бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, банк, санхүү, даатгалын салбарын реформыг хэрэгжүүлж, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална.

Тавдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Ногоон хөгжлийн бодлого”-ын хүрээнд ногоон хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих, байгаль орчны тогтвортой байдлыг хангах бодлого баримтална.

Зургаадугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хүрээнд хөрөнгө оруулалт, хөгжлийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар төлөвлөх, бүсийн ялгаатай болон шаталсан татварын эрх зүйн

орчныг бүрдүүлэх, бүсүүдэд эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татваргүй чөлөөт бүсүүдийг ашиглалтад оруулах бодлого баримтална.

Долоодугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Улаанбаатар хотын бүсчлэл-20 минутын хотын бодлого”-ын хүрээнд Улаанбаатар хотын засаглалыг сайжруулж, иргэд нийгмийн үйлчилгээг төвөгшөөлгүй, өөрийн гэрээс “20 МИНУТЫН ЗАЙ”-д авах бололцоог бий болгох, түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах төслүүдийг эрчимжүүлэх бодлого баримтална.

Наймдугаар бодлогын тэргүүлэх чиглэл буюу “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ын хүрээнд “Нэг цонх-Нэгдмэл гадаад бодлого”-ыг үргэлжлүүлэх, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, орчны аюулгүй байдлыг хангаж, хүн, нийгмийн амар тайван орчныг бий болгох бодлого баримтална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр нэгтгэн гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ...
дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтод үндэслэн боловсрууллаа.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд бүрэн тусгаж, хэрэгжүүлнэ.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд эдийн засгийн өсөлтийг 6-аас дээш хувьд тогтвортой хадгалах, Засгийн газар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар төлөвлөж хэрэгжүүлэх, нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах, төсвийн үр ашгийг эрс дээшлүүлж, бодлогын орон зайг нэмэгдүүлнэ.

Монголбанк инфляцыг зорилтот түвшинд тогтвортой хадгалахад мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах, цаашид инфляцын зорилтот түвшнийг үе шаттай бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлэх зарчмыг баримтална.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд тусаагүй төсвийн ерөнхийлөн захирагч болон хөтөлбөрийн үр дүнг сайжруулах үндсэн үйл ажиллагаа болон үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээг төсвийн зардлын хязгаарт багтаан төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолын 2.3-т заасныг үндэслэн 2025 онд “Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх” хүрээнд дараах бодлогын 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойллоо.

Нэг. Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого

- 1.1. Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын зах зээлийг өргөжүүлнэ.
 - 1.1.1. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээр, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулж, экспортын зах зээлийг өргөжүүлнэ.
 - 1.1.2. Гадаад худалдааны процесс, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хялбаршуулан, шаарддаг гэрчилгээ, зөвшөөрөл, бичиг баримтын тоог боломжит хамгийн бага түвшинд хүртэл бууруулж, “Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж, гадаад худалдааг хөнгөвчилнө.

- 1.2. Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.
- 1.2.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд өрнүүлж, аравтын системийн бүтцээр хоршоолохыг дэмжинэ.
- 1.2.2. Хөдөө аж ахуй салбарт малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрд нэмэгдүүлэхийг дэмжинэ.
- 1.2.3. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг олгох эрх зүйн орчныг бий болгоно.
- 1.2.4. Худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.5. Малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг ил, тод болгож, малчдад тайлагнадаг процессыг сайжруулна.
- 1.2.6. Бороо, гадаргын усыг хуримтлуулах жижиг нуур, цөөрмүүд байгуулж, гадаргын усжуулалтын систем хөгжүүлэн, бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.
- 1.2.7. Эрчимжсэн болон хагас эрчимжсэн аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд уялдуулан байгуулахыг бодлогоор дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.
- 1.2.8. Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлан, дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтийг бүсчлэн тогтоож, тогтвортой хадгалах, эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай малын биобэлдмэлийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 1.2.9. Малын чанар, үүлдэр сайжруулах судалгаа, шинжилгээг хувийн хэвшлийн байгууллагуудын зах зээлийн шаардлагатай уялдуулан, бизнесийн зарчмаар хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.10. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан тариалангийн газар, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 1.2.11. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.2.12. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүсчлэн байгуулж иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.
- 1.2.13. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, стандартыг нэмэгдүүлж, эрүүл, чанартай хүнс хэрэглэх тогтолцоог сайжруулна.
- 1.2.14. Хөдөө аж ахуйн салбар дахь татаас, дэмжлэгийг боловсруулах шатны үйлдвэрлэл рүү чиглүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.
- 1.2.15. Худалдааны түнш улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүдийг байгуулж, хөдөө аж ахуйн

- бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.
- 1.2.16. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад худалдааны хориг, хязгаарлалтыг цуцалж, бүх боомтоор экспортолно.
 - 1.2.17. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг хувийн хэвшилд нээлттэй болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, өмчийн олон хэлбэр, өрсөлдөөнийг дэмжинэ.
 - 1.2.18. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
 - 1.2.19. Экспортын баримжаатай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах үйлдвэр технологийн паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.
 - 1.2.20. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хагас болон гүн боловсруулах, инновац, технологи шингэсэн “ЦАГААН АЛТ” хөнгөн үйлдвэрийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт уул уурхайн шилжилтийг хийнэ.
- 1.3.1. Хөрөнгө оруулалтыг татах томоохон орд газруудын тоог нэмэгдүүлэх хүрээнд геологи хайгуулын ажлын цар хүрээг өргөжүүлнэ.
 - 1.3.2. Өндөр технологийн үндсэн түүхий эд болох литий, цахиур болон газрын ховор элементийн орд газруудын төслийг эрчимжүүлэн гадаадын хөрөнгө оруулалт, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.
 - 1.3.3. Ашигт малтмалын салбарын ил тод байдлыг хангаж, уул уурхайн бүх төрлийн бүтээгдэхүүнийг биржээр арилжина.
 - 1.3.4. Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгоно.
 - 1.3.5. Үндэсний баялгийн сангийн тогтолцоог боловсронгуй болгоно.
 - 1.3.6. Байгальд ээлтэй өндөр технологийн уул уурхай болон стратегийн ач холбогдолтой төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулна.
 - 1.3.7. Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах хүнд үйлдвэрүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлнэ. (Газрын тосны үйлдвэр, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэлбэрээр болон ураны олборлолт, хүдрийн баяжмал, барилгын материал).
 - 1.3.8. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг чангатгана.
- 1.4. Боомтын сэргэлт, бүс холбосон таван тойрог замын төслүүдийг хэрэгжүүлж тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бий болгоно.
- 1.4.1. Экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдийг үргэлжлүүлж, экспортын тээврийн ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
 - 1.4.2. Бүсүүдийн хөгжлийг дэмжих аймгийн төв, сумдыг холбосон “ТАВАН ТОЙРОГ” автозамын төсөл хэрэгжүүлнэ.

- 1.4.3. Улс хоорондын ачаа, автотээврийн мэдээллийн нэгдсэн цахим санг олон улсын жишигт хүргэн хөгжүүлнэ.
 - 1.4.4. Төмөр замын тээврийн үнэ, тарифыг зах зээлийн зарчимд нийцсэн, шударга, үр ашигтай болгох бодлого үргэлжлүүлнэ.
 - 1.4.5. Эдийн засгийн хөндлөн, босоо тэнхлэгийн хилийн боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
 - 1.4.6. Идэвхтэй ажиллагаатай боомтын тоог нэмэгдүүлж, ажлын цагийг уртасган, зарим боомтын тээвэрлэлтийг 24 цагийн горимд шилжүүлнэ.
 - 1.4.7. Боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, ачаа тээврийн бүртгэл, гаалийн хяналт шалгалтыг автоматжуулж, рентген, камер, автомат хаалга, автомат жин, шинжилгээний төхөөрөмжийг суурилуулан боомтын "Ухаалаг гарц"-ыг ашиглалтад оруулна.
 - 1.4.8. Аймаг, сумын төвүүдэд хуурай боомт байгуулж, орон нутагт гаалийн бүрдүүлэлт хийдэг болно.
 - 1.4.9. Улаанбаатар, Замын-Үүд, Алтанбулагт ачаа тээврийн нэгдсэн логистикийн төвийг байгуулна.
 - 1.4.10. Шуудан хүргэлтийн тогтолцоог олон улсын түвшинд хүргэж, хүргэлтийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлнэ.
- 1.5. Эрчим хүчний салбарт бодлогын суурь шинэчлэл хийж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай салбар болгон хөгжүүлнэ.
- 1.5.1. Эрчим хүчний өртөг шингэсэн тарифыг үе шаттайгаар бий болгож, салбарыг санхүүгийн хувьд бие даасан салбар болгож, зах зээлийн тогтолцоонд шилжүүлнэ.
 - 1.5.2. Сэргээгдэх эрчим хүчний үр ашигтай тогтолцоог нэвтрүүлж, цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, цаашид экспортлох боломжийг бүрдүүлнэ.
 - 1.5.3. Иргэн, аж ахуйн нэгж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж хэрэглэх, хэрэгцээнээс давсан хэсгийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх, худалдах боломжоор хангана.
 - 1.5.4. Ердийн ачааллын үеийн цахилгааныг хуримтлуулж, оргил ачааллын үед төвийн системд нийлүүлэх төслүүдийг дэмжинэ.
 - 1.5.5. Бие даасан, тархмал дулааны эх үүсвэрийг байгуулж, дулааны өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангана.
 - 1.5.6. Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
 - 1.5.7. Эрчим хүчний дамжуулах, түгээх шугам сүлжээг өргөтгөн шинээр байгуулж, эрчим хүчний найдвартай байдлыг хангана.
- 1.6. Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ.
- 1.6.1. Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүсийг байгуулна.
 - 1.6.2. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг (AR, VR, MR, 3D) ашиглаж, "Цахим соёл II", "Соёлын эрхийн бичиг" системийг нэвтрүүлнэ.

- 1.6.3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ /тусгай сонирхлын, хил орчмын/
- 1.6.4. Монгол орны онцлог, өв уламжлалыг олон улсын экспо, маркетинг, зар сурталчилгаа зэрэг олон төрлийн үйл ажиллагаа, арга хэрэгслээр дамжуулан дэлхийд сурталчилна.
- 1.6.5. Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 1.6.6. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжиж, өөрийн орны иргэд, гадаадын жуулчдад үзүүлэх, борлуулах нөөцтэй болгоно.
- 1.6.7. Агаарын тээврийн либералчлахыг үргэлжлүүлж, орон нутгийн болон олон улсын нислэгийн тоо, чиглэл, давтамжийг нэмэгдүүлнэ.
- 1.6.8. Орон нутгийн Чойбалсан, Ховд, Мөрөн нисэх буудлыг 4C, Гурвансайхан нисэх буудлыг 4D ангиллын болгох төслийг үргэлжлүүлнэ.
- 1.6.9. Визний хөнгөлөлтийг үргэлжлүүлж, түр чөлөөлсөн улсуудын визийг бүрэн чөлөөлнө.
- 1.6.10. Аялал жуулчлалын гол чиглэл, олон улсын авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.6.11. Аялал жуулчлалын авто зам дагуух зорчигч үйлчилгээний цогцолбор, амрах талбайг нэмэгдүүлнэ.
- 1.7. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
 - 1.7.1. Соёлын биет болон биет бус өвийг эдийн засгийн эргэлтэд оруулахад хатуу, зөөлөн дэд бүтэц, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
 - 1.7.2. Өөрийн орны өвөрмөц онцлог, нөөц, олон улсын чиг хандлага, технологийн хөгжилтэй уялдсан, мэдлэгт суурилсан бүтээлийг дэмжиж, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

Хоёр. Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого

- 2.1. Үндэсний орон сууцжуулах бодлогыг баялгийн сантай уялдуулж хэрэгжүүлнэ.
 - 2.1.1. "Миний анхны байр", "Миний түрээсийн байр", "Миний амины сууц", "Миний сонголт орон нутаг", "Миний ажилтан орон сууцтай" багц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана.
 - 2.1.2. Орон нутагт 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгоно.
 - 2.1.3. Нийслэл, орон нутагт ипотекийн санхүүжилтийг хүртээмжтэй болгоно.
- 2.2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг эрчимжүүлнэ.
 - 2.2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, эрт илрүүлгийг эрчимжүүлнэ.

- 2.2.2. Цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэгтгэн уялдуулж, үр ашгийг дээшлүүлнэ. /өвчний түүх, эмчилгээний түүх, эмчийн онош, жорын нэгдсэн өгөгдлийн систем/
 - 2.2.3. Дасгал хөдөлгөөн, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.
 - 2.2.4. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого хэрэгжүүлнэ.
 - 2.2.5. Эрүүл мэндийн даатгалыг багцын системд шилжүүлж, даатгуулагч өөрт хэрэгцээтэй багцыг сонгодог тогтолцоонд шилжинэ.
 - 2.2.6. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан бүс бүрд төрөлжсөн эмнэлэг байгуулна.
 - 2.2.7. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.
 - 2.2.8. Эмийн чанар, үнэ, аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлсэн health.gov.mn цахим системийн хэрэглээг өргөжүүлнэ.
 - 2.2.9. Эмийн чанар баталгаажуулах өндөр технологид суурилсан лавлагаа лаборатори байгуулна.
 - 2.2.10. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, нийтийн биеийн тамирын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 2.2.11. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт ба нөхөн сэргээх төв” барих төслийг эхлүүлнэ.
- 2.3. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөхүйц чадвартай төгсөгчдийг бэлтгэнэ.
- 2.3.1. Боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийж, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудын бүлэг дүүргэлтийг зохистой түвшинд хүртэл бууруулж, тэгш хамран сургах орчныг бүрдүүлнэ.
 - 2.3.2. Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчилж, англи хэлний сургалтыг үе шаттай нэвтрүүлнэ.
 - 2.3.3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролд үе шаттайгаар нэвтрүүлнэ.
 - 2.3.4. Бүх түвшний сургалтын байгууллагын багшийг чадваржуулах, хангалтыг нэмэгдүүлэх багшийн гурван тулгуурт бодлого хэрэгжүүлнэ.
 - 2.3.5. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Коосен, ВТЕС загварын сургалтыг цогц байдлаар үе шаттай нэвтрүүлнэ.
 - 2.3.6. Хөдөлмөрийн зэх зээлийн тоон болон ур чадварын эрэлтэд нийцсэн ажиллах хүчнийг бэлтгэх чиглэлээр салбар дундын дадлагын баазыг томоохон аж ахуй нэгжтэй хамтран байгуулна.
 - 2.3.7. Судалгааны их сургуулийг хөгжүүлж, судалгаа, шинжилгээний бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулна.

- 2.3.8. Хот хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр цахим шилжилтийг эрчимжүүлнэ.
- 2.4. Нийгмийн баталгааг сайжруулна.
- 2.4.1. Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.
- 2.4.2. Нийгмийн даатгалын тогтолцоог хуримтлалын сангийн тогтолцоонд шилжүүлэх хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн 2 хувийг иргэн бүрийн дансанд мөнгөжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.4.3. Иргэн бүрийн нэрийн дансыг байгалийн баялгийн үр өгөөжөөр мөнгөжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 2.4.4. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулж, сум, хороо бүрд гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын нийгмийн ажилтантай болгоно.
- 2.4.5. Иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.
- 2.4.7. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг нэвтрүүлж, судалгаа суурьтай нийгмийн халамжийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.
- 2.4.8. Малчдын орлогын эх үүсвэртэй уялдуулж, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. НДШ-ийг сар бүр төлөхгүйгээр жилдээ багтаан төлөх, хувааж төлөх, нөхөж төлөх зохицуулалтыг хийнэ.
- 2.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хүн амын бүрд зориулан оновчтой хэрэгжүүлнэ.
- 2.5.1. Халамжийн олон төрлийн бодлогын давхцалыг арилгаж, зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 2.5.2. Зайнаас болон цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийн уян хатан зохицуулалтыг бий болгон иргэн бүр цалин хөлстэй ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.5.3. Ажлын байранд дадлагажих боломжийг нэмэгдүүлэх замаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.5.4. Өндөр настны ажлын байрыг бодлогоор дэмжинэ.
- 2.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийцсэн ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 2.5.6. Оюутны цагаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журмыг сайжруулж, нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх, цагийн ажлын зуучлалыг E-Student цэсээр дамжуулна.
- 2.5.7. Төгсөгчдөд зориулан "Хийнгээ суръя - Орлого олъё - Хэмнээ" загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.
- 2.5.8. Урт хугацаанд ажил завсардсан болон эх орондоо буцаж ирсэн иргэдэд ур чадвар эзэмшүүлэх, мэргэшлийн зэрэг, гэрчилгээ олгох үйл ажиллагааг дэмжинэ.

- 2.5.9. Асрахуйн эдийн засгийн хөгжлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн эко системийг бүрдүүлж, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
 - 2.5.10. Ажлын байрыг шинээр бий болгосон бүс, орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.
 - 2.5.11. Ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулан үйл ажиллагааг нь хялбаршуулж, хүртээмжтэй, ил тод болгоно.
 - 2.5.12. Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.6. Соёл, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.6.1. Үндэсний өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёл шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, эерэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх “Бүх нийтийн соёлын боловсрол-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 2.6.2. Төр-иргэний хамтын ажиллагааны түншлэлд үндэслэн соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварыг хамгаалан, хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлнэ.
 - 2.6.3. Урлагийн бүтээлээр дамжуулан нүүдлийн соёл иргэншилт язгуур урлагийг хадгалан, хамгаалж, хүн төрөлхтний соёлын ололттой хослуулан ижилсэл, ондоошлыг илэрхийлсэн олон улсад өрсөлдөх чадамжтай авьяаслаг, бүтээлч монгол иргэнийг төрөөс дэмжин хөгжүүлж, “Монгол урлаг дэлхийн тайзнаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
 - 2.6.4. Үндэсний түүхэн болон уран барилгын дурсгалуудыг сэргээн шинэчилж, хамгаалан ирээдүйн үнэ цэнийг бий болгоно.
 - 2.6.5. Спортын өндөр амжилтыг дэмжихэд чиглэсэн спортын арга хэмжээ зохион байгуулна.

**Гурав. Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан
засаглалын бодлого**

- 3.1. Төрийн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглаж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгоно /ухаалаг “E-Mongolia”, AI шинэчлэл – Цахим засаглал/.
- 3.1.1. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн шат дамжлагыг бууруулж, иргэд, бизнест төвөггүй, хялбар үйлчилгээг үзүүлнэ.
- 3.1.2. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хиймэл оюуны тусламжтайгаар хүний оролцоо, хүнд сурталгүй “Ухаалаг E-Mongolia” системийг хөгжүүлнэ.
- 3.1.3. Үндэсний хиймэл дагуул хөөргөх суурь нөхцөлийг бүрдүүлж, нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжинэ.

- 3.1.4. Аж үйлдвэрийн IV дүгээр хувьсгалын технологиудыг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд нэвтрүүлэх суурь судалгааны ажлуудыг санхүүжүүлж, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлнэ /хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, blockchain, ухаалаг бот, IoT/.
 - 3.1.5. Аливаа контентын жинхэнэ эсвэл хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн эсэхийг тодорхойлох, байгууллагын болон иргэдийн нэр хүндэд халдах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийг бий болгоно.
 - 3.1.6. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандартыг иргэн, аж ахуй нэгжид төлбөртэй олгохыг больж, цахимаар нээлттэй, ил тод хүргэнэ.
- 3.2. Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбарын хөгжлийг эрчимжүүлнэ.
- 3.2.1. Мэдээлэл, харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг салбарт өргөнөөр нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
 - 3.2.2. Эрдэмтдийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн оновчтой шийдэл, шинэ бүтээл, оюуны өмч, судалгаа шинжилгээг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжинэ.
 - 3.2.3. Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
 - 3.2.4. Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн үр дүнг практикт нэвтрүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 3.2.5. Үндэсний баялгийн сангийн нэгээс доошгүй хувийг шинжлэх ухаан, инновац технологийн салбарт зориулж, эдийн засгийн салбаруудын бүтээмж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
 - 3.2.6. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
 - 3.2.7. Хил дамнасан онлайн худалдаа эрхлэх боломжийг бүрдүүлж, олон улсын төлбөр тооцооны нөхцөлийг сайжруулна /“Apple pay”, “Google pay”, “Paypal”, “Stripe”/.
- 3.3. Хүний эрхийн баталгааг хангана.
- 3.3.1. Ази тивийн хүний эрхийн төвийг Монгол Улсад байгуулна.
 - 3.3.2. Цахим орчин дахь ялгаварлал, хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулж, хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.
 - 3.3.3. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
 - 3.3.4. Төрийн шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн аливаа шийдвэр гаргахгүй.

- 3.3.5. Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт шалгалт хийх “Нээлттэй сонсгол”-ыг тогтмол зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.
 - 3.3.6. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
 - 3.3.7. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ.
 - 3.3.8. Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны орчин нөхцөлийг сайжруулна.
- 3.4. Хараат бус, ил тод шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.
- 3.4.1. Шүүхийн процессыг цахимжуулж, хэрэг хянан шийдвэрлэх явцыг ил тод болгож, маргааныг түргэн шуурхай, үнэн зөв шийдвэрлэдэг болгоно.
 - 3.4.2. Шүүхийн дата төвийн хүчин чадлыг сайжруулна.
 - 3.4.3. Шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын дундын төв байгуулна.
 - 3.4.4. Шүүхийн байгууллагыг шаардлагатай дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангана.
 - 3.4.5. Шүүхийн байрыг стандартад нийцүүлнэ.
 - 3.4.6. Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.
 - 3.4.7. Иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бүтээмжтэй, үр нөлөөтэй анхан болон давж заалдах шатны шүүх байгуулна.
 - 3.4.8. Ерөнхий прокурорын газрын дэргэдэх мөрдөн шалгах тусгай нэгжийг сэргээж, шүүгч, прокурор, мөрдөгч, цагдаа зэрэг тусгай субъектийг шалгах тогтолцоог бүрдүүлнэ.
 - 3.4.9. 5Ш ажиллагааг үргэлжлүүлж, авлигачдын төр, нийгэмд учруулсан хохирлыг эргэн төлүүлж, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шууд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
 - 3.4.10. Авлигыг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, мэдээлэгчийн эрхийг хамгаалах, учирсан хохирлыг төлүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.
 - 3.4.11. Бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлнэ.
 - 3.4.12. Санхүүгийн хориг, арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт, Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохоос сэргийлж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр хадгалж, сайжруулна.
- 3.5. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааг хангана.
- 3.5.1. Төрийн албаны хүний нөөцийн менежментийг сайжруулна.

- 3.5.2. Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлнэ.
- 3.5.3. Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ.

Дөрөв. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого

- 4.1. Бизнесийн салбарт төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, төрийн оролцоог хязгаарлана.
 - 4.1.1. Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглаж хүний оролцоо, хүнд суртлыг арилгана.
 - 4.1.2. Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.
 - 4.1.3. Төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг тогтоож, иргэн, аж ахуйн нэгж бизнес, хөрөнгө оруулалтаа төлөвлөх боломжийг нэмэгдүүлнэ.
 - 4.1.4. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, үр өгөөжийг сайжруулж, олон улсын чанарын стандартыг нэвтрүүлэн, үе шаттайгаар хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж ил тод, олон нийтийн болгоно.
- 4.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлнэ.
 - 4.2.1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, эдийн засгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.
 - 4.2.2. Засгийн газрын өрийн зохистой түвшний үзүүлэлтүүдийг тогтмол хадгалж, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх замаар хувийн хэвшилд олон улсын зах зээлээс хямд өртөгтэй эх үүсвэр татах боломжийг олгоно.
 - 4.2.3. Бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг тогтворжуулна.
 - 4.2.4. Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах механизмыг тогтворжуулна
- 4.3. Банк, санхүү, даатгалын салбарын реформыг хэрэгжүүлж зээлийн хүүг бууруулна.
 - 4.3.1. Банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж, иргэд, хувийн хэвшилд олгох зээлийн хүүг бууруулна.
 - 4.3.2. Гаднын хөрөнгө оруулалттай урт хугацааны даатгалын компаниудыг дэмжиж, давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, даатгалын зах зээлийг өргөжүүлнэ.
 - 4.3.3. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулах хүрээнд даатгалын салбарын хууль эрх зүйн реформыг хийж, технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлнэ.
 - 4.3.4. Санхүүгийн салбарт санхүүгийн систем, дижитал төлбөр тооцоо, бизнесийн үйлчилгээг дэмжих шийдлүүдийг нэвтрүүлнэ.

Тав. Ногоон хөгжлийн бодлого

- 5.1. Ногоон хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжинэ
 - 5.1.1. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлнэ.
 - 5.1.2. Хүлэмжийн хийг бууруулах стратегийг утаа, эрчим хүч, өрхийн халаалтын шийдэл, цөлжилт зэрэг тулгамдсан асуудлууд руу чиглүүлж, олон улсын байгууллагуудаас санхүүжилт татаж, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
 - 5.1.3. Үндэсний хэмжээнд хүлэмжийн хийн тооллогыг хийх аргазүйг сайжруулна.
 - 5.1.4. Байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай үйлдвэр, технологийг хөгжүүлэн, ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
 - 5.1.5. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц, дэд бүтцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 5.1.6. Ногоон хэрэглээг нэмэгдүүлэх бодит хөшүүргүүдийг үе шаттай бий болгож, төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад шилжүүлнэ
- 5.2. Байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангана
 - 5.2.1. Зүүн Азийн улс орнуудтай хамтран “Шар шороон шуурга”-ны нүүдлийг зогсоох, цөлжилтийн эсрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 5.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлнэ.
 - 5.2.3. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомсдол, доройтлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
 - 5.2.4. Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.
 - 5.2.5. Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ
 - 5.2.6. Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах 14 хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, үйлдвэрлэлийн ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 5.2.7. Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.
 - 5.2.8. Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.
 - 5.2.9. Гэрээний дагуу даацаа хэтрүүлээгүй, зөв зохистой маллаж, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

- 5.2.10. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 5.2.11. Биологийн олон янз байдлыг хамгаална.

Зургаа. Бүсчилсэн хөгжлийн бодлого

- 6.1 Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.
 - 6.1.1 Орон нутгийн хөрөнгө оруулалт болон хөгжлийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилан төлөвлөж, эдийн засгийн баталгааг хангах томоохон мега төслүүдийг эхлүүлнэ.
 - 6.1.2 Бүсчилсэн хөгжлийн хүрээнд бүсийн ялгаатай болон шаталсан татварын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
 - 6.1.3 Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан бизнесийн ААНОАТ-ыг 5 хувь болгоно.
 - 6.1.4 Бүс нутгийн эдийн засгийн төрөлжилтөд нийцсэн экспортын хөнгөн үйлдвэрийн кластерыг хөгжүүлж, орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой болгоно.
 - 6.1.5 Бүс, орон нутгийн үйлдвэрлэлийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжиж, боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг импортоор оруулж ирэхэд татвараас хөнгөлнө.
 - 6.1.6 Эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт зэрэг хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлж, газар олгох, дэд бүтэцтэй холбох асуудлыг төр хариуцна.
 - 6.1.7 Олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр холбогдож, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
 - 6.1.8 Бүсүүдэд эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татваргүй чөлөөт бүсүүдийг ашиглалтад оруулна.
- 6.2 Орон нутгийг байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурлан дараах тэргүүлэх чиглэлээр бүсчлэн хөгжүүлнэ.

Зүүн бүсийн тэргүүлэх чиглэл: Дэлхийн байгалийн өв болох Дагуурын ландшафт болон Хан Хэнтий, Дорнод Монголын талын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж чадсан, байгальд ээлтэй ногоон технологи бүхий уламжлалт ба эрчимжсэн хөдөө аж ахуй, түүх соёлын өвд суурилсан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэл, өндөр технологид суурилсан хариуцлагатай уул уурхай, хүнд аж үйлдвэрлэлийн бааз суурь бүрэлдсэн, зүүн хойд азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоотой, тээвэр логиستيкийн цогц систем бүхий, шинжлэх ухаан, инновацын төвийг хөгжүүлсэн бүс нутаг болж хөгжсөн байна.

Говийн бүсийн тэргүүлэх чиглэл: Тээвэр-логиستيкийн сүлжээ, зангилаа бүрдүүлэх замаар хөрш орны эрчимтэй хөгжиж буй бүс нутгуудтай эдийн засгийн интеграцид нэгдэнэ. Говийн бүсийн байгаль, түүх соёл, палеонтологийн үнэт өв сангийн бүрэн бүтэн

байдлыг хадгалж, өндөр технологи, инновацад суурилсан, хариуцлагатай уул уурхай, орчин үеийн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлснээр үндэсний хуримтлал, баялгийн санг бүрдүүлэгч гол бүс нутаг болно.

Хангайн бүсийн тэргүүлэх чиглэл: Байгаль, түүх соёл, археологийн үнэт өв санд тулгуурласан аялал жуулчлал, амралт рашаан сувилал, ногоон технологи бүхий уламжлалт ба эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн кластер хөгжүүлнэ. Дэлхийн соёлын өв болсон Орхоны хөндийд Монгол Улсын улс төр засаг захиргааны шинэ төв - Шинэ Хархорум хотыг байгуулна. Шинэ Хархорум хотод сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хотхоныг байгуулна.

Баруун бүсийн тэргүүлэх чиглэл: Байгалийн унаган төрх, олон үндэстэн ястны түүх, ахуй соёлын баялаг өв санд тулгуурласан эко ба тусгай сонирхлын аялал жуулчлал, байгальд ээлтэй ногоон технологид суурилсан уламжлалт мал аж ахуй, түүхий эдэд суурилсан үйлдвэрлэл, жимс жимсгэнийн тариалан, боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлнэ. Төв азийн эдийн засгийн хамтын ажиллагааны идэвхтэй оролцоотой, дорно-өрнийг холбосон олон улсын тээвэр логистикийн зангилаа, хил орчмын худалдаа, үйлчилгээг хөгжүүлсэн бүс болгон хөгжүүлнэ.

Хойд бүсийн тэргүүлэх чиглэл: Дэлхийн шим мандлын сүлжээний бүрэлдэхүүн-Хөвсгөл нуур, Сэлэнгийн савын эко системийн байгалийн унаган төрх, түүх, ахуй соёлын баялаг өв санд тулгуурласан, эко ба өвлийн аялал жуулчлал, амралт сувиллын кластер, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлсэн бүс болгон хөгжүүлнэ. Орчин үеийн өндөр технологийн хот Эрдэнэт хотыг хөгжүүлнэ.

Төвийн бүсийн тэргүүлэх чиглэл: Төвийн бүсийг Ази-Европын эдийн засаг, соёл, байгаль орчны асуудлуудад чухал үүрэгтэй, олон улсын эдийн засгийн коридор, тэнхлэг бүхий, хүн ам, нийгэм эдийн засгийн хэт төвлөрлийг саармагжуулсан, шинжлэх ухаан, инновац, мэдлэгт суурилсан эдийн засгийн бүтэцтэй, хүнс, хөнгөн, хүнд үйлдвэрлэлийн кластер хөгжүүлнэ.

Долоо. Улаанбаатар хотын бүсчлэл- 20 минутын хотын бодлого

7.1. Улаанбаатар хотын засаглалыг сайжруулна.

7.1.1. Одоогийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэхгүйгээр 9 дүүрэг, 213 хороог хүн амын зохистой харьцаа, төвлөрлийг харгалзан шинэчлэн зохион байгуулах замаар Улаанбаатар хотын Бага тойрууд төвлөрсөн төрийн үйлчилгээг анхан шатны 42 нэгжид бүсчлэн байршуулж, иргэдийн нийгмийн үйлчилгээг “20 МИНУТЫН ЗАЙ”-д багтаан авдаг стандарт бүхий цогц реформыг хэрэгжүүлнэ.

- 7.1.2. Хотын стандарт, хот төлөвлөлтийн хуулийг шинэчлэн баталж, хот төлөвлөлтийн дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хуулийн хариуцлагыг чангатгана.
- 7.1.3. Нийслэлийн Засаг дарга болон Улаанбаатар хотын Захирагчийн чиг үүргийг зааглана.
- 7.1.4. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг дүүрэг бүрд байгуулна.
- 7.1.5. Хууль бусаар олгосон газрыг төрд буцаан авах, нийтийн эзэмшлийн газар, талбайд зөвшөөрөлгүй барьсан байгууламжийг буулгах ажлыг үргэлжлүүлж, уг газарт ногоон байгууламж барина.
- 7.1.6. Алхах, дугуй унахад аюулгүй тав, тухтай байдлыг хангах, хотын хөдөлгөөн хязгаарлаж буй хашаа, хаалтуудыг үргэлжлүүлэн буулгана.
- 7.1.7. Гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэл гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай шинэчлэл хийнэ.
- 7.1.8. Улаанбаатар хотын төв, хүм ам ихээр төвлөрсөн бүсүүдээр аюултай ачаа тээвэрлэхгүй байх зохицуулалтыг хийнэ.
- 7.2. Түгжрэлийг бууруулна.
 - 7.2.1. Улаанбаатар хотын автозамын сүлжээний ачааллыг бууруулж, Туулын авто замыг Нисэхийн хурдны автозамтай холбож наадамчдын автозам дээгүүр гүүрэн байгууламж барина.
 - 7.2.2. Сэлбэ-Сэргэлт төслийг хэрэгжүүлэх, явган хүний замын бүрэн төлөвлөлтийг хийх замаар авто замын ачааллыг бууруулна.
 - 7.2.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоо, нийтийн тээврийн чиглэл, хуваарилалтыг бүрэн оновчтой болгоно.
 - 7.2.4. Метро буюу их багтаамжтай нийтийн тээврийн бүтээн байгуулалтын төслийг эхлүүлнэ.
 - 7.2.5. Хотын бүх чиглэлд дугуйн замыг шинээр барих ажлыг эхлүүлнэ.
 - 7.2.6. Нийслэлийн замын хөдөлгөөний иж бүрэн ухаалаг системийг нэвтрүүлж, хотын гэрлэн дохионы удирдлага менежментийг ухаалаг системд шилжүүлнэ.
- 7.3. Төвлөрлийг сааруулж, агаарын бохирдлыг бууруулна.
 - 7.3.1. Шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжин төвлөрлийг сааруулна.
 - 7.3.2. Хөшгийн хөндийн дагуул хотод төрийн байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангана.
 - 7.3.3. Гэр хорооллыг орон сууцжуулах, цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг байгуулна. /Сонгинохайрхан, Хан-Уул/
 - 7.3.4. Сэлбэ, Баянхошуу дэд төвийн цогц бүтээн байгуулалтын хүрээнд төрийн байгууллага, худалдаа үйлчилгээ, их дээд сургууль, соёл, спортын цогцолборыг байгуулах, шилжүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

- 7.3.5. Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.
- 7.3.6. Хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах ногоон байгууламж, цэцэрлэгтэй болох боломжийг бүрдүүлнэ.
- 7.3.7. Улаанбаатар хотын зүүн болон баруун бүсэд олон улсын ачаа тээврийн терминал, дэд төвүүдэд 50000 тонн багтаамжтай хүнсний агуулах барих төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эхлүүлнэ.

Найм. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх

- 8.1. Нэгдмэл гадаад бодлогыг бэхжүүлнэ.
 - 8.1.1. Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл, залгамж чанарыг хангах “Нэг цонх – Нэгдмэл гадаад бодлого”-ыг үргэлжлүүлнэ.
 - 8.1.2. Хүчирхэг Монгол паспорт: Монгол Улсын иргэд визгүй зорчих улсын тоог нэмэгдүүлнэ.
 - 8.1.3. Бусад улстай хоёр талт болон олон талт олон улсын гэрээ байгуулах замаар хилийн чанадад зорчих иргэдийн визийн нөхцөлийг хөнгөвчилнө.
- 8.2. Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.
 - 8.2.1. Цэргийн зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хүрээнд батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн зэвсэг, техникийг дотооддоо үйлдвэрлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 8.2.2. Улсаа хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтыг дэмжиж, Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлнэ.
 - 8.2.3. Төрийнхөө энхийг эрхэмлэсэн гадаад бодлогод хувь нэмрээ оруулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах үйлсэд Зэвсэгт хүчний оролцоог тогтвортой хадгална.
 - 8.2.4. Хугацаат цэргийн алба хаах хугацаанд мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 - 8.2.5. Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмыг боловсронгуй болгоно.
 - 8.2.6. Цэрэг, эх оронч үзэлд суурилсан “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах оюутны тоог шат дараатай нэмэгдүүлж, хугацаат цэргийн алба хаах хугацаанд мэргэжил, ур чадвар олгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 - 8.2.7. Монгол Улсын аюулгүйн нөөцийн бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хүнсний болон газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий агуулахын цогцолборыг барина.
- 8.3. Орчны аюулгүй байдлыг хангаж, хүн, нийгмийн амар тайван орчныг бий болгоно.
 - 8.3.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг нэмэгдүүлнэ.
 - 8.3.2. Улсын болон орон нутгийн онцгой комисс нь зөвхөн гамшгийн зэрэглэл тогтоох, үүссэн нөхцөл байдалд гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх стратегийн шийдвэр гаргах,

онцгой байдлын алба, нэгж нь шийдвэр хүлээлгүй төлөвлөгөөг түргэн шуурхай хэрэгжүүлэх тогтолцоонд шилжинэ. Гамшгийн үеийн тушаал, шийдвэр гаргах механизмыг тодорхой болгоно.

- 8.3.3. Онцгой байдлын үеийн бэлэн байдлыг орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан тоног төхөөрөмжөөр хангана.
- 8.3.4. Гамшиг, ослын үеийн бэлэн байдлыг орчин үеийн техник, технологиор бүрэн хангаж, гамшгийн үед аврах чадавхыг бэхжүүлнэ.
- 8.3.5. Улаанбаатар хотын үерийн эрсдэлтэй бүсүүдэд далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн, шинэчилнэ.
- 8.3.6. Хот, суурин газарт хөрс, усны чанарын олон улсын стандартыг нэвтрүүлж, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 8.3.7. Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий цогц эрсдэлийн менежментийг шинэчлэн баталж, үндэсний хэмжээнд мөрдүүлнэ.
- 8.3.8. Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, радарын станц байгуулна.
- 8.3.9. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гаднын сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 8.3.10. Иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах зорилгоор цагдаа, дотоодын цэргийн байгууллагад нисэхийн нэгж байгуулна.
- 8.3.11. Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системийг бий болгоно.
- 8.3.12. Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Хариуцагч
						Суурь түвшин /2023 он/	Зорилгот түвшин /2025 он/	Санхүүжилт, сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ЭДИЙН ЗАСАГ БҮЛГИЙН ХҮРЭЭНД:										
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙН БОДЛОГО.										
1.1. Гадаад худалдаа, экспорт хийх таатай орчин бүрдүүлнэ.	1.1.1. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг хөгжүүлнэ.	АХ-4.1.21, 4.2.33 МУХТЖҮЧ-5.2.3	1.1.1.1. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулах	Бүгд Найрамдах Солонгос Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг шинээр байгуулах арга хэмжээний хэрэгжилт	Хувь	-	100	-	Улсын төсөв	ЭЗХЯ
				Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр шинээр байгуулах арга хэмжээний хэрэгжилт	Хувь	-	100	-	Улсын төсөв	ЭЗХЯ
